

**ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 12 дугаар сарын 02-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-52
1.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатаас Тэтгэврийн зээлийн асуудлаар Монголбанкны Ерөнхийлөгчид хандсан асуулгын хариуг хэлэлцэх	7-45
2.Иргэдээс ирүүлсэн өргөдлийн талаар /Бэрхийн уурхайн нэр бүхий 112 иргэнээс ирүүлсэн өргөдлийн тухай/	45-48
3.Өргөдлийн байнгын хороонд иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийн шийдвэрлэлтийн явцын талаарх мэдээлэл сонсох	48-52

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Өргөдлийн байнгын хорооны
12 дугаар сарын 02-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Өргөдлийн байнгын хорооны дарга О.Номинчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 44 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баттулга, Б.Батцэцэг, С.Ганбаатар, Х.Жангабыл, Л.Мөнхбаясгалан, Ч.Ундрэм, С.Цэнгүүн;

Чөлөөтэй: Г.Лувсанжамц;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнхтуяа;

Тасалсан: Д.Батбаяр, Р.Эрдэнэбүрэн.

Нэг.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатаас Тэтгэврийн зээлийн асуудлаар Монголбанкны Ерөнхийлөгчид хандсан асуулгын хариуг хэлэлцэх

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, мөн банкны Мөнгөний бодлогын газрын Макро зохистой бодлогын хэлтсийн захирал Н.Батболд, мөн газрын Мөнгөний бодлого, төсөөллийн хэлтсийн захирал Н.Ургамалсүвд, Хууль, эрх зүйн газрын захирал Д.Аюуш, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг, Төрийн банкны Хууль, эрх зүй хариуцсан дэд захирал Б.Амарсанаа, мөн банкны Зээлийн газрын захирал Э.Батбаяр, Хаан банкны Бизнес хөгжил хариуцсан дэд захирал С.Энх-Ирээдүй, мөн банкны Ногоон банкны газрын захирал Б.Болортуяа, Голомт банкны Зээлийн бодлогын хэлтсийн захирал Н.Лхагвасүрэн, мөн банкны Иргэдийн бизнес хөгжлийн хэлтсийн ахлах менежер Г.Амарзаяа, Ахмадын холбооны төлөөлөл Ц.Сүхбаатар, Ц.Алтанзул нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Д.Наранцэцэг, референт Г.Нямсүрэн нар байлцав.

Байнгын хорооны дарга О.Номинчимэг Монголбанкны Ерөнхийлөгчид хандан тавьсан асуулгын хариуг тараасан байгаа талаар танилцуулав.

Асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат тэтгэврийн зээлийн асуудлаар үг хэлэв.

Асуулгын хариутай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Замира, Б.Бат-Эрдэнэ, Д.Рэгдэл, Б.Пунсалмаа, П.Мөнхтулга, Ж.Золжаргал, О.Саранчулуун нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Монголбанкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, мөн банкны Мөнгөний бодлогын газрын Макро зохистой бодлогын хэлтсийн захирал Н.Батболд, Хууль, эрх зүйн газрын захирал Д.Аюуш, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг, Төрийн банкны Хууль, эрх зүй хариуцсан дэд захирал Б.Амарсанаа, Хаан банкны Бизнес хөгжил хариуцсан дэд захирал С.Энх-Ирээдүй, Голомт банкны Зээлийн бодлогын хэлтсийн захирал Н.Лхагвасүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, С.Замира, Б.Бат-Эрдэнэ, Ж.Золжаргал, О.Саранчулуун, О.Номинчимэг нар үг хэлэв.

Асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Монголбанкны Ерөнхийлөгчид хандсан асуулгын хариуг хэлэлцэв.

Уг асуудлыг 13 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Иргэдээс ирүүлсэн өргөдлийн талаар /Бэрхийн уурхайн нэр бүхий 112 иргэнээс ирүүлсэн өргөдлийн тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, бодлогын газрын дарга Д.Рэнцэнханд, мөн яамны Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газрын ахлах шинжээч П.Хишигжаргал, Хөдөлмөрийн хяналтын хэлтсийн Хөдөлмөрийн хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн М.Ууганбаяр, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Нэхэмжлэгчдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч П.Алтангэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Д.Наранцэцэг, референт Г.Нямсүрэн нар байлцав.

Байнгын хорооны дарга О.Номинчимэг ирүүлсэн өргөдлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа өргөдлийг судалсан талаар тус тус танилцуулав.

Байнгын хорооны дарга О.Номинчимэг уг асуудлыг хойшлуулав./14:09/

Гурав.Өргөдлийн байнгын хороонд иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийн шийдвэрлэлтийн явцын талаарх мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг, ахмадын холбооны төлөөлөл Ц.Сүхбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Д.Наранцэцэг, референт Г.Нямсүрэн нар байлцав.

Байнгын хорооны дарга О.Номинчимэг Байнгын хороонд ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийн шийдвэрлэлтийн явцын талаарх мэдээллийг Улсын Их Хурлын гишүүдэд хүргүүлсэн талаар мэдэгдэв. /14:13/

Байнгын хорооны дарга О.Номинчимэг ахмад настнуудаас тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлж, цалингийн итгэлцүүрээр тэтгэврийг шинэчлэн тогтооход ахмадуудын тэтгэврийн хэмжээ багассан асуудлаар иргэдээс ирүүлсэн өргөдлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл өргөдлийг судалсан талаар тус тус танилцуулав.

Өргөдөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн тавьсан асуултад ахмадын холбооны төлөөлөл Ц.Сүхбаатар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга О.Номинчимэг тогтоолын төслийг тараасан талаар танилцуулав.

О.Номинчимэг: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	7
Бүгд:	14

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэлийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

О.Номинчимэг: Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэлийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	6
Бүгд:	14

57.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

О.Номинчимэг: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	6
Бүгд:	14

57.1 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 45 минут үргэлжилж, 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 29 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

О.НОМИНЧИМЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 12 дугаар сарын 02-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Үндсэн хууль”
танхим
11 цаг 44 минут.

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

О.Номинчимэг: Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы Өргөдлийн байнгын хорооны 12 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаан эхлэхэд бэлэн боллоо.

Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хороодын гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Өргөдлийн байнгын хорооны 2025 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн, Жанчивын Галбадрах гишүүн, Жаргалсайханы Золжаргал гишүүн, Дүгэрийн Рэгдэл гишүүн, Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн, Даваасамбуугийн Ганмаа гишүүн, Отгоны Саранчулуун гишүүн, Жамбын Батсуурь гишүүн, Сонгобайн Замира гишүүн, Бадамдоржийн Пунсалмаа гишүүн, Мягмардашийн Сарнай гишүүн, Одсүрэнгийн Номинчимэг нар ирсэн байна. Нийт 25 гишүүнээс 13 гишүүн ирээд байна.

Ирц бүрдэхгүй байсантай холбоотойгоор манай Байнгын хороо жишээлбэл 45 минут хоцорч эхэлж байна. Халтмаагийн Баттулга гишүүн гадаад томилолттой, Батмөнхийн Батцэцэг гишүүн гадаад томилолттой, Хажекберийн Жангабыл гишүүн гадаад томилолттой, Сайнхүүгийн Ганбаатар гишүүн орон нутгийн томилолттой, Ганзоригийн Лувсанжамц гишүүн чөлөөтэй, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн орон нутгийн томилолттой, Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн өвчтэй, Саруулсайханы Цэнгүүн гишүүн гадаад томилолттой явж байх шиг байна лээ тийм үү? Энэ дээр тэмдэглэгээг нь хэлээрэй. Ийм нөхцөл байдалтай байгаа юм байна.

Гишүүд маань Байнгын хорооныхоо хуралдаа бас идэвхтэй оролцъё. Орж ирээрэй. Ингээд Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр 3 асуудал манай Байнгын хороогоор хэлэлцэхээр байгаа.

Нэгдүгээрт, Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэбатаас Тэтгэврийн зээлийн асуудлаар Монголбанкны Ерөнхийлөгчид хандсан асуултын хариуг хэлэлцэх асуудал байна.

Хоёрдугаарт, иргэдээс ирүүлсэн өргөдлийн талаар буюу Бэрхийн уурхайн нэр бүхий 112 иргэнээс ирүүлсэн энэ хохирол барагдуулахтай холбоотой ирүүлсэн өргөдлийн тухай хэлэлцэнэ.

Гуравдугаарт, Өргөдлийн байнгын хороонд иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын хүсэлтийн шийдвэрлэлтийн явцын талаар та бүхэнд бас мэдээлэл өгч, дараагийн Байнгын хорооны бэлтгэл ажлыг хангуулах асуудал байна.

Ингээд хэлэлцэх асуудалтай холбоотой санал хэлэх гишүүд байна уу?

Хэлэлцэх асуудалтай холбоотой алга байна.

Нэгдүгээр асуудал, Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатар Эрдэнэбатаас Тэтгэврийн зээлийн асуудлаар Монголбанкны Ерөнхийлөгчид хандсан асуултын хариуг хэлэлцүүлье.

Ажлын хэсгийг оруулъя.

Монгол Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороонд хандан ахмадуудаас арилжааны банкнууд тэтгэврийн зээлийн хүүг нэмэгдүүлж, зээл олгох хугацааг 6, 12, 18 сарын хугацаатайгаар хязгаарлалт тогтоон олгож байгаа нь ахмад настнуудад хүндрэл үүсгэж байгаа асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэбатаас Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь хэсэг дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11.1 дэх хэсгийг үндэслэн 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Монголбанкны Ерөнхийлөгчид хандсан асуулт болон ирүүлсэн хариуг та бүхэнд хүргүүлсэн болно.

Уг асуудлыг цөмөөрөө хэлэлцэж эхэлье. Ажлын хэсгийг оруулаарай.

Ингээд тус асуудлын талаар Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн эхлээд танилцуулна. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүний микрофоныг өгье.

С.Эрдэнэбат: Өглөөний мэнд хүргэе. Ахмадын тэтгэврийн зээлтэй холбоотой асуудал үндсэндээ бараг жил ойтойгоо бараг золгох гэж байна. Түрүү жилийн өдийд Засгийн газар, Гэр бүл, нийгмийн хамгааллын яамны яам, мөн Монголбанканд тодорхой бас санал хүргүүлсэнтэй холбоотойгоор тэтгэврийн зээлийг олгоход нь өр, орлогын харьцааг амьжиргааны баталгаажих доод түвшинтэй хамаатуулан тогтоох, мөн тэтгэврийн зээл олгодог хэмжээг, хязгаарыг тавих ийм чиглэл ирүүлсэн гэдэг үндэслэлээр арилжааны банкнууд тэтгэврийн зээлийг хугацааг нь багасгах, мөн өр, орлогын харьцааг тавих ийм санал, шаардлага тавьсан.

Оны эхнээс авахад Нийгмийн бодлогын байнгын хороо, мөн Өргөдлийн байнгын хороонд дахиж бас нийтдээ бараг 6000 орчим ахмадаас гомдол ирсэн.

Үүний дагуу Нийгмийн бодлогын байнгын хороо, Өргөдлийн байнгын хороо бас ярилцаад Монголбанк болон Гэр бүл, нийгмийн хамгааллын яамныхан өөрсдийн гаргаж байсан шийдвэрүүдээсээ буцаад тэтгэврийн зээлийг хуучин олгож байсан хэвд нь олгох, мөн хүүг нь бас тодорхой хэмжээгээр бууруулах гэх

мэтчилэн ийм асуудлаар тодорхой судалгаа хийж байна гэдэг ийм саналыг ирүүлсэн.

Гэсэн хэдий ч гэсэн үндсэндээ энэ наадмын өмнө буюу энэ оны наадмын өмнө ерөнхийдөө энэ асуудал шийдэгдсэн. Засгийн газрын тэргүүн ч гэсэн бас энэ тал дээр анхаарал хандуулчихвал ахмадын тэтгэврийн энэ зээлтэй холбоотой асуудлыг хуучин хэвд нь оруулах, мөн тодорхой хязгаар тавихгүйгээр шийдэх ийм асуудлуудыг тавьсан.

Энэ асуудал маань явсаар байгаад сүүлдээ тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэх гээд энэ тэтгэвэртэй холбоотой олон асуудлууд гарч ирсэн. Энэ тал дээр манай Ахмадын холбоо, ахмадын иргэдийн нэгдэл манай энэ Алтанчимэг гуай сууж байна үндсэндээ энэ зунжингаа л суулаа. Ингээд асуудал шийдэгдсэн болов уу гэж бодсон харамсалтай нь бас арилжааны банкнуудад асуудал байна. Одоо бол 36 сараар олгож байгаа, тэтгэврийн зээл олгож байгаа ийм банк байхгүй. Дээд тал нь 24 сараар олгож байгаа. Ийм хязгаар тавьсан байна.

Үүний дагуу миний бие дахиж энэ ахмадуудын санал, хүсэлт, мөн Байнгын хороод дээр, Өргөдлийн байнгын хороод дээр ирж байгаа ажлын хэсэг гаргаад арилжааны банкнуудтай уулзсан. Монголбанкныхантай уулзсан, ахмадуудтай уулзсан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллынхан, яамтай уулзсан. Арилжааны банкнуудаас энэ тэтгэврийн зээлийг, ер нь зээлийн хүүг бууруулах энэ Улсын Их Хурлаас өгсөн чиглэлийн дагуу хэд хэдэн саналыг ирүүлсэн.

Нэгдүгээрт, арилжааны банкнууд тэтгэврийн зээлийн хэмжээг олгоход тодорхой Монголбанкнаас болон Засгийн газраас арга хэмжээнүүдээ бид нар эргэж бас тодорхой хүүг нь бууруулах болон хэмжээг нь уртасгах талаар арга хэмжээ авч болж байна гэдэг нэр бүхий системийн 3 банкнаас бичгээр ирсэн. Банкны холбоотой хүртэл уулзсан.

Нэгдүгээрт бол ахмадын тэтгэврийн зээлийг хамгийн өндөр эрсдэлтэй буюу 150 хувийн эрсдэлтэй гэдэг байдлаар тогтоосон. Зээлийн зардал өсөх үүнтэй холбоотойгоор хүүгийн зардал дээр тодорхой хэмжээний нөлөөлөл байна гэдэг ийм саналыг ирүүлсэн. Хэрвээ энийгээ эрсдэлээ бууруулах, ахмадын зээлийн эргэн төлөлтийг нь аваад үзэхээр 97, 8 хувийн буцаан төлөлттэй буюу сайн төлөлттэй зээлд орж байгаа. Тийм учраас яагаад ийм өндөр эрсдэлтэй буюу 50 хувийн эрсдэлтэй гэж тавьсан бэ гэдэг ийм асуулгыг би тавьсан.

Хоёрдугаарт, тэтгэврийн зээлийн хүүг заавал байлгах нөөцийн хэмжээнд тодорхой хэмжээний зохицуулалт хийгээд банкнуудад зээл олгох эх үүсвэр дээр нь орон зай гаргаж өгөх юм бол тэтгэврийн хүүг бууруулах болон хугацааг нэмэгдүүлэх боломж бас байж болох юм гэдэг ийм саналыг банкнуудын зүгээс ирүүлсэн. Юуны дагуу би асуулга тавьсан. Нэгдүгээрт тэтгэврийн зээлийн хүү нэмэгдсэн байна. Одоо жигнэсэн дунджаар буюу нийт тэтгэврийн зээлийн дундаж нь 17, 8, 16 гэж яриад байгаа боловчиг яг шинээр авч байгаа тэтгэврийн зээл 19 хувь, 19 орчим хувь буюу 20 хувь нэмэгдсэн байна.

Тэгэхээр үндсэндээ манай энэ банкнуудын зүгээс зээлийн хүүгийн дундаж хэмжээ яг шинээр авч байгаа хамтын тэтгэврийн зээлийн хувьд нэмэгдсэн.

36 сараар хязгаарлахгүй, Монголбанк ерөөсөө оролцохгүй, хуучин хэвд нь оруулсан, банкнууд шийд гэж байгаа боловчиг банкнууд тодорхой хэмжээний

зээлийн багц дотор эзлэх хувь болоод ахмадын тэтгэврийн зээлийн хэмжээ 5 хувь хавьцаа байгаа. Тийм өндөр бол биш. Тийм учраас 36 сараар олгож байгаа болоод тэтгэврийн зээл үндсэндээ байхгүй. Олгох боломжгүй. Зарим нь 24, зарим нь 18 гэдэг ийм хэмжээгээр олгож байгаа. Энэ зээлийг хязгаарлах шалтгаанаа тодорхой гаргаж өгөөч гэдэг би бас ийм саналыг, асуулгыг тавьсан.

Мөн ахмадад олгох үндсэндээ тэтгэврийн зээл гэж яриад байгаа боловч энэний цаана маш олон зээлүүд байж байгаа. Үндсэндээ бид нар Монгол Улсын Үндсэн хуулиар ахмадууд болон иргэдийг нас хүйс, ажил, албан тушаал юугаар нь ялгаварлахыг хориглоно гэсэн ийм заалтаа зөрчөөд ахмадуудад орон сууцын зээл олгодоггүй, хөнгөлөлттэй бизнес, аж ахуй, өрхийн аж ахуй эрхлэх зээл олгодоггүй, янз бүрийн бусад ийм зээлүүдийг олгох нь үндсэндээ хязгаарлалттай байдаг. Үндсэндээ моргейжийн зээл ч гэсэн ахмадуудад ингээд олгодоггүй.

Тэгэхээр энэ хүмүүс яаж байна вэ гэхээр харахад тэтгэврийн зээл мэт харагдаж байгаа боловчиг ард нь маш олон зээлийн бүтээгдэхүүнүүдийг тэр хүмүүс тэтгэврийн зээлийн ард байна. Тийм учраас ахмадуудын амьжиргаанд бас нөлөөлсөн байна. Тийм учраас энэ ахмадуудад зээлийн бусад бүтээгдэхүүнүүдийг гаргаж өгөөч гэдэг саналыг тавьсан. Энэ талаар судалж байна, боломжтой гэж ярьсан. Тэгээд энэ талаар би асуулга тавьсан.

Мөн ахмадуудтай холбоотой янз бүрийн давхар зээлдэгч, баталгаа гаргуулах гэх мэтчилэн маш олон ийм банкнуудад хүнд суртлын ч гэдэг юм уу ойлгомжгүй ийм олон асуудлууд байна. Энэ тал дээрээ тодорхой арга хэмжээ аваач гэдэг ийм асуулгыг тавьсан. Тэгээд энэ асуудлыг Монголбанк, банкууд бол нэг талаас нь харж байгаа байх. Мэдээж энэ ахмадын зээлийн тэтгэврийн зээлийг урт хугацаагаар хэмжээ, хязгааргүй олгочих юм бол инфляцад нөлөөлнө, зээлийн багцад нөлөөлнө, чанарт нөлөөлнө энэ тэр гээд юу яаж байгаа.

Тэгэхээр нэгэнт энэ асуудлыг анх үүсгэсэн Гэр бүл, нийгмийн хамгааллын яамны сайдын мэдэгдэл, Засгийн газар энэ зээлийн асуудалд Засгийн газар ямар нэгэн байдлаар хязгаарлах ийм зүйлийг ярихгүй. Ер нь бол бид нар тэр гадаад, дотоодын гэдэг юм уу Монголын аж амьдралаас хол, тэтгэвэр нь өндөр, цалин хөлс, хөдөлмөрийн үнэлэмж нь өндөр, хангамж сайтай, эрүүл мэнд, тусламж, үйлчилгээ үндсэндээ гадаадын тэр олон улс орнуудад тэтгэвэрт гарсан ахмад заавал ямар нэгэн аж ахуй эрхлэх, эс үгүй бол эмчилгээ, үйлчилгээтэй холбоотойгоор ийм зээл авах шаардлагагүй орнуудын судалгаа, шинжилгээгээр үндэслээд бид нар ахмадуудынхаа санхүүгийн энэ байдалд нь хязгаарлалт тогтоох нь эрсдэлтэй байна. Яах вэ урт хугацаандаа энэ 3 жилээр нь авдаг, 2 жилээр нь авдаг энэ асуудал дээр анхаарал хандуулах нь зүйтэй.

Гэхдээ яг өнөөдрийн байдлаар нэг дор гэнэт ийм шийдвэр гаргасан нь ахмадууд үндсэндээ тэтгэврийн зээлийн циклийн эрсдэлд буюу санхүүгийнхээ төлөвлөлтөд огцом шийдвэр гарснаас болоод эрсдэлд учирчхаад байна. Тухайлбал, 24 сарын тэтгэвэр, 36 сарын тэтгэврийн зээл авсан хүн эргээд 6 сарыгаа төлөөд буцаагаад 6 сарынхаа 3 сарыг нь дахиж авах байдлаар, ийм байдлаар амьжиргаагаа залгуулж байгаа.

Энэ бол нэгдүгээрт юутай холбоотой вэ гэхээр манай ахмадын тэтгэвэр бага. Үндсэндээ зээлээс зээлийн хооронд амьдарч байгаа ийм циклд нь орчихсон байсан. Тийм учраас төрийн аливаа шийдвэр огцом гэнэт гаргадаг биш, гадаадын ч гэдэг юм уу дотоодын ч гэдэг юм уу нэг байгууллагын судалгааг гэнэт авч

үзэнгүүтээ одоо гэнэт тэтгэврийн зээлийг зогсоо, одоо өр, харилгын харьцааг нь ингээд тавь гэдэг ийм бодлогогүй огцом шийдвэрүүдээс болоод ийм асуудал үүсээд байгаа юм.

Тэгэхээр зарим хүмүүс болохоор тэтгэврийн зээл ингээд тавьчихаар бүгдээрээ 36 сарын тэтгэмж, зээл авчихна, инфляц өсөж байна гэдэг ийм зүйл яриад байгаа юм. Тэгэхээр энэ тал дээр бас Их Хурлын дарга ч гэсэн бас анхны үгэндээ энэ тэтгэврийн зээлийн асуудал дээр анхаарал хандуулъя, ойрын хугацаанд шийдье, яг ингээд аваад үзэх юм бол энэ чинь нэг талаасаа зээл, мөнгөний бодлого боловчиг нөгөө талаасаа ахмадын амьжиргааны асуудал байгаа юм байна. Нөгөө талаар амьжиргааны эрсдэлийн асуудал байгаа юм байна.

Тийм учраас энэ гаргах гэж байгаа шийдвэрээ магадгүй бид нар 3, 4 жилийн хугацаанаас урьдчилаад, өр нь цаашдаа 3 жилийн дараанаас авхуулаад, 2 жилийн дараанаас авхуулаад тэтгэврийн зээлийг 3 жилээр нь авдаг өр нь байхгүй болох нь байна шүү. Тэр хугацаанд нь бид нарын гол шаардлага бол тэтгэврээ нэмэгдүүлэх, бусад тэр ахмадуудын тухайлбал, ахмадууд эмнэлэгт үзүүллээ. Эмнэлэгт үзүүлэхэд захын 1 ор хоногийн мөнгө гэхэд 200-250 мянган төгрөг. Хавар боллоо амралт, сувилалд явлаа. Мөн өвчин зовлон тусах юм бол үндсэндээ зээл авдаг. Орон сууц авах гэдэг, хашаа байшингаа дулаалах хэрэг гардаг. Тэгээд маш олон ийм хэрэгцээтэй байгаад байгаа учраас энэ тал дээр энэ Монголбанк болон арилжааны банкнууд маань нийгмийн хариуцлагын хүрээнд, нөгөө талаасаа энэ олон мянган ахмадуудын энэ санал, хүсэлт нэг зүйлийг хэлээд байгаа юм. Тэгээд энэ зүйл дээр бас энэ шийдвэрүүдээ эргэж авч үзээд шийдээсэй.

Арилжааны банкнуудын асуудалд оролцохгүй гэж хэлээд байгаа боловчиг цаагуураа миний хувьд харж байгаагаар бол өр нь энэ зээлийн багцыг нь Монголбанкны өөрийн оролцох, заавал байлгах нөөцийн хэмжээ, эрсдэлийн хэмжээ, тэр нөөцийн арилжааны банкнуудыг энэ зээлийн хүүг бууруулах энэ тал дээр нь бас дэмжлэгийн арга хэмжээнүүдийг аваач л гэдэг ийм тодорхой асуултуудыг тавьсан юм.

О.Номинчимэг: Өр нь яах вэ манай Өргөдлийн байнгын хороон дээр сүүлийн үед ирж байгаа бид нар 14, 14 хоногоор тойм гаргадаг. Тэгээд хамгийн их сүүлийн энэ 14 хоногт ирж байгаа өргөдөл, гомдол буюу нийт өргөдөл, гомдлын 33.3 хувь нь тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой асуудал байгаа.

Ялангуяа манай ахмадуудын тэтгэврийг буруу бодсон, эсвэл энэ тэтгэвэр, тэтгэмж, зээлийн асуудал гээд нэлээн хавраас хойш л уг нь явж байгаа. Энэ асуудал уг нь хавар Нийгмийн бодлогын байнгын хороон дээр яригдсан боловч дорвитой шийдэл гараагүй юм уу асуудлууд үргэлжилж байгаа учраас Эрдэнэбат гишүүн бас асуулт тавиад энэ хүрээндээ асуудлуудаа цөмөөрөө хэлэлцээд нэг шийдэлтэй л баймаар байгаад байгаа юм. Зүгээр яриад өнгөрөх биш цөмөөрөө яг олон талаас энэ мэдээллээ хэлэлцэж байгаад шийдэл гаргаад ёстой Улсын Их Хурлын тогтоолоороо гаргадаг юм уу яадаг юм шийдэлтэй байхгүй бол ингээд олон сар, жилээр үргэлжлээд явдаг юм байх ёсгүй гэж харж байгаа юм.

Ингээд хэлэлцэж байгаа энэ асуудалтай холбоотойгоор хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Энхтайван Монголбанкны дэд ерөнхийлөгч. Босоод ирсэн гэдгээ хэлээрэй. Батболд Монголбанкны Мөнгөний бодлогын газрын Макро зохистой бодлогын

хэлтсийн дарга, Аюуш Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал, Ургамалсувд Монголбанкны Мөнгөний бодлогын газрын Мөнгөний бодлого, төсөөллийн хэлтсийн захирал. Тэнд байна. Амарсанаа Төрийн банкны Хууль, эрх зүй хариуцсан дэд захирал, Э.Батбаяр Төрийн банкны Зээлийн газар хариуцсан захирал, С.Энх-Ирээдүй Хаан банкны Бизнес хөгжил хариуцсан дэд захирал, Болортуяа Хаан банкны Ногоон банкны газрын захирал, Лхагвасүрэн Голомт банкны Зээлийн бодлогын хэлтсийн захирал, Амарзаяа Голомт банкны Иргэдийн бизнес, хөгжлийн хэлтсийн ахлах менежер, Ц.Сүхбаатар Ахмадын холбооны ерөнхийлөгч. Сүхбаатар гуай ирсэн байна. Ц.Алтанзул Ахмадын зөвлөлийн төлөөлөгч. Ахмадын холбоо гээд Ахмадын зөвлөл гээд хоёр өөр байгууллага байгаад байна уу? Ахмадын холбоо, Ахмадын хөдөлгөөн гээд тусдаа хоёр байгууллага байгаад байна уу? Мөн Гэр бүл, хөгжлийн яамнаас хэн ирсэн байна? Ренчиндорж Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, бодлогын газрын дарга, Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга. Бат-Эрдэнэ? Тэнд сууж байна уу? Ганцэцэг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга. Энэ дээр байгаа юм уу? Хишигжаргал Гэр бүл, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газрын ахлах шинжээч? Ард сууж байгаа юм байна. Ууганбаатар Гэр бүл, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн хяналтын хэлтсийн Хөдөлмөрийн хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн гэнэ. Ийм албан тушаалтнууд өнөөдрийн энэ эхний хэлэлцэх асуудалтай холбоотойгоор оролцож байна.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Нэрсээ өгье.

Замира гишүүнээр тасаллаа. Нийт 4 гишүүн. Сүхбат Эрдэнэбат гишүүн чинь өөрөө асуухгүй билүү? Асуухгүй асуулт тавьсан гишүүн болохоор. Тэгвэл ирцийн дарааллын дагуу Сонгобайн Замира гишүүн асуултаа асууя.

С.Замира: Баярлалаа. Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Энэ тэтгэвэр, тэтгэмжийн асуудал нэлээд яригдлаа л даа. Манай 126 гишүүн бүгд ярьсан байх. Ахмадууд ингээд бараг юунд суугаад бараг хэдэн, маш олон хугацаа өнгөрлөө. Ер нь энэ тэтгэврийг хүмүүс янз бүрээр тайлбарлаад байна. 20, 30 жил ажилласан ахмадууд дээр 91 онд өмч хувьчлалаар байгууллагууд таарахад тэгээд бүх хийсэн хөдөлмөр нь алга болоод, бичиг баримт нь алга болоод доод хэмжээгээр тэтгэврээ тогтоолгосон шүү дээ. Бүүр тэр барилга, хүнд хүнд газарт ажиллаж байсан бүх ахмадууд. Тэгэхээр энийг эргэж харах цаг нь болсон. Болох байтугай өнгөрч байна. Ихэнх ахмадууд тэтгэвэр нэмүүлнэ гэсээр байгаад хальлаа хорвоогоос. Одоо ер нь Монголбанк энийг нь яаралтай ажил болгож 2, 3 асуудлыг шийдэх боломж байна уу?

Нэгдүгээрт, тэтгэврийн хүү буурах ёстой. Энэ ийм боломж байна уу?

Хоёрдугаарт, тэтгэвэр 24 сараар ч юм уу, 12 сараар авчхаад дараа нь дахиад хэдэн сар нэмж авахад тэр нь хүү дээр хүү нь нэмэгдээд явж байна гэсэн гомдол бас ирчихсэн байгаа. Тэгэхээр суутгаж авч байгаа мөнгө нь нэмэгдэж байна л гэсэн үг. Хүүг нь багасга, тэгээд тэтгэвэр нэмэх ёстой. Тэтгэврийн доод хэмжээг. Ялангуяа доод хэмжээг. 600 хэдэн мянган төгрөг гэдэг чинь 1 удаа аягүй бол дэлгүүрээс ганц, хоёр тор юм аваад гарахад ингээд алга болчихно. Өвлийн идэшний юу болж байна, өвлийн түлээ түлшээ бэлдэх үе болж байна. Зарим хүмүүс тайлбарлах юм хүүхдүүд нь энэ ахмадуудыг мөлжөөд тэтгэврийг нь

хүүхдүүд нь идэж байна гэж. Аав, ээж болгон үр хүүхдийн төлөө ажиллана шүү дээ залуу ч бай, тэтгэвэрт нь ч бай. Тийм учраас энэ 2 асуудлыг яаралтай шийдэх боломж байна уу цэслэн шийдэх?

О.Номинчимэг: Монголбанкнаас асууж байна. Энхтайван Монголбанкны дэд Ерөнхийлөгч. Индэр дээрээс хариулах юм байна. Индэр дээр.

Г.Энхтайван: Замира гишүүний асуултад хариулъя. Гишүүн энэ тэтгэврийн зээлийн хүүтэй холбоотой асуултыг хөндлөө. Тэтгэврийн зээлийн хүүг хэрхэн бууруулах вэ? Мөн 24 сартай холбоотой зохицуулалт дээр нэмж аваад байгаа тохиолдолд зээлийн хүүг давхардуулж тооцоод байна уу гэсэн тийм асуулт асууж байх шиг байна.

Төв банкны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор олгогдсон эрх, үүргийн хувьд бол Төв банк арилжааны банкны үйл ажиллагаанд хөндлөнгөөс ерөөсөө огт оролцдоггүй. Банк, иргэн, хуулийн этгээд өөрийн болзол нөхцөлийн дагуу зээл олгож, зээлийн хүүг өөрөө тогтооно гэж банкны зээлийн үйл ажиллагааг хэрхэн зохицуулах тухай Банк эрх бүхий мөнгөн этгээдийн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд заасан байдаг. Тэгэхээр энэний дагуу зээлдэгч, зээлийн зориулалт, зээлийн хүү, хугацаа болон нөхцөлийн талаар зээлдэгчтэй харилцан тохиролцож байгуулсан гэрээний үндсэн дээр түүний зээлийн данс нээж зээл олгоно гэж бид бүхэн заасны дагуу л арилжааны банк өөрийн нөхцөлийн дагуу хүүгээ тогтоогоод явж байгаа.

Төв банкны зүгээс зээлийн хүүг хэрхэн бууруулахад ямар бодлогын арга хэмжээ авах боломжтой вэ гэдэг дээр түрүүн бас Эрдэнэбат гишүүн хэлсэн. Тэгэхээр Төв банкны зүгээс макро зохистой зохицуулалтын хүрээнд заавал байлгах нөөц болон эрсдэлээр жигнэсэн активын хэмжээг тогтоодог. Яг энэ хүрээнд түрүүн гишүүн хөндсөн түрүүн таны хэлснээр зээлийн эрсдэлийн жинг хэрвээ бид хэд 50 нэгж хувиар бууруулах юм бол сарын хүү 0.04 хувиар буюу сарын хүү нь 1.5-аас 1.46 хувь болоод жилийн хувьд зүгээр 0.5 хувиар буурах тийм тооцоолол гарч байгаа.

Тэгэхээр одоо байгаа тэтгэврийн зээлийн жигнэсэн дундаж хүү 17.6 хувьтай. Үүнээс 0.5-аар буурахаар 17.1 хувь болж тийм буурах тооцоолол байгаа. Эрсдэлийн жингээр тооцох юм бол.

Нөгөө талдаа хэрвээ банканд хөнгөлөлттэй нөхцөлтэй эх үүсвэр олгох юм бол арилжааны банк өөрөө хадгаламж эзэмшигчдээс 13-14 хувиар хадгаламж эзэмшигчдийн мөнгийг татаж авчирч байгаа. Түүн дээрээ нэмээд өөрөө эрсдэлийн зардлаа нэмээд зээлийг олгож байгаа. Тэгэхээр Төв банкны зүгээс арилжааны банканд хөнгөлөлттэй нөхцөлтэй эх үүсвэр олгоод хэрвээ энийг шийдсэн тохиолдолд энэ репо санхүүжилтийн хүү 13 хувьтай байгаа. Тэгэхээр энэ дээр бас харьцангуй нөлөө их багатай. Тэгэхээр Төв банкны зүгээс энэ дээр ямар бодлогын арга хэмжээ авах боломжтой вэ гэж байгаа гэж үзэж байгаа гэдэг тохиолдолд Нийгмийн даатгалын ерөнхий газраас хэрвээ тэтгэврийн зээлийн эх үүсвэрийг, нийгмийн даатгалын сангийн чөлөөт эх үүсвэрийг арилжааны банкуудад байршуулаад.../минут дуусав./

О.Номинчимэг: Гүйцээж хариулъя. Индрийн микрофоныг нэмэлтээр өгье.

Г.Энхтайван: Тухайн зээлийн эх үүсвэрийн зардлыг тодорхой хэмжээнд бууруулаад Нийгмийн даатгалын ерөнхий газар, арилжааны банк хоёр хамтраад гэрээ байгуулаад явсан тохиолдолд энэ дээр тодорхой хэмжээнд буурах зохицуулалттай байгаад байгаа.

24 сарын зээл авчхаад үргэлжлүүлээд зээлээ тооцоод явахад, нэмээд явахад зээлийн хүүг давхардуулж аваад байна гэдэг дээр манай Төв банкнаас арилжааны банкнууд дээр шалгалт явуулсан байгаа. Тэгээд энэ шалгалтын дүнг хэрхэн гарсан, энэ дээр ямар зөрчил, дутагдал хэрвээ гарсан эсэх талаар манай Мөнгөний бодлогын газраас яг дэлгэрэнгүй танилцуулаад яриад өгчих.

Н.Батболд: Мөнгөний бодлогын хэлтсийн захирал Батболд байна.

О.Номинчимэг: Индрийн микрофоныг үргэлжлүүлээд өгөөрэй.

Н.Батболд: Саяын давхар хүү тооцдог асуудлаар иргэн Алтанзулаас Монголбанканд өргөдөл ирүүлсэн байгаа. Тэгээд энэ дагуу Монголбанкнаас судлаад үзэхэд энэ дээр яг ийм давхардуулж байгаа асуудал гараагүй Монголбанкнаас тогтоосон зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох аргачлалыг Монголбанк болон Зохицуулах хороо хамтран баталсан байдаг. Энэхүү аргачлалтай бүрэн нийцтэй байгаа гэдэг үр дүн гарсан байгаа. Энэ талаар бас иргэн Алтанзулд мэдэгдсэн байгаа үр дүнг.

О.Номинчимэг: Замира гишүүн тодруулж асууя.

С.Замира: Ер нь Монголбанкны үндсэн үүрэг нь юу юм? Монголбанкнаас асууж байна. Үндсэн та бүхний үүрэг юу Монголбанк? Одоо юу хийх ёстой байгууллага билээ?

О.Номинчимэг: Индрийн микрофон Монголбанкны дэд ерөнхийлөгч Энхтайван.

Г.Энхтайван: Төв банкны тухай хуулиар Монголбанкны үндсэн зорилтыг хуулиар тодорхойлж өгдөг. Үүнд бол төгрөгийн тогтвортой байдал буюу үнийн тогтвортой байдлыг хангах үндсэн үүрэгтэй. Юу гэнэ ээ?

О.Номинчимэг: Замира гишүүн 1 минут дахиад тодруулга.

С.Замира: Арилжааны банкнуудтай яаж харьцаж ажиллах ёстой билээ та нар? Дахиад нэмж асууна. Тэгээд бас нийгмийн даатгалдаа хэр байна? Нийгмийн даатгалын шимтгэл авч байгаа нийгмийн даатгалын байгууллагатайгаа хамтарч чадвал бид нар тэгээд хүү бууруулах гээд үлгэр шиг юм ярьж байгаа биз дээ? Энэ хэзээ болох юм, энэ хэзээ дуусах юм, энэ дээр ажил эхэлсэн юм уу ер нь? Гэрээ, хэлэлцээр ч юм уу Засгийн газраас ч шийдвэр гарсан юм байна уу ер нь? Энэ хоёр дээр хариулт өгчих.

О.Номинчимэг: Байж байгаарай микрофон өгөхөөр ярина шүү. Энэ чинь бас дэгтэй хурал байна. Хоорондын харилцан яриа шиг байж болохгүй.

Монголбанкнаас энэ юутай Монголбанкны чиг үүрэг ялангуяа арилжааны банкнуудтай холбоотой чиг үүргийн талаар ярина. Бусад асууж байгаа энэ асуудал илүү Засгийн газартай холбоотой асуудал байгаа учраас тэрийг төлөөлж ярих

хүмүүс нь бэлдэж байгаарай. Тэр арга хэмжээ авч байгаа юм уу, энэ даатгал дээр тэрийг Засгийн газрын дээр ажиллаж байгаа юу гэдэг асуудлыг Засгийн газар төлөөлөх гишүүд нь. Индрийн микрофон Энхтайван.

Г.Энхтайван: Төв банк арилжааны банкны үйл ажиллагаа, бодлого, үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийг олгож, холбогдох хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавьдаг. Түүнээс Төв банкны зүгээс арилжааны банкны өөрийн зээлийн бодлого болон тухайн банкны үзүүлж байгаа шимтгэл болон бусад үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хуулиар хориглодог.

Төв банкны зүгээс арилжааны банканд байгаа иргэдийн буюу хадгаламж эзэмшигчдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, тухайн улс орны санхүүгийн тогтвортой байдлыг хангахад нэгдсэн тийм бодлого явуулж ажилладаг. Мэдээж Төв банкны зүгээс иргэд, аж ахуйн нэгжүүд тэр тэдгээрээс арилжааны банкнаас үйлчилгээ авч байгаа нийт иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, эдгээр иргэд иргэд маань өөрөө үнийн тогтвортой байдлын нөхцөл байдлаас хамааран тэдгээрийн аж ахуй болон амьжиргааны түвшин хэрхэн нөлөөлж байгаа гэдэг дээр бид бүхэн судалгаа хийж, холбогдох байгууллагууд энэ чиглэлийн талаар шийдвэр гаргах эрх бүхий субъект болох Засгийн газарт бол.../минут дуусав./

О.Номинчимэг: Замира гишүүний 2 дахь асуулттай холбоотой нийгмийн даатгалын Гэр бүл, хөгжлийн яамнаас ярих уу? Тодорхой арга хэмжээ авч байгаа юм уу энэ асуудлаар гээд? Ер нь ахмадуудынхаа талаар. Тэгье, индэр дээр очъё.

Монголбанкны чиг үүрэг тэгээд яах вэ үнийн тогтвортой байдлыг хангах гэж байгаа. Тэгээд үнийн нөхцөл байдал сүүлийн 1, 2 жил ямар байгаа билээ бүгдээрээ л мэдэж байгаа шүү дээ бид нар макро эдийн засгийн хувьд. Ард иргэдийн хамгийн их бухимдаж байгаа юм инфляц ихэссэн байна, үнэ өссөн байна гээд. Тэгээд Монголбанкны мөнгөний бодлого үнэхээр энэ чинь тэгвэл дорвитой хэрэгжэж чадаж байгаа юм уу гэдэг дээр ч гэсэн зүгээр энэ асуудалтай холбоогүй ч гэсэн үнэлэлт, дүгнэлт хийх л хэрэгтэй шүү дээ. Тэгээд зорилго нь гээд тэгэхээр зөвхөн мөнгөний бодлого, инфляц л яриад байдаг. Нөгөө талд нь уг нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг багасгах гэдэг том уг нь зорилт бух бүхий л газруудад байдаг. Манай Монголбанк чинь тэр дээрээ ерөөсөө анхаарахгүй байхаар зүгээр өөрийнхөө инфляцын юуг л бариад яваад байх юм. Энэ дээр ер нь Улсын Их Хурал дээр ч гэсэн ярьж байсан. Бас анхаарах ёстой шүү гэдгийг хэлмээр байна.

Нэрээ хэлээд, индрийн микрофон нэрээ хэлээд Замира гишүүний асуултад асуултад хариулья.

Ц.Ганцэцэг: Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ганцэцэг. Замира гишүүний тэр сүүлийн асуултад хариулья. Нийгмийн даатгалын ерөнхий газар маань Загийн газрын Хэрэгжүүлэгч агентлаг. Арилжааны банкнуудтай хамтарч, хамтран ажиллах гэрээг жил бүр байгуулдаг. Энэ гэрээний дагуу Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авч байгаа хүмүүсийнхээ нийгмийн даатгалын үйлчилгээг үзүүлдэг. Ажил олгогч шимтгэлээ төлнө. Эдгээр банкнуудад байршиж байгаа орлого бүрдэнэ. Эргээд 520 орчим мянган хүний тэтгэврийг сар бүр, 300 орчим мянган хүний бусад

төрлийн богино хугацаатай тэтгэмжийг тухайн эрх үүссэн болгонд нь олгодог ийм ерөнхийдөө зохицуулалттай.

Бид арилжааны 9 банктай хамтран ажиллах гэрээг жил бүр байгуулдаг. Энэ гэрээгээр тухайлаад юу гэдэг юм тэтгэврийн барьцаалсан зээлийн хүүг бууруулна, зээлийн барьцаанд ийм хэмжээний мөнгө байршуулна гэдэг ийм зохицуулалт одоогийн байдлаар хамтран ажиллах гэрээгээр зохицуулагдаагүй. Зөвхөн тэтгэвэр, тэтгэмж тогтоож олгохдоо.../минут дуусав./

О.Номинчимэг: Одоогоор та хамтран ажиллах гэрээнд чинь тэр байршуулах энээ тэрээ эрсдэлийг байхгүй болгох үүднээс тэр байршуулах гэсэн гэрээ хийгдээгүй байгаа гэж байна шүү дээ тээ? Тэгээд энэ дээр хийгдэхэд хамгийн их саад болж байгаа сөрөг зүйл, эсвэл болгоомжилж байгаа юм нь юу байгаад байгаа юм? Яагаад энэ юм хийгдэхгүй байгаа юм? Тэрийг нэмэлтээр тайлбар өгчих тэгэх үү? Би Замира гишүүний асуултыг илүү цааш нь дэлгэрүүлээд асууж байна.

Ц.Ганцэцэг: Нийгмийн даатгалын сангийн хувьд тухайн жилийн орсон орлогоо буцаагаад бүх тэтгэвэр, тэтгэмждээ тавьдаг. Сангийн хувьд чөлөөт үлдэгдэл хэрвээ үлдвэл энэ чөлөөт тухайн жилд ашиглаагүй чөлөөтэй үлдсэн үлдэгдлээ системийн нөлөө бүхий банканд тодорхой хүүтэйгээр, гэрээтэйгээр байршуулдаг. Энэ жилийн хувьд 700 орчим тэрбум төгрөгийг арилжааны 5 банканд, системийн нөлөө бүхий 5 банканд 1 жилийн хугацаатай жилийн 15 хувийн хүүтэй байршуулсан. Энэ чөлөөт үлдэгдэл маань Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан болон Тэтгэмжийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл байгаа. 15.

О.Номинчимэг: Би асуултуудаа сүүлд нь яая даа. Дараагийн гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Бид нар уг үндсээ л ойлгохгүй л яваад байгаа юм л даа. Тэтгэврийн хэмжээ нь өөрөө өндөр байсан бол тэтгэврийн зээл авах гээд яваад байх нэг ч хүн байхгүй байхгүй юу. Тэгэхээр тэтгэврийнхээ хэмжээг бид нар яаж нэмэгдүүлэх вэ гэдгээ нэгдүгээр асуудал дээр аль аль талдаа бид нар бодмоор байгаа юм. Нэгдүгээр асуудал нь.

Ер нь яах вэ өнөөдөр байгаа ахмадууд маань яг өөрсдийгөө тэжээх гээд балраад байгаа юм байхгүй шүү дээ. Нэг талдаа орлого нь хүрэхгүй байгаа. Энэ чинь ач, гучаасаа авхуулаад Монгол улсын ирээдүйн иргэдийг бэлдэж байгаа ийм л хүмүүс. Энэ талыг нь бид нар бас аягүй сайн бодох ёстой байгаад байгаа юм. Нэг талдаа.

Монголбанк арилжааны банкнуудад нөлөөлдөггүй л гээд л олон дахин л яриад л сайхан жижүүрийн үгтэй л байгаад байгаа. Яах вэ үнэн. Тэр дээр би санал нэгтэй байна. Хуулиараа ч тийм.

Тэгэхдээ Монголбанк арилжааны банкнуудад тусгай зөвшөөрлийг нь олгож байгаа шүү дээ. Бүх хяналт шалгалт, бүх хяналтыг танайх өөрөө тавьж байгаа. Тэгэхээр нөлөөлөхгүй байна гэж, хөндлөнгөөс оролцохгүй байна гэж хэлээд байх бас нэг талдаа өрөөсгөл шүү. Ард түмний дунд, ялангуяа Улсын Их Хурлын гишүүд та бүхнийг бас хардаж сэрдээд танайх нөлөөлөөд байна гэдэг мэдээлэл хэлээд байна гэдэг маань арилжааны банкнуудаас Улсын Их Хурлын гишүүд дээр

Монголбанк бид нарыг хөдөлгөхгүй байна гэдэг мессеж ирээд байгаа байхгүй юу. Тийм учраас энэ асуудлыг дахин дахин хөндөөд байгаа шүү гэдгийг би хэлэх гэж байгаа юм.

Энхтайван Ерөнхийлөгч маань яах вэ би урьд нь ч бас хэлж байсан. Та хэд маань их л өөрсдөө тэтгэвэрт гарахгүй юм шиг нэг талдаа. Нөгөө талдаа өнөөдөр олж байгаа, авч байгаа цалин чинь хангалттай түвшинд байгаа учраас энэ муу хэдэн ахмадуудын асуудлыг ойлгохгүй байгаад байгаа юм л даа. Тэгээд энд ингээд биччихсэн байгаа юм. Эрсдэлийн жин зээлийн хүүд том нөлөөгүй гэж. Том нөлөө гэж юу юм? Энийгээ тайлбарлаад өгөөч яг тоогоор. Жижиг нөлөө гэж юу юм? Нөлөөлж байгаа нь тодорхой юм байна танай Ерөнхийлөгчийн бичиж явуулснаар. Тэгээд том нөлөөгүй гэж үзээд байгаа юм байна. Тэгэхээр жижиг нөлөөтэй юм байна, эсвэл дунд зэргийн нөлөөтэй юм байна. Энийг тоогоор хэлээд өгөөч гэдгийг хүсэх гэж байгаа юм.

Хоёрдугаар асуулт нь тэтгэврийн зээлтэй холбоотой гарсан өмнөх шийдвэрийг нэр бүхий улс төрчид хөндлөнгөөс оролцож цуцлуулсан явдал нь Төв банкны хараат бус байдалд улс төрөөс халдаж, шийдвэрийг цуцлуулсан анхны тохиолдол болсон төдийгүй тухайн нөхцөл байдлыг дордуулсан харамсалтай явдал болсон байна. Улсын Их Хурлын гишүүд саналаа л тавьсан шүү дээ. Цуцалсан процесс нь танайх өөрөө Бодлогын зөвлөл өөрсдөө хуралдаад л цуцалсан шүү дээ. Тэгээд яах гэж ойр ойрхон танайх өөрсдөө хуралдаж ийм бодлогын шийдвэртээ нөлөөлөөд байдаг юм? Улсын Их Хурлын гишүүд болон ард түмэн та бүхэнд үг хэлэх эрхтэй. Нөлөөлөх эрхгүй байж болно. Тэгээд өнөөдрийн энэ хурал маань Өргөдлийн байнгын хороо бас, 1 минут сунгаад авчих уу дарга аа.

О.Номинчимэг: Тэгье сунгая.

Б.Бат-Эрдэнэ: Өргөдлийн байнгын хороо өргөдөл ирсэн учраас авч хэлэлцэж байгаа. Одоо өнөөдрийн энэ асуудал бас нөлөөлж байгаад орох уу Энхтайван Ерөнхийлөгч өө? Танай Ерөнхийлөгчийг сүүдрийг нь ч хараагүй олон сар болж байна. Тэгэхээр өнөөдрийн энэ хуралдаан бас нөлөөлж байгаад орох уу гэдгийг би танаас асуух гэж байгаа юм.

Арилжааны банкны төлөөллүүд байна. Ахмадуудад ерөөсөө зээл олгохгүй байна та нар. Ямар үндэслэл, суурь шалтгаантайгаар зээл олгодоггүй юм бэ гэдгийг би асуух гэж байгаа юм.

Эрдэнэбат гишүүнээс би асуух гэж байгаа юм. Асуулга тавьсан гишүүн учраас. Энэ эх үүсвэр дээр танд яг шийдэл байгаа юм уу? Бид нар ингээд л Монголбанкийг шахаад л байдаг, Сангийн яамыг шахаад л байдаг, Засгийн газрыг шахаад л байдаг. Яах вэ Улсын Их Хурлын гишүүд тодорхой хэмжээнд шүүмжилж болж байна.

Гэхдээ бид нар эх үүсвэр дээр шийдэл байгаа юу гэдгээ бас олоод, тодорхой холбогдох төрийн захиргааны байгууллагуудтайгаа яриад, шаардлагатай тохиолдолд Засгийн газартай яриад энэ асуудлуудыг шийдвэрлэхийн төлөө байх ёстой. Тэрнээс биш Улсын Их Хурлын гишүүд гэдэг зөвхөн шүүмжлээд суугаад байдаг хүмүүс биш.

Нөгөө талдаа зээлийн хүүг бууруулах, тэтгэврийн зээлийн хязгаарыг байхгүй болгох тухай асуудал хөндөөд байгаа. Энэ дээр.../минут дуусав./

О.Номинчимэг: Эхлээд Монголбанкнаас Монголбанкны дэд ерөнхийлөгч Энхтайван. Индрийн микрофоноос.

Г.Энхтайван: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Монголбанкны Ерөнхийлөгчөөс Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбатад асуулгын хариу явуулахад эрсдэлийн жин хүүд том нөлөөгүй гэж тайлбар явуулсан байгаа. Тухайлбал, эрсдэлийн жинг одоо байгаагаас нь 50 нэгж хувиар бууруулахад сарын хүү 0.04 хувь буюу жилийн дүнгээр 0.5 хувиар хүү буурч байгаа. Бид бүхэн эрсдэлийн жингээр бууруулаад явсан тохиолдолд одоо байгаа зээлийн дундаж хүү 17.6-аас 17.1 хувь болж буурахаар тийм тооцоолол гарч байгаа.

Арилжааны банкин дээр урьд нь жишээлбэл, 2018 оны үед арилжааны банкин дээр Нийгмийн даатгалын ерөнхий газар, арилжааны банкнууд хамтраад гэрээ байгуулаад явж байсан. Тухайн үед 12 хувиар, 10.6-аас 11 хувийн хүүтэй эх үүсвэр байршуулж байсан байгаад байгаа. Тухайн үед Нийгмийн даатгалын ерөнхий газар. Тэр үед арилжааны банкнууд Гэр бүл, нийгмийн хамгааллын яамны хамтарсан гэрээний дагуу тухайн үеийн тэтгэврийн зээлийн 12 хувьтай олгоод явж байсан байгаад байгаа. Тэгэхээр одоо байгаа тэтгэврийн зээлийн эх үүсвэртэй холбоотой Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл 15 хувиар байршиж байгаа учраас зээлийн хүү дээр ийм эффекттэй байгаад байгаа.

Гишүүний дараагийн асуултад хариулахад бол Улсын Их Хурлын гишүүд иргэд, олон нийтээс ирсэн аливаа мэдээллийг Төв банканд дамжуулах эрхтэй. Тэгээд энэ дээр Улсын Их Хурлын өнөөдрийн Өргөдлийн байнгын хорооны энэ хуралдаан нь мэдээж Төв банкны бодлого үйл ажиллагааг олон нийтэд хүргэх, энэ чиглэлийн мэдлэг, мэдээллийг олон нийтэд үнэн, зөв байдлаар нь хүргэх, нөхцөл байдлыг тодруулах тийм зорилготой хурал байгаа учраас энэ бол Төв банкны хараат бус үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөхгүй байгаад байгаа.

Ер нь тантай санал нэг байгаа. Төв банкны зүгээс арилжааны банкин дээр бид бүхэн тусгай зөвшөөрөл олгоод явдаг. Энэ хүрээндээ бид бүхэн Төв банкныг аль болохоор Төв банкны зүгээс арилжааны банкнууд дээр энэ иргэдээс тавиад байгаа энэ шаардлагыг нийцүүлж бодож үзэж энэ зээлийн бодлогоо уян хатан байлгах талаар чиглэл хүргүүлдэг. Ер нь одоогийн байдлаар Төв банкнаас энэ 24 сар, 36 сартай холбоотой бүх зохицуулалтуудыг бүгдийг нь цуцалсан байгаад байгаа. Арилжааны банкнуудад 36 сараар зээл олгох эрх нь нээлттэй байгаад байгаа. Нээлттэй. Гэхдээ бодит амьдрал дээр бас эх үүсвэрийн дутагдал байгаад байгаа юм. Арилжааны банканд энэ хэмжээний мөнгийг буцаагаад олгох тийм эх үүсвэр нь дутагдалтай, эх үүсвэрийн зардал нь өндөр байгаад байгаа учраас бас эрсдэлээр тооцож байгаа.

Бид бүхний зүгээс мэдээж энэ заавал байлгах нөөцтэй холбоотой, энэ эрсдэлийн жинтэй холбоотой зохицуулалтыг макро зохистой бодлогын хүрээнд зохицуулаад явах боломжтой. Би тэгээд түрүүн хэлсэн 0.5 орчим хувийн хүүгийн дэмжлэг бол эрсдэлийн жинг бууруулаад явсан тохиолдолд гарах юм байна гэж үзэж байгаа. Ер нь суурь нөхцөл байдлын хувьд бодлогын инфляц буураад бодлогын хүү 12 хувьтай байгаа нь энэ буураад 10 дээр юм уу 9 дээр ирсэн тохиолдолд зээлийн хүү дагаад буурах ийм зохицуулалттай байгаад байгаа.

Тэгээд арилжааны банкнуудын хувьд энэ яг тэтгэврийн зээлийн зээл олголттой холбоотой асуудлууд дээр дэлгэрэнгүй хариулчих Хаан банк, Төрийн банк.

О.Номинчимэг: Арилжааны банкнууд хариулаарай. Одоо Монголбанкны юугаар чинь 36 сар гэж, 24 сар гэж хязгаарласан юм байхгүй гээд байна шүү дээ. Индэр дээр нэрээ хэлээд Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя.

С.Энх-Ирээдүй: Хаан банкнаас Энх-Ирээдүй асуултад хариулъя. Тэгэхлээр бид нарын зүгээс 12-18 сар дээр олгож байгаа. Зээлийн хүү маань 16.8 дээрээс эхэлж байгаа. Түрүүн ярьж байгаа зүйл нь болохлоор бид нар дээр эх үүсвэр байдаггүй. Хаан банкны зүгээс нийт татан төвлөрүүлж байгаа хөрөнгийн 12 сар дээрээс байгаа хугацаатай хадгаламжууд гээд 12.6 хувь дээр дунджаар тэгээд тэрнээс дээшээ иргэдийн хадгаламжийг татан төвлөрүүлээд эргээд бид нар дээр нэгэнт эх үүсвэрийн асуудлыг шийдэж өгөөгүй учраас хүнээс татан төвлөрүүлсэн эх үүсвэрийг буцаагаад тэтгэврийн зээл болгоод гаргаж байгаа.

Тэгэхлээр бид нар дээр одоогийн байдлаар 1.5 их наядын тэтгэврийн зээлийн багц байдаг юм. Энэ нь болохлоор манай нийт Хаан банкин дээр байгаа зээлийн багцын 9.8 хувь байдаг юм. Тэгэхлээр ер нь тэтгэврийн зээл Хаан банкин дээр 10 хувь арай хүрэхгүй зээлийн багцыг эзэлж байдаг гэсэн үг. Тэгээд энэ дотроо бид нар хамгийн бага зээлийн хүүг тэр 16.8 дээр буюу тавьсан байгаа. Яагаад гэхлээр өөрөөр хэлбэл түрүүн хэлснээр.../минут дуусав./

О.Номинчимэг: Микрофон нэмж өгье. Гүйцээж хариулъя.

С.Энх-Ирээдүй: Тэгэхлээр бид нарын зүгээс түрүүн хэлсэн хэрвээ чөлөөт үлдэгдэл байгаад эх үүсвэрийн зардлыг шийдээд өгөх юм бол арилжааны банкнуудын зүгээс тэтгэврийн зээлийн хүүг бууруулах дээр бүрэн нээлттэй байна гэсэн хариултаа өгсөн байгаад байгаа. Эсвэл хүүгийн татаасыг тусгаад өгөх юм бол бид нарын зүгээс үүн дээр хамтраад ажиллахад бүрэн нээлттэй байна гэсэн албан тоотыг бас хариугаар би хүргүүлчихсэн байгаад байгаа. Тэр энэ асуудлуудыг шийдээд өгөх дээр хамтран ажиллахад бүрэн нээлттэй байгаад байгаа. Ганцхан бусдаас татан төрүүлсэн хөрөнгө өөрийн гэсэн өртөгтэй. Тэдгээр дээр бид нар үйл ажиллагааны зардлыг нэмээд эрсдэлийн нэг аравны хэдхэн хувь ингээд эрсдэл нь бага учраас бид нар энэ дээр хамгийн бага хүүтэй зээл ингэж олгож чадаж байгаадаа үзээд байгаа юм. Тэгээд бид нарт эх үүсвэр байхгүй байгаад байгаад л сул тал байгаад байгаа юм.

Тэгье. Тэгэхлээр бид нар одоо Хаан банкны зээлийн нийт багц нь 15 их наяд байдаг юм. Тэрний 9.8 хувь нь буюу тэтгэврийн зээл байдаг гэсэн үг. 10 хувь нь арай хүрэхгүй. Өөрөөр хэлбэл 1.5 их наяд. Тэгэхлээр бид нарын нийт зээл олгогдож байгаа хүмүүсийн 60.../минут дуусав./

О.Номинчимэг: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн хариулъя.

С.Эрдэнэбат: Эх үүсвэрийн хувьд банкнууд маш тодорхой саналууд хэлсэн байж байгаа. Заавал байлгах нөөцийнхөө хэмжээг жоохон бууруулчихаач, эх үүсвэр гаргаж өгөөч. Заавал байлгах нөөц Монголбанканд нийт банкнуудын байгаа активын багагүй хувийг эзэлдэг. Өөрөөр хэлбэл, бусдаас татаж авсан, хүүтэй татаж авсан эх үүсвэрийг ямар ч хүүгүйгээр активынх нь одоо хэдэн хувь байна тээ тэр хэмжээг нь жоохон багасгачих юм бол тэр эх үүсвэрээрээ зээл олгочихье.

Тэгэхээр хүү буурна. Нөгөө талаараа бас хугацааны хувьд уян хатан болох боломж байна гэж хэлээд байгаа юм.

Тэгэхээр энэ бол Монголбанкны яг өөрийнх нь ба арилжааны банкнуудад оролцож энэ зээлийн хүү болон хугацаан дээр нөлөөлөх боломж нь байхгүй юу. Тэгэхээр манай Монголбанк болохоор арилжааны банкнуудад нөлөөлөхгүй гэж шууд хэлээд байгаа боловч нөгөө талаараа бодлогынхоо хэрэгслээр нөлөөлөх бүрэн эрх нь байгаа шүү дээ. Тэгэхээр энийгээ хэрэгжүүлээч л гэдэг би саналыг тавиад байгаа юм.

О.Номинчимэг: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Энхтайван Ерөнхийлөгч өө та хэд том нөлөө байхгүй л гээд байна шүү дээ. 0.5 хувь тийм том нөлөө биш гэж үзээд байна. Гэтэл 18 хувиас, таны хэлснээр 17.5 хувь болоход жилийн 1 ахмадад үлдэж байгаа мөнгө 60 мянган төгрөг байхгүй юу. Тэгээд ахмадад бол энэ жижиг нөлөө биш байхгүй юу. Та хэд том нөлөө биш гэж үзээд эрсдэлгүй гэж үзэж байгаа бол тэгээд л эрсдэлийн жинг нь 50 хувиар бууруулаад л өгчихгүй юү тээ? Монгол Улсад хамгийн ашигтай ажиллаж байгаа салбар бол банк шүү. Эрхэм банкны дарга нар аа та бүхний зээл, хүү сүүлдээ зарим тохиолдолд бүүр мөлжлөгийн хэмжээнд очиж байгаа шүү. Маш өндөр байгаа шүү. Тэр дээр арилжааны банкнууд тодорхой хэмжээний ахиц гаргах түвшиндээ цөөхөн хэдэн ахмад байхгүй юу чааваас та хэд өөрсдөө мэдэж байгаа шүү дээ. Энэ дээрээ.../минут дуусав./

О.Номинчимэг: Индрийн микрофон.

Г.Энхтайван: Бат-Эрдэнэ гишүүний асуултад нэмэлтээр тайлбар өгье. Эрдэнэбат гишүүн бас түрүүн хэлсэн заавал байлгах нөөцийн хэмжээ 13 хувьтай байгаад байгаа. Заавал байлгах нөөцийн хэмжээг Төв банк банкны зүгээс бүх арилжааны банкнуудад тухайн банкны өөрийн нэгдсэн эх үүсвэр татсан хэмжээнээс тооцож олгодог.

Хэрвээ бид хэд бол энэ дээр заавал байлгах нөөцийн хэмжээг инфляцтай уялдуулаад зах зээлийн нөхцөл байдалтай хамааруулаад тогтоодог. Заавал байлгах нөөцийн хэмжээг бууруулснаар чөлөөт эх үүсвэр бол арилжааны банкин дээр бол тодорхой хэмжээгээр нэмэгдэнэ. Заавал байлгах нөөцийн хэмжээг бууруулахад бас маш олон нөхцөл байдал тооцдог бид хэд. Тэтгэврийн зээлтэй холбоотой зээлийн үлдэгдэлтэй тэнцэх хэмжээний заавал байлгах нөөцийг эх үүсвэрийг хасаж нөөцөд, юу гэдэг юм хасаж тооцсон тохиолдолд ойролцоогоор 36.../минут дуусав./

О.Номинчимэг: Микрофон нэмэлтээр 1 минут өгье.

Г.Энхтайван: 36 орчим тэрбум төгрөгийн нэмэлтээр эх үүсвэр гарах боломжтой байгаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр заавал байлгах нөөцийн хэмжээн дээр бид бүхэн зохицуулалт хийгээд явах боломжтой байгаа.

Тэгэхдээ түрүүн хэлсэн бас энэ маань өөрөө бас бүр томоохон хэмжээний өөрчлөлт дээр бас харьцангуй нөлөө багатай. Хамгийн гол зүйл тэр банк, арилжааны банкин дээр эх үүсвэр дээр нь өмнө нь олгогдож байсан тэр 10-аас, 11-ээс 12 хувийн эх үүсвэр хүүтэй эх үүсвэр байршуулаад явсан тохиолдолд хүү 12 болоод буурах тийм боломжтой байгаа.

О.Номинчимэг: Одоохон эндээс тодруулчихъя. Юу сая хариултдаа хэдэн хувиар бууруулах юм бол зээлийн тэр жишээ нь дунджаар банкнуудад 9.8, 10 хувь нь зээлийн багцынх нь 10, тэр хувь нь ахмадын зээл байна шүү дээ тээ? Тэгээд энэ хэмжээгээр бууруулахад 36 тэрбум л гарна гэсэн үү? Тэрний тоог дахиад тодруулаад хэлээдхээч. Тоо их ч сонин өөр сонсогдоод байна. Индрийн микрофон Энхтайван Монголбанкны дэд ерөнхийлөгч.

Г.Энхтайван: Одоо байгаа тэтгэврийн зээлийн үлдэгдэлтэй тэнцэхүйц хэмжээний эх үүсвэрийг заавал байлгах их нөөцөөс ингээд хасчихаар нийт. Айн? 302 тэрбум.

О.Номинчимэг: 302 тэрбумыг хасахаар яана гэнэ?

Г.Энхтайван: 302 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний эх үүсвэр тэтгэврийн зээлд юу гэдэг юм гарах боломжтой болж үлдэнэ гэсэн үг.

О.Номинчимэг: Индэр дээр. Хэн нь ч байж болно шүү. Арилжааны банкнууд ч байгаа. Хэд хэдэн банкнууд байна шүү дээ. Төрийн банк, Голомт, Хаан банк хамгийн их тэтгэвэр. Төрийн банк хариулъя индэрт нэрээ хэлээд хариулт.

Б.Амарсанаа: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Төрийн банк Хууль, эрх зүйн хариуцсан дэд захирал Амарсанаа.

Төрийн банк өнөөдөр тэтгэврийн зээлийг хэвийн олгоод явж байгаа. 24 сар хүртэл олголтууд Төрийн банкны бүх нэгж дээр болон цахимаар олголт хийгээд явж байгаа. Яг өнөөдрийн байдлаар нийт Төрийн банкин дээр 58533 тэтгэвэр авагчийн зээл, зээлийн багцын дүн нь 307.3 тэрбумын зээлийн багц Төрийн банкин дээр байгаа. Цахимаар болон нийтдээ тэтгэврийн зээлдэгчийн тоо бол 58533 зээлдэгч байна. Тэтгэврийн зээлийн дүн нь 307 тэрбум 384 сая төгрөгийн зээлийн багцын ийм үлдэгдэлтэй байгаа. Төрийн банкны хувьд бол.../минут дуусав./

О.Номинчимэг: 300 тэрбумын үлдэгдэлтэй байгаа юм уу? Багц нь, үлдэгдэл нь? Тэгэхээр чинь сая Монголбанкны хэлээд байсан 320 хэдэн тэрбумын үлдэгдэл гэдэг чинь бараг ихэнх нь танайх дээр байгаа юм уу? Нэмэлтээр бүх тэр түрүүний асуултад илүү дэлгэрэнгүй хариулаадах. Микрофоныг нь хангалттай өгөөдхөөч индрийн.

Б.Амарсанаа: Нийт тэтгэврийн зээлтэй иргэдийн 19.8 хувь нь Төрийн банкин дээр байгаа гэсэн үг. 19.8 хувь. Яг тэтгэврийн зээлдэгчийн тоогоор 58533 тэтгэвэр авагчийн зээл байгаа. Зээлийн дүн нь 307 тэрбум 384 төгрөгийн тэтгэврийн зээлийн багцын үлдэгдэл яг өнөөдрийн байдлаар байгаа. Төрийн банкны тухайд Улаанбаатар хотын 80 нэгж, орон нутагт 21 аймаг 330 сумынхаа хүрээнд яг бүх нэгж дээр тэтгэврийн зээлийг хүсэлтийг хэвийн түвшинд шийдээд явж байгаа.

Хугацааны хувьд 24 сар хүртэл шийдэж байгаа. Банкны нэгжээр болон цахимаар гэсэн ийм 2 байдлаар ерөнхийдөө хүсэлтийг шийдээд явж байгаа. Хүүгийн хувьд 18-20.4 хувь хүртэл хүүтэйгээр. Банкны хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөлд нийт зарласан яг энэ хүүгээ мөрдөөд явж байгаа. Ер нь тэтгэврийн зээл олголт дээр Төрийн банкны хувьд бас аль болох уян хатан бодлоготойгоор хэрэгжүүлээд ажиллаж байгаа.

О.Номинчимэг: Зөвхөн Төрийн банкны хэмжээнд нийт тэтгэвэр авагчдын 20-оод хувь нь энэ банкнаас авдаг юм байна тээ? Тэгээд зээлийн багцаас нь харахад Хаан банкнаас хамгийн их тэтгэвэр авч таарч байна. Бат-Эрдэнэ гишүүн дахиад тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Монголбанк маань бид нар ч уулзсаар байгаад сурчхаж дээ. Тэгээд хариултаа л хэлсээр. Бид нарыг хуулиа уншдаггүй гэж боддог юм шиг байгаа юм. Та бүхэн бас тодорхой хэмжээний бодлого гаргах бүрэн эрхтэй шүү дээ. Тэр бодлогынхоо хүрээнд ямар боломжууд байна вэ гэдэг шийдлийг уул нь иймэрхүү хурал дээр сонсмоор байгаа байхгүй юу. Тэрнээс биш танай банк руу дайраад байгаа юм ерөөсөө байхгүй. Тэрийг нэг сонсмоор байна.

Хоёрдугаарт, Төрийн банк 24 сар хүртэл гэж байна. Жилийн 18-20.4 хувь гэнэ. Бусад банкнууд маань яг хэдэн сарын хугацаатай байна? Хэрвээ бусад бүх банк 24 сар хүртэл хугацаатай гэж үзэж байгаа бол та бүхэн картель хийж байна. Хоорондоо хэлэлцэн тохирч, хэлэлцэн тохирох хэлбэрээр тэтгэврийн хязгаар, тэтгэврийн зээлийн хязгаарыг тогтоож байна гэсэн үг. Энэ бол Монополын эсрэг газар та бүхнийг шалгах бүрэн үндэслэл болно.

Хоёрдугаарт, зээлийн хүү 18-20.4 хувь Төрийн банк. Бусад банк хэд байна?

О.Номинчимэг: Бүх арилжааны банкнуудын төлөөлөл гараад хэдэн сараар яаж, ямар нөхцөлд олгож байгаа гэдгээ хэлэх ёстой юм байна. Тийм үү, гэж асуулаа гэж ойлголоо Бат-Эрдэнэ дарга? Тэрнээс өмнө Монголбанк тодруулгаа, тодруулах хариулт. Индрийн микрофон.

Г.Энхтайван: Бат-Эрдэнэ гишүүний асуултад нэмэлт тодруулъя. Бодлогын шийдэл гээд тэгж байна. Төв банкны зүгээс зохицуулалтын л шийдлүүдийг гаргаж байгаа юм. Зохицуулалтын шийдлүүд. Түүнээс биш Төв банкнаас арилжааны банканд эх үүсвэр олгож энэ зээлийн үйл ажиллагааг шийдвэрлэдэг тийм юу гэдэг юм хууль, эрх зүйн орчин, боломж байхгүй.

Тэгэхээр эх үүсвэр дээр нь бид бүхэн ямар боломж байна гэхээр эх үүсвэр тал маань нөгөө талдаа Нийгмийн даатгалын ерөнхий газраас тавьж байгаа үлдэгдэл л байгаа арилжааны банкин дээр. Өмнөх 18-20 оны үед бол Нийгмийн даатгалын ерөнхий газраас үлдэгдлээ банкнууд дээр байршуулаад тухайн үлдэгдэл нь 10-11.6 хувийн хүүтэй байршаад 12 хувьтай зээл гаргадаг байсан. Одоо энэ үлдэгдэл маань 15 хувьтай байршаад байгаа. Тийм учраас 16 хувьтай зээл гараад байгаа. Нэгд нь.

Хоёрт нь бид бүхэн заавал байлгах нөөцтэй холбоотой эрсдэлээр жигнэсэн хувиа бас бууруулаад явлаа гэхэд хүүгийн хувьд та түрүүн хэллээ жилийн 0.5 хувийн хүү бол зээлийн хүү дээрээс нь хасагдах юм байна. Эх үүсвэрийн хувьд нийтдээ 300 орчим тэрбум төгрөгөөр зээлийн хэмжээ нэмэгдэх юм байна гэж байгаа юм. Тэгэхээр энэ дээр Төв банк бол зохицуулалтын арга хэмжээнүүдийг хийгээд явж болно.

Ерөнхий Төв банкны зүгээс өөрсдийн зүгээс авч байгаа бүх хязгаарлалтуудыг тэтгэврийн зээл дээр цуцалчихсан байгаад байгаа арилжааны банкин дээр. Арилжааны банкнуудын хувьд энэ 24 сарыг 36 сараар болгохгүй байна гэдэг дээр Улсын Их Хурлын гишүүд маань Төв банкнаас энэ дээр 24-өө

заавал 36-гаар олгооч гэдэг албадлагын арга хэмжээг арилжааны банкнуудаар аваач гэж хүсээд байх шиг байна. Энэ маань хуулиар бас хориотой. Арилжааны банк маань өөрөө хадгаламж эзэмшигчдийн мөнгийг бусдад зээлдүүлж байгаа. Тэгэхэд энэ хүнд тэдээр та зээл олгооч гэж арилжааны банкиг бид бүхэн тулгах тийм боломж хязгаарлагдмал.

Тэгээд Төв банкны зүгээс зохицуулалтынхаа хүрээнд тавигдаж байгаа шаардлагуудаа сулруулаад л явж байгаа. Тэтгэврийн зээлтэй холбоотой бүхий л шаардлагыг зээлийн өр, орлогын харьцааг нь байхгүй болгосон. Хугацааг нь байхгүй болгосон. Бид бүхний хувьд одоо ингээд авч байгаа бодлогын арга хэмжээнүүд аваад хэрэгжүүлээд явж байгаа.

Хамгийн сүүлийн арга хэмжээ нь тэр заавал байлгах нөөцтэй холбоотой арга хэмжээ. Заавал байлгах нөөцтэй холбоотой арга хэмжээ чинь нийт арилжааны банкны өөрийн системийн эрүүл мэндэд бас нөлөөлнө. Тэгэхээр бид энд энэ дээр болгоомжтой хандаж байгаа. Ер нь тантай санал нэг байгаа. Нөхцөл байдлыг бид бүхэн шийдвэрлэх ёстой. Заавал байлгах нөөцийн хэмжээн дээр бид бүхэн бас эргэж харахаар төлөвлөж байна.

О.Номинчимэг: Арилжааны банкнууд. Бат-Эрдэнэ гишүүний хэлж байгаа зөв шүү. Ер нь Монголбанк уг нь хараат бусаар мэргэжлийн ажиллах ёстой. Хуулиараа ч тийм. Тэгэхдээ яг үнэндээ тэгээд л Бодлогын зөвлөл, Хяналтын зөвлөлд улс төрчид ороод тэн дээр нь бужигнуулдаг юм ч гэсэн байгаа шүү дээ. Тэрнээс улс төрч нар өөрсдөө анхаарах хэрэгтэй шүү дээ. Санал нэг байна. Арилжааны банкнууд.

Н.Лхагвасүрэн: Та бүхэнд өдрийн мэнд. Голомт банкны төлөөлөл Зээлийн бодлогын хэлтсийн Лхагвасүрэн. Манай банк 1.4 хувиас эхлээд тэтгэврийн зээлийг олгож байгаа. Нийтдээ 246 тэрбум төгрөгийн багц байна. 18 хүртэлх сараар олгож байгаа. Яг өндөр настнуудын хэрэгцээт үе буюу цагаан сар болон наадмын үеэр бид нар 7 сард 24 сараар олгосон. Тэгээд нийт зээлийн багц огцом өсөж ирсэн. Эх үүсвэрийн зардал өндөр байгаа учраас бид нар хүүгээ өсгөх шаардлага үүссэн учраас 18 сараар хязгаарлаад байгаа. Хүү 1.4-өөр буюу хамгийн багаар тогтоод явж байгаа. Нэмэлтээр хязгаарлаж байгаа нэмэлт шалгуур энэ тэр байхгүй. 23 онтой харьцуулахад зээлийн багц 2 дахин өссөн үзүүлэлттэй байгаа.

О.Номинчимэг: Хаан банк ямар хугацаа. Дүгэрийн Рэгдэл гишүүн асуулт асууя.

Д.Рэгдэл: Баярлалаа. Энэ Эрдэнэбат гишүүнд их баярлаж байна. Бид нар зөндөө л тойрч ярьдаг баахан асуудлуудыг ингээд 5 багц болгоод асуучихсан юм байна Монголбанкнаас. Тэгээд энэний хариуг манай ирсэн улсууд ялангуяа энэ ахмадын төлөөлөл танилцсан болов уу гэж бодож байна. 5 асуултад тийм эерэг хариу ерөөсөө алга. Өөрөөр хэлбэл, Монголбанкны хариуг үндэслээд, хариултыг үндэслээд Байнгын хорооноос ямар нэгэн шийдвэр гаргах их боломжгүй юм. Энэ 5-ыгаа энэ хариултыг та бүхэн сайн үзээрэй. Монголбанк бол ингээд Санхүүгийн зохицуулах хороотой нийлж байгаад зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох аргачлалыг батлаад хэрэгжилтэд нь хяналт тавина гэж байгаа юм. Тэгсэн мөртөө бид нар энэ арилжааны банкиг өгч байгаа зээл дээр хязгаарлалт хийх, зохицуулалт хийх боломжгүй гээд байгаа. Энэ 2 чинь зохицохгүй байна шүү дээ. Хяналт тавьж байгаа юм бол хяналтын мөрөөр ямар ямар арга хэмжээ авч болдог юм бэ зээлийн хүүтэй холбоотой? Энэ асуултыг би Монголбанкнаас асуумаар

байна. Тэгэхээр аргачлалаа батлаад хянасан газар бол заавал тийм шийдвэр гаргах боломжтой л байж таарна шүү дээ одоо прокуророо бол.

2 дугаар хэсэг дээр энэ эхний асуулт дээр бас юм байгаа юм. Ингээд зээлдэгч тэр прайм хүүд үндэслэн тогтоох тийм зээлийн олгох зээлийн хүүг тогтоох. Зээлдэгчдэд олгох хүүгийн мэдээллийг ил тод, нээлттэй зарладаг болох боломжийг судалж байна гээд байгаа юм. Тэгэхээр энэ энэ прайм хүүд үндэслэн тооцдог энэ тогтоох энэ боломжоо хэдий хэр удаан судлах вэ, хэзээ хариу нь гарч ирэх вэ? Энэ тодорхой хариу өгөөч.

3, 4 дүгээр асуулт дээр бас л жаахан ойлгомжгүй юм байгаа юм. Түрүүн Бат-Эрдэнэ гишүүн бас асууна лээ. Тэтгэврийн зээлтэй холбоотой өмнөх шийдвэрийг нэр бүхий улс төрчид хөндлөнгөөс оролцож цуцлуулсан гээд байгаа юм. Энэ ямар ямар шийдвэрээр цуцлуулчихаад өнөөдөр тэтгэврийн хүүгийн нөхцөл ийм тааруухан муу байгаад байгаа юм гэдэг асуултыг асуумаар байгаа юм. Тэгээд энэнээсээ болоод энэ эрсдэлийг 150 хувиар боддогоо ер нь бууруулаад байх шаардлагагүй. Энэ чинь нөлөө багатай гээд байгаа юм. Жилдээ 0.5 хувийн нөлөөтэй. Энэ чинь шалтгаан биш баймаар байна.

Банкны эх үүсвэрүүдийн асуудлаар сая нэлээн тодорхой хариулт авчихлаа. Тэгэхээр тусгайлан бага хүүтэй зээл олгох тийм эх үүсвэр үүсгэх боломжгүй л гээд байна л даа. Банкнуудад байдаг хэрвээ би зөв ойлгосон бол банкнуудад байдаг хугацаанаасаа болоод энэ зээлийн олгох хугацаа хязгаарлагдаад байдаг юм байна. Тэгэхээр энийг эх үүсвэр энийг.../минут дуусав./

О.Номинчимэг: Рэгдэл гишүүний асуултад Монголбанк индрийн микрофон Энхтайван Монголбанкны дэд ерөнхийлөгч.

Г.Энхтайван: Рэгдэл гишүүний асуултад хариулъя. Тэр зээлийн хүүгийн тооцоололтой холбоо Санхүүгийн зохицуулах хороо манайх хоёрын тооцоололтой холбоотой асуудлыг манай Мөнгөний бодлогын газраас дэлгэрэнгүй хариулчих байх.

Бид бүхний хувьд тэтгэврийн зээлтэй холбоотой зохицуулалтуудыг анх энэ оны 3 сард Гэр бүл, нийгмийн хамгаалал хөгжлийн яамнаас Төв банканд хүсэлт ирүүлсэн. Хүсэлтээр тухайн тэтгэврийн зээл авч байгаа иргэний зээлээ төлөөд үлдэж байгаа төлбөр нь амьжиргааных нь доод түвшнийг хангах хэмжээнд байлгаж өгөөч гэдэг хүсэлтийг тухайн үед тавьсан. Яг Гэр бүл, нийгмийн хамгааллын яамнаас ирүүлсэн хүсэлтийнх нь дагуу Төв банк хуралдаад шийдвэр гаргасан.

Түүний дараа холбогдох нэр бүхий Улсын Их Хурлын гишүүд энэ асуудал чинь амьдралд нийцэхгүй байна. Энийгээ та бүхэн эргэж харах боломжтой юу гэдэг хүсэлтийг гаргасан. Үүний дагуу Гэр бүл, нийгмийн хамгааллын яамнаас дахиад Төв банканд энэ тавьсан хүсэлтээ больё гэдэг хүсэлтээр буцаагаад тавьсан.

Төв банкны Мөнгөний бодлогын хороо хуралдаад дахиад угаасаа зохицуулж байгаа Засгийн газрын зүгээс ийм асуултаа тавьж байгаа бол буцаагаад энэ зохицуулалтуудыг бүгдийг нь буцаагаад цуцалсан. Буцааж цуцлаад тэтгэврийн зээлтэй холбоотой ямар нэгэн зохицуулалт ерөөсөө байхгүй болсон.

Энэ дээр өр, орлогын харьцаа ерөөсөө мөрдүүлээгүй байгаад байгаа, хугацаан дээр нь ямар хязгаарлалт ерөөсөө тавиагүй байгаад байгаа. Одоо хүчин төгөлдөр байгаа журмаар ердийн нөхцөлтэй хэрэглээний зээлийн өр, орлогын харьцаа 50:50 хувь байгаа. Тэтгэврийн зээл дээр ямар ч хязгаарлалт байхгүй. Одоо байгаа тэтгэврийн зээлийн үлдэгдлээр өр, орлогын харьцаа нь 83 хувьтай байгаад байгаа буюу тэтгэврийн зээл авч байгаа нийт иргэд зээлээ нийт авч байгаа тэтгэврийнхээ 83 хувийг нь тэтгэврийнхээ зээлд эргүүлээд гаргачхаж байгаа гэсэн үг. Энэ бол маш өндөр хувь байгаад байгаа юм.

Тэгэхээр арилжааны банкнуудын хувьд өр, орлогын харьцаа дээр ямар ч тийм хязгаарлалт Төв банкны зүгээс тавихгүй байгаа. Хугацаан дээр нь тавихгүй байгаад байгаа. Яах вэ 24 сараар олгоод байна, 18 сараар олгоод байна гэдэг маань банк өөрөө эх үүсвэрээ иргэдээс 1 жилийн хугацаатай л авч байгаа. Ер нь дунджаар.

Тэгэхээр бас урт хугацааны зээл олгоход арилжааны банкин дээр өөрсдийн тийм эх үүсвэрийн тийм хугацааны тийм зөрүү гараад байгаа. Энэ дээр мэдээж Төв банкны зүгээс эх үүсвэрийн талд нь дэмжлэг үзүүлэх юм бол хамгийн үр нөлөөтэй, тэтгэврийн зээлийн асуудлыг шийдэх боломжтой гэж үзэж байгаа.

Зохицуулалтын зүгээс бид бүхэн мэдээж заавал ойлгох нөөцийн хэмжээг тодорхой хэмжээнд нь өөрчлөөд багасгаад тэгээд хугацааг энэ дээр бол заавал байлгах нөөцтэй холбоотой эрсдэлийн жин энэ тэрийг бууруулаад явах арга зам бол байгаа.

Гэхдээ энэ маань түрүүний хэлсэн эх үүсвэр талд нь шийдэхтэй харьцуулбал маш бага үр нөлөөтэй юм. 0.5 хувийн л тэтгэврийн хүүгийн зүйл зөрүүтэй. Энэ дээр бид бүхэн шийдээд ер нь явах тийм арга зам нь нээлттэй байгаад байгаа гэж л хэлье дээ.

Тэтгэвэр зээлийн тэр хүүгийн тооцоололтой холбоотой Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтарсан тийм тушаалаар гаргадаг. Энэ дээр яаж тооцдог талаар манайхан дэлгэрэнгүй тайлбарлачих.

О.Номинчимэг: Монголбанкны Мөнгөний бодлого уу? Мөнгөний бодлогын хэлтсээс дэлгэрэнгүй хариултыг нь өгчих. Индэр. Тийм түрүүний хэлсэн юмныхаа тооцоонуудыг бас нарийн мэдээлэл өгчихвөл. Дараа нь ажил хэрэгч жоохон шийдвэр гаргахад, шийдэлтэй байхад хэрэгтэй тоонууд байгаа шүү. Тийм тэрийгээ сонсчих юм бол бид ч гэсэн бас энд яаж гол нь сонсоод өнгөрөөх биш шийдэлтэй байх вэ гэдэг нь чухал болохоор тэрийг бас нарийвчлаад өгчхөөрэй тэгэх үү? Индрийн микрофон.

Н.Батболд: Мөнгөний бодлогоос Монголбанкнаас хэлтсийн захирал Батболд. Гишүүний асуултад нэмж хариулъя. Түрүүн хэлсэн Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга хамтран баталж байгаа болохоор зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох аргачлал байгаад байгаа. Энэ болохоор тухайн зээлийн хүүг тогтоохтой холбоогүй. Тогтоосон зээлийнх нь хувьд яг зээлийнх нь сарынх нь төлбөрийг хэрхэн тооцох вэ, хэрвээ хүүгээс хүү тооцдог байлаа гэж үзэхэд яг бодит хүү нь хэдээр байх вэ энэ тэр гэдэг яг тэрийг тооцсон тэгээд аргачлалыг нь хамтран баталж байгаа.

Тэгээд түрүүний тооцоотой холбоотой, түрүүний заавал байлгах нөөцтэй холбоотой тооцоог бага зэрэг дэлгэрүүлээд танилцуулъя гэж бодлоо. Яагаад 303 тэрбум төгрөг зүгээр сулрах тооцоо гарч байгаа вэ гэхээр одоогоор тэтгэврийн зээл олгож байгаа 5 банкны 9 сарын байдлаарх тэтгэврийн зээлийн үлдэгдэл маань өөрөө 2.3 их наяд төгрөг байгаа.

Энэ банкнуудын хувьд Монголбанкнаас заавал байлгах нөөцийг тооцож байгаа суурь маань өөрөө 30 гаруй их наяд төгрөг байгаа. Үүний төгрөгийн эх үүсвэрийн хувьд болохоор одоогийн зохицуулалтаар 13 хувийн заавал байлгах нөөцийн шаардлагыг тогтоож байгаа. Хэрвээ энэ сууриас тэтгэврийн зээлийн үлдэгдэл болох 2.3 их наядыг хорогдуулж тэрнээс нь заавал байлгах нөөцийг тооцох юм бол өөрөө заавал байлгах нөөцийн шаардлага маань өөрөө 300 орчим тэрбумаар шаардлага нь сулрах тийм тооцоо гарч ирчихсэн байгаа.

О.Номинчимэг: Рэгдэл гишүүн тодруулъя.

Д.Рэгдэл: Ямар ч байсан энэ 150 хувь гэдэг эрсдэлийг бууруулж болох юм байна. Тэгээд болох юм байна л гэж яриад байгаа. Энэ бага ч гэсэн нөлөөтэй учраас энийг хийчихмээр байгаа юм.

Хоёрдугаарт, тэр зээлийн хүү тооцоолох аргачлал энэ тэр гээд энийг чинь ойлголоо л доо энэ бичсэн юмыг. Гэтэл хяналт тавиад ямар хяналт тавиад яаж танай аргачлал зөрчигдөөд байвал ямар арга хэмжээ авдаг талаар юм хэлсэнгүй. Энийгээ хэлээд өгчихмөөр байна.

Гуравдугаарт, энэ хүү өндөртэй байхад би Засгийн газрын төлөөллөөс асууж байгаа юм. Хүү өндөртэй байхад манайд байдаг зарим нэгэн жишгээр энэ ахмадын тэтгэврийн зээлийн хүүгийн зөрүүг төрөөс даах боломж ер нь аль хэр байх вэ? Энийг тодорхой хэлж өгөөч гэж ингэж асуумаар байгаа юм.

Энэ хамгийн сүүлчийн 5 дахь асуудал өөр тэтгэврийн эх үүсвэрүүд яриад байгаа юм. Тэгэхээр энэ чинь олддоггүй шүү дээ ахмад хүнд. Энэ ингэж онол ярьж хэрэггүй. Энийг өгдөг тийм банк байхгүй шүү дээ ахмад хүн.

О.Номинчимэг: Монголбанкны Хууль, эрх зүйн газрын дарга Аюуш уу тээ? Рэгдэл гишүүний эхний асуултад хариулъя. Индрийн микрофон.

Д.Аюуш: Рэгдэл гишүүний Монголбанкны хяналт шалгалттай, банктай холбоотой асуултад тодруулга өгье. Төв банкны тухай хуулиар арилжааны банктай ямар хүрээнд Монголбанк харилцах вэ гэдэг зохицуулалт нь үндсэн суурь зохицуулалт нь явдаг. Төв банкны хуулийн 32.1 дээр байдаг. Энэ нь юу вэ гэхээр Монголбанк нь энэ хуулийн 12, 13, 16, 19, 20 дугаар зүйл болон Банкны тухай хууль тогтоомжийн дагуу банктай харилцана гэсэн зохицуулалт байдаг. Энэ хүрээндээ Банкны тухай хууль бид нарын нэрлэдэгээр урт нэртэй нэртэй хуулиар ямар ямар хүрээнд нь оролцох вэ гэсэн нарийвчилсан зохицуулалт нь орж ирдэг. Энэ хүрээнд бид нар юу гэдэг юм зохистой харьцаа, актив ангилал, банкны засаглалын асуудлууд, мөн Монголбанкны тухай хуульд заасан, 6 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрлийг өгөх, түдгэлзүүлэх, албадлагын арга хэмжээ авах гэсэн ийм хүрээндээ харилцаж оролцож байгаа.

Яг өнөөдрийн ярьж байгаа сэдвийн хүрээнд зээлийн хүүгийн асуудал, зээлийн гэрээ.../минут дуусав./

О.Номинчимэг: Хяналт шалгалтаа яаж хийдэг юм бэ? Журам чинь арилжааны банкнууд үнэхээр дагаж байна уу үгүй юү, энэ дээр та бүхэн ямар хугацаатай яаж хяналт шалгалтаа хийгээд, яадаг юм бэ гэдэг дээр тодорхой энгийн үгээр хариулчих. Индрийн микрофон.

Д.Аюуш: Энэ дурдсан хуулиудын хүрээнд Монголбанк хяналт, шалгалтаа хийдэг. Хяналт, шалгалт бол иж бүрэн шалгалт, хэсэгчилсэн шалгалт гээд ингээд явж байгаа. Түрүүн манай Батболд захирал хэлтсийн захирлын хэлсэнчлэн яг энэ өргөдөл, гомдлын дагуу шалгалт хийсэн. Энэ шалгалтын хүрээнд хянаж үзэхэд Банкны тухай хууль болоод энэ журмыг, хүү тооцохтой холбоотой журам зөрчсөн үйлдэл гарч ирээгүй. Хүүг давхардуулан бодож авсан, хүүгээс хүүд тооцож гэрээнд заасан буюу журамд заасан зөрчил гараагүй гэсэн хариултыг өгсөн байгаа.

Хэрвээ журам зөрчсөн бол ямар арга хэмжээ авдаг вэ гэхээр Банкны тухай хууль, Зөрчлийн тухай хуульд заасан дагуу бид нар холбогдох арга хэмжээг авдаг.

О.Номинчимэг: Дараагийн асуултад хэн хариулах вэ? Сангийн яам, Гэр бүл, хөгжлийн яамнаас ирсэн байгаа. Хариулаадхаач ийм боломж байгаа юм уу? Тэтгэврийн зээлийн хүүгийн татаас гэдэг зүйлийн боломж ер нь хэр байна? Үнэн бодитой хэлээд хариулчих л хэрэгтэй байна. Мэргэжлийн хүмүүстээ. Тэгье, индрийн микрофон дээр. Гэр бүл, хөгжлийн яам.

Ц.Ганцэцэг: Рэгдэл гишүүний сүүлийн асуултад хариулъя. Ер нь нийгмийн даатгалын хууль тогтоомжид тийм зохицуулалт байхгүй. Өөрөөр хэлэх юм бол тэтгэвэр барьцаалсан зээлээ авлаа, тэтгэвэр авагч нь нас барлаа, үлдэгдэл зээлийг төр батлан даана гэдэг юм уу Нийгмийн даатгалын сангийн үлдэгдлээс төлнө гэсэн зохицуулалт байхгүй. Зүгээр жилдээ 13.8 мянган хүн бас нас барж байна. Тэтгэвэр авч байгаа хүмүүсийн хувьд.

Тэгэхээр энэ хүмүүс хуулиар тухайн нас барсан сарын болон дараагийн сарын тэтгэврийг нь өгөх хуулийн зохицуулалттай. Энэ төсөв суугаад тэтгэврийг нь өгөөд явдаг юм байгаа. Түүнээс зээлийн үлдэгдлийг төлөх гэдэг юм уу, төр батлан даах, Нийгмийн даатгалын сан батлан даах тийм зохицуулалт байхгүй. Боломжгүй л гэсэн үг.

О.Номинчимэг: Бусад улсад тийм жишиг байна уу ингэж шийдэж байсан та хэд маань энэ хүрээнд судалсан юм байдаг юм уу бодлогын хүрээнд? Энэ асуудал аягүй их удаан яригдаж байгаа асуудал шүү дээ. Тэгээд гарц, гаргалгааны хувьд. Индрийн микрофон.

Ц.Ганцэцэг: Тэтгэвэр барьцаалсан зээл гээд ингэхээр ерөнхийдөө бараг л Монгол Улсад л байдаг гэж бид нар судалсан. Бусад орнуудад тэр тусмаа Японд маш сонирхоод ийм гэж ер нь байж болохгүй шүү дээ гэдэг асуудал тавьж байсан. Тэгэхээр олон улсын хувьд энэ байдаггүй жишиг гэж харж байгаа.

О.Номинчимэг: Тэгэхдээ манай Монгол Улсын нөхцөл байдал бас их өөр болохоор ялт ч үгүй бид ахмадууд маань тэтгэврийн зээл гэдэг юман дээр бас амьдарч байгаа хүмүүс их байна. Тэгээд энэ чинь өөрөө бид нар тэтгэврийн тогтолцоогоо л анх 90 хэдэн оноос хойш хийхдээ л алдчихсан. Дундуур нь баахан популист шийдвэрүүд гарсны л үр гай, нөлөө гэж харж байгаа шүү дээ. Бадамдоржийн Пунсалмаа гишүүн асуулт асууя.

Б.Пунсалмаа: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн амар амгаланг айлтгая. Сая бид нар төсөв дээрээ 8.6 хувийн нэмэгдлийг ахмадуудын тэтгэвэр, тэтгэмж дээр нэмэхээр тавьсан байгаа. Үүнийг бас ахмадууд маань бас хангалттай нэмэгдэл болж чадахгүй байна гээд ингээд. 36 сарын хугацаатай энэ зээлийн нөхцөлөө сэргээж өгөөч гээд маш их хүсэлт ирж байгаа юм. Маш их хүсэлт. Тэгээд сая энэ хурлын явцыг ингээд сонсож байхад 36 сарын хугацаатай зээлийн нөхцөлийг бид нар бууруулаагүй, энэ хэвдээ байгаа гэхихлээ тийм ээ. Тэгэхлээр энэ чинь хаана ер нь ингээд зөрүү гараад байна гэдгийг асууя.

Хоёрдугаарт нь энэ иргэд энэ 16.8-24 хувийн хүүтэй тэтгэврийн зээл байна. Энийг бууруулж өгөөч гэж байна. Тэгээд та бүхэнд энэ боломж нь юу байна?

Хоёрдугаарт, миний асуух гээд байгаа зүйл бол Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын Монголбанканд тайлбар хүргүүлсэн гээд бичиг дээр Монголбанк нь макро зохистой бодлого боловсруулж хэрэгжүүлэх хүрээнд тэтгэврийн зээлийн хэт өсөлтийг сааруулж гэж оруулж ирсэн байна л даа. Тэгэхлээр энэ тэтгэврийн зээл маань өөрөө макро эдийн засгийн хэт тэлэлт, мөнгөний нийлүүлэлтийг өсгөөд байна гэж үзээд байгаа юм уу? Жилдээ ер нь хэд орчим төгрөгийн тэтгэврийн зээл гаргадаг юм бэ бид нар? Цаашлаад бас тэтгэврийн зээлд 150 хувийн эрсдэлийн жинг тогтоож ажиллаж байна гэж байгаа байхгүй юу. Энэ тэтгэврийн зээлийн эргэн төлөлт хамгийн сайн өндөр эргэн төлөлттэй байдаг. Яагаад ийм өндөр эрсдэлтэй зээл 150 хувь тогтоож байна? Энэ өөрөө арилжааны банкнуудад асар их зардалтай орж ирж байгаа л даа. Яагаад гэхлээр арилжааны банкнууд чинь үүнд зориулж заавал байлгах нөөц, зохист харьцааг өсгөх хэрэгтэй болдог. Тэгээд энэ дээр манай Монголбанк ажиллах хэрэгтэй байна. Яагаад ийм тэтгэврийн зээлийг 150 хувийн өндөр эрсдэлтэй гэж үзсэн юм бэ? Энийгээ бууруулчихвал бид нарт цаана нь бас сая 300, 3 тэрбумын боломж байна гээд ярьчихлаа. Тэгэхлээр энэ талаар асууя.

О.Номинчимэг: Хэн хариулах вэ? Монголбанк уу? Монголбанк индэр дээр Энхтайван дэд ерөнхийлөгч. Ялангуяа тэр эрсдэл 150 хувь гэж үнэхээр байгаа юм уу? Тэр нь ноцтой сонсогдож байна шүү. Индрийн микрофон.

Г.Энхтайван: Пунсалмаа гишүүний асуултад дэлгэрэнгүй хариулъя. Тэтгэврийн зээлийн хэмжээ 2020 оны 1 дүгээр сард нь иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс 1 удаа төлөх 1 удаагийн хуулийг батлаад тухайн үед 19 оны эцэс дээр 757 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байсан зээлийг тэглээд нойл болгосон. Үүнээс хойш одоогийн байдлаар 2.8 дахин нэмэгдээд байгаа. 2.8 их наяд төгрөгийн бол тэтгэврийн зээлийн үлдэгдэлтэй. 2025 оны 10 сарын байдлаар 2.4 их наяд төгрөгийн тэтгэврийн зээлийн үлдэгдэлтэй байгаад байна.

Тэтгэврийн зээлийн хүсэлтийг хязгаарлах чиглэлээр 2023 оноос хойш буюу 2 жилийн өмнөөс эхлэн Гэр бүл, нийгмийн хамгааллын яамны тавьсан хүсэлтийн дагуу Төв банк арга хэмжээнүүдийг авч эхэлсэн. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2023 оны 3 сарын 16-ны өдрийн 02-693 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг харгалзаад 23 оноос тодорхой нөхцөлийг буюу 6 сараас дээш хугацаатай олгосон тэтгэврийн зээлийн сарын төлбөрөө төлсний дараах үлдэгдэл нь тэтгэврийн орлого нь амьжиргааны баталгаажих доод түвшнээс бага байхтай тухай зохицуулалтыг хийгээд хангасан, яг энэ заалтыг хангасан тэтгэврийн зээл 150 хувийн тэтгэврийн зээлийн эрсдэлийн жинг бид бүхэн бүрдүүлээд явж байгаа.

Ер нь тэтгэврийн зээлтэй холбоотой эрсдэлийн жинг бид бүхэн зээл тус болгон дээр 150 хувь буюу хувиар, тэтгэврийн зээл дээр 150 хувьтай байгаа. Тэгэхдээ үүнээс ч өндөр зээлийн эрсдэлийн жин мөрдүүлж байгаа зээлүүд байгаад байгаа. Ер нь зээлийн эрсдэлийн жинг 150 хувиас бууруулаад явахад түрүүн хэлсэн 50 хувиар бууруулаад явахад жилдээ 0.5 хувийн тэтгэврийн зээлийн хүүгийн бууралт гарч ирнэ. Арилжааны банкин дээр тухайн үедээ бас тэтгэвэр өр, орлогын харьцаатай нь бол заавал байлгах нөөц дээр нь өөрчлөлт ороод явсан тохиолдолд 300 орчим тэрбум төгрөгийн эх үүсвэр бол тооцогдоод нэмэлтээр гараад явах боломжтой байгаад байгаа.

Гэхдээ нэг зүйлийг бас яг ингээд хэлэхэд хэрвээ бид бүхэн тэтгэврийн зээлтэй холбоотойгоор юу гэдэг юм эрсдэлийн жинг ингээд бууруулаад яваад өр, орлогын харьцаа цуцалчихсан байгаад байгаа. Хэмжээн дээр нь арилжааны банкнууд бас ингээд 36 сараар олгоод явахад арилжааны банкнууд бас өөрсдийн өр, орлогын харьцаагаа нэмэгдүүлэх ч юм уу тийм дотоод шийдвэр гаргахыг бас үгүйсгэхгүй нөхцөл байдлаасаа хамаараад.

Тэгэхээр энэ дээр илүү аягүй хамгийн боломжит уян хатан чиглэл нь эх үүсвэр чиглэлд нь л өөрчлөлт оруулах нь Төв банкны зүгээс хамгийн үр дүнтэй арга юм л гэдэг тийм шийдлийг танилцуулж байгаа юм. Зохицуулалтын арга хэмжээнээсээ илүүтэйгээр яг эх үүсвэр талд нь бид бүхэн нэмэлтээр арилжааны банкнууддаа дэмжлэг үзүүлэх, эх үүсвэрийн зардлыг нь бууруулах чиглэлд л арга хэмжээ аваад л хамгийн илүү үр дүнтэй яг иргэнд очих тийм үр нөлөө нь хамгийн өндөр байх юм байна л гэж Төв банкны зүгээс харж байгаа.

Зохицуулалт дээр мэдээж бид бүхэн тантай санал нэг байгаа. Энэ дээр бид бүхэн зохицуулаад явах боломж нь нээлттэй. Гэхдээ энэ маань өөрөө бас яг иргэнд хүрч байгаа үр дүн болон үзүүлж байгаа нөлөө нь бас эх үүсвэртэйгээ харьцуулбал бас харьцангуй бага байх юм байна л гэж үзэж байгаа.

О.Номинчимэг: Бадамдоржийн Пунсалмаа гишүүн тодруулъя.

Б.Пунсалмаа: Тэгэхлээр макро зохистой ер нь макро эдийн засагт мөнгөний нийлүүлэлтийг өсгөөд байна, инфляцыг нэмэгдүүлээд байна гэж ингэж үзэх гээд байна л даа. Тэгэхлээр энийг 2.8 их наядын зээл гаргаж байгаа юм байна.

Гэтэл үүний хажууд төсөв чинь 34 их наяд, төрийн өмчийн компаниудын жилдээ зарцуулж байгаа хөрөнгө нь 26 их наяд гээд үүний хажууд асар бага хэмжээний зээлийг өгч байгаа. Тэгэхлээр энийгээ бид нар нэмэгдүүлчихмээр байна. Энэ ерөөсөө инфляцад тийм дараа учруулахаар ийм зүйл биш гэж бодож байгаа.

Хоёрдугаарт нь энэ эх үүсвэр байхгүй байна гэж хэлээд байх юм. Тэгэхлээр би энэ арилжааны банкнуудаас асуугаадахъя. Ер нь арилжааны банкнууд Төв банкин дээрээ байршуулсан үнэт цаас хэлбэрээр хэдий орчим төгрөг Төв банкин дээрээ байршуулж байгаа юм? Эндээсээ эх үүсвэрээ гаргаж болохгүй юм уу?

О.Номинчимэг: Индрийн микрофон.

Г.Энхтайван: Тэтгэврийн зээл нэмэгдээд энэ дээр инфляц дээр их хэмжээний дарамт үзүүлээд байгаа гэсэн тийм тайлбар ерөөсөө байхгүй. Ерөөсөө

байхгүй. Нийт хэрэглээний зээл бол өөрөө инфляц, төлбөрийн тэнцэл дээр бас тодорхой хэмжээний дарамт үзүүлдэг. Төв банкны жилд баримтлах мөнгөний бодлогын үндсэн чиглэл батлахад Улсын Их Хурлаас хэрэглээний зээлийн хязгаарлалтыг хумиач ээ буюу бизнесийн зээлийн өсөлтөө нэмээч гэдэг чиглэлийг Төв банканд сүүлийн 3, 4 жил дараалаад өгч байгаа. Энэ хүрээнд бид бүхэн зохицуулалтуудыг хийдэг.

Хэрэглээний зээл маань өөрөө бас төлбөрийн тэнцэл, гадаад валютын нөөц дээр бас сөрөг нөлөөтэй байдаг. Импортыг нэмэгдүүлдэг. Тэтгэврийн зээлтэй холбоотой яг энэ тэтгэврийн зээлийн хэмжээтэй холбоотой нь инфляц дээр тийм том хэмжээний нөлөө байхгүй байгаа. Тантай бол санал нэг байгаа. Бид бүхний дотооддоо хийсэн тооцоогоор тэтгэврийн зээлийн хэмжээг 36 сар болгоод хүүг тодорхой хэмжээнд бууруулаад явахад инфляц дээр 0.15-аас 0.23 хувийн л нөлөө гарч байгаа юм.

Ер нь энэ арилжааны банкнууд бас түрүүн энэ Төв банкны үнэт цаастай холбоотой асуудлуудаа банк тус бүр хэд байгаагаа дэлгэрэнгүй хэлчих байх. Ер нь Төв банкин дээр арилжааны банкны байрших үнэт цаасны хэмжээ 10 их наядтай байсан. 10 орчим их наядтай байсан сүүлд харахад. Банк.../минут дуусав./

О.Номинчимэг: Пунсалмаа гишүүний микрофон өгье.

Б.Пунсалмаа: Тэгэхлээр миний асууж байгаа асуулт нь энэ үнэт цаас хэлбэрийнхээ энэ эх үүсвэрээсээ одоо энэ тэтгэвэр дээрээ нэмж тавьж болох уу гэж асууж байгаа байхгүй юу арилжааны банкнууд.

О.Номинчимэг: Индрийн микрофон.

Г.Энхтайван: Төв банкнаас үнэт цаасыг арилжааны банкнуудад, арилжааны банкнууд өөрийн чөлөөт эх үүсвэрээ буюу заавал байлгах нөөцөө бодоод илүү гарч байгаа тэр хэмжээтэй холбоотой эх үүсвэрийг Төв банкин дээр үнэт цаасаар байршуулдаг. Одоо манай нийт арилжааны банкны актив маань өөрөө 67 орчим их наяд төгрөгийн активтай болчихоод байгаа юм.

Тэгэхээр байгаа хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа журмуудаа ингээд тооцоод үзэхээр 10 их наяд гэдэг маань өөрөө арилжааны банкны эрсдэл даах чадварын хамгийн доод хэмжээ байгаад байгаа юм. Тэгэхээр хэрвээ энэ хэмжээний мөнгийг ингээд хэрвээ бид бүхэн зээлд ингээд гаргаад явах юм бол зээлийн хүү эргээд л арилжааны банкны эрсдэлээс хамаараад өсөх боломжтой байгаад байгаа юм.

Тэгэхээр яг энэ үнэт цаасан дээр байршиж байгаа мөнгөнөөс илүүтэйгээр түрүүн хэлсэн тэр заавал байлгах нөөцтэй холбоотой зохицуулалт хийгээд 300 орчим тэрбум төгрөгийн эх үүсвэр суллаад явах нь илүү эрсдэл багатай нэг талаасаа.

Нөгөө талаасаа илүү бодлогын зохистой хэлбэр юм болов уу л гэж Төв банкны зүгээс харж байгаа. Ер нь энэ 10 их наяд.../минут дуусав./

О.Номинчимэг: Мөнхтулга гишүүн асуулт асууя.

П.Мөнхтулга: Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Өнгөрсөн хаврын чуулганд яг энэ сэдвээр анх шүгэл үлээж байлаа. Монгол Улсад хамгийн эрсдэлгүй зээл бол тэтгэврийн зээл юм гээд. Төр байгаа цагт тэтгэврээ тавьж л таараа. Тэгэхээр энэ зээлийн хүүг хамгийн бодит бага хэмжээнд авчрах боломжийг өнгөрсөн хаврын чуулганаас авхуулаад судалсан. Тэгээд энэ танхимд сууж байгаа хүмүүс бүгдээрээ л бид нарын өмнө нь хэлэлцүүлэг хийж байсан яг энэ сэдвээр яриад сууж байсан хүмүүс байна.

Монголбанк надад 2025 оны 9 сарын 25-нд А12 дугаартай энэ албан бичгийг явуулсан юм. Энэ дээр би юм хараад байгаа юм. 2020 онд, 21 онд бодлогын хүү 6 хувь байсан. Одоо бодлогын хүү 12 хувь байхгүй юу. Тэгтэл 21 онд бодлогын хүү 6 хувь байхад тэтгэврийн зээлийн хүү 15.1 хувь байсан. Одоо бодлогын хүү 12 хувь болчихоод байхад тэтгэврийн зээлийн жигнэсэн дундаж хүү нь 17.3 хувь болчихоод байгаа.

Тэгээд энэ хооронд чинь харин арилжааны банкнууддаа баярламаар юм биш үү? Энэ банкнууд маань, арилжааны банкнууд маань бодлогын хүүдээ хавчигдчихсан байгаа мөртөө л одоо 17.3 хувь. Зарим сая дурдсан тоонууд дээр 16.8 хувь гэдэг чинь арилжааны банкнууд энэ дээр ерөөсөө ашиг хийхгүй байна гэсэн үг тэтгэврийн зээл дээр. Хамгийн бага эрсдэлээр тооцоод ингээд яваад байгаа.

Тэгэхээр бид нар зохицуулалт нь хаана явах вэ гэхээр Монголбанкин дээр л байгаад байгаа. Монголбанкны тэр журмын 150 хувь гээд хамгийн эрсдэлгүй зээлийг эрсдэлтэй зээлийн хэмжээнд тооцчихсон байгаа тэр журмыг нэгд байхгүй болгох ёстой.

Хоёрт, тэр саяын олон дахин яригдаад байгаа тэр заавал байх үлдэгдлийг чөлөөлж 300 тэрбумыг гаргаж ирнэ. Ингээд ирэхлээр ер нь арилжааны банкнуудаасаа би бүгдээс нь санал авчихсан байгаа. Энэ дээр гол 4 банк бүгд саналаа ирүүлчихсэн. Одоо Хаан банк бол маш ажил хэрэгч 4 саналыг явуулсан байна лээ. Тэгээд ерөөсөө энэ 4 дээр ажиллалчихад бараг манай тэтгэврийн хүү нэлээн буугаад ирнэ.

Дээрээс нь Хаан банк бол нийгмийн хариуцлагын хүрээнд бид нар энэ 4 зохицуулалтыг Монголбанкин дээр хийгээд өгөх юм бол бид нар бараг ашиг хараад яах вэ, ахмадууддаа нийгмийн хариуцлагын хүрээнд ашиггүйгээр ажиллаад өгье гэсэн хүсэлтээ ирүүлчихсэн байна лээ.

Тэгэхээр бид нар бодлогын хүү 12 хувьтай байхад банкны “operation cost” гэж ярьдаг ажлын зардал, тэр теллерүүдийн цалин, байрны түрээс гээд энэ болгоноо тооцоход бодлогын хүү дээр хоёр аравны хэдэн хувийг нэмчихэд эрсдэлүүдээ хасаад явахад зээлийн хүү 14 хавь дээр буугаад ирэх боломжтой юм байна лээ. Нэмэлт 1 минутаа авчихъя тэгэх үү дарга аа?

О.Номинчимэг: Мөнхтулга гишүүнд нэмэлт 1 минут.

П.Мөнхтулга: Тэгэхээр өнгөрсөн хугацаанд маш олон удаа улс төрийн нөлөөлөл орж нийгмийн асуудал болоод хүрээд ирэнгүүт Монголбанк руугаа янз бүрийн шийдвэр өгөөд байсан учраас нэг бол чөлөөл, нэг бол цуцал, нэг бол буцааж олго гээд ингээд системийг нь доголдуулчихаад байгаа юм. Тэгэхээр энийг хэдүүлээ ерөөсөө хуульчилчихъя гээд би ингээд хуулийн төслөө бэлэн

болгочихсон, үзэл баримтлал нь бэлэн болчихсон. Одоо энэ намрын чуулганд өргөн барих гээд байж байгаа юм. Энэ дээр ерөөсөө маш товчхон зохицуулалт хийгээд л бол оо.

Банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дээр банк, иргэн хуулийн этгээд өөрийн болзол нөхцөлийн дагуу зээл олгож болох бөгөөд зээлийн хүүг өөрөө тогтооно гэчихсэн ийм заалт байгаа. Энэ заалт дээр зөвхөн тэтгэврийн зээлийг хамруулахгүй гэдэг энэ нэмэлт, өөрчлөлтийг хийгээд Монголбанкны дээр янз бүрийн улс төрч ч юм уу эсвэл сайд нь ирж нөлөөлөөд байдаг бол Их Хурлын тогтоол батлуулъя. Та бүхний шийдвэрийг Их Хурлын тогтоолоор баттай болгоод өгчихье.

О.Номинчимэг: 1 минут.

П.Мөнхтулга: Тэгээд ингээд хуулийг нь хөдөлгөөнгүй болгоод тогтоол гаргаад та бүхний үйл ажиллагааг ямар нэгэн улс төр ч юм уу ямар нийгмийн шахалтаар өөрчлөхгүй болгоод ингээд тогтсон системтэй болоод өгвөл банкандаа ч амар, Монголбанкандаа ч амар, Их Хурлын гишүүддээ ч амар байгаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр Монголбанкнаас асууж байгаа асуулт нь одоо та бүхнийг энэ улс төрийн хавчлагад юу гэдэг юм нэг сайд нь тэг гээд, нөгөө Их Хурлын гишүүд нь боль гээд ингээд шийдвэрийг чинь олон дахин гаргуулаад байна шүү дээ энэ дээр ямар эрх зүйн акт одоо Их Хурлаар үйлдүүлчихвэл та бүхэнд яг нэг тогтсон системтэй явахад бэлэн болох гээд байна?

Миний санал бол Их Хурлын тогтоол дээр 3 юм оруулъя гэж байгаа юм. Тэр 150 эрсдэлийг бууруулъя. 150 хувийн эрсдэлийг бууруулъя. Тэр заавал байх үлдэгдлээс хасъя. Ингээд дээрээс нь энэ тэтгэврийн зээлийг Монголбанкны журмаар бодлогын хүү дээр нэмэх нь тэдэн хувь гэсэн бат.../минут дуусав./

О.Номинчимэг: Монголбанк байр сууриа илэрхийлэх байна. Индрийн микрофон.

Г.Энхтайван: Мөнхтулга гишүүний асуултад тодруулъя. Тантай тэтгэврийн зээлийн нөхцөл байдалтай холбоотой энэ санал гаргаж байгаад Төв банкны зүгээс хариуг бид бүхэн дэлгэрэнгүй судлаад танд яг хариуг хэлье. Яг шууд яг би өнөөдөр яг тийм байна, ийм байна гэж бас яг тооцоогүйгээр хэлэхэд хүндрэлтэй байна. Бодлогын хүү 12 хувьтай байгаа. Энэ маань бас харьцангуй өндөр хүү байгаад байгаа.

Яг сүүлийн 7, 8 жилийн ч юм уу, 5 жилийн дунджийг харахаар. Сүүлийн жилүүдийн дундаж бол 9 хувьтай байгаад байгаа. Тэгэхээр бодлогын хүү дараа дараагийн жилүүдэд бас 9 хувь орчим дээр тогтворжих болов уу гэсэн бид бүхний хүлээлт байгаад байгаа юм. Тэгэхээр бодлогын хүү маань өөрөө зах зээлийн суурь эрсдэлийг тооцож байгаа, суурь төгрөгийн үнэ цэнийг тогтоож байгаа хүү. Тэгэхээр одоо байгаа 12 хувь дээр бодлогын хүү байхад арилжааны банкнууд хадгаламжийг 13-14 хувьтай иргэдээс татан төвлөрүүлж байгаа. Үүн дээрээ нэмээд бодлогын хүү дээрээ нэмэгдсэн үйл ажиллагааныхаа зардлыг тооцоод зээлийг гаргаад явж байгаа.

Тэгэхээр энэ дээр тэтгэврийн зээлийг бууруулах хамгийн үндсэн арга бол мэдээж энэ зардлын хүүгийн хамгийн гол бүрэлдэхүүн хэсэг болж байгаа энэ эх үүсвэрийн зардалтай холбоотой л асуудал. Арилжааны банкнууд мэдээж энэ заавал байлгах нөөцтэй холбоотой, хугацаатай холбоотой энэ зохицуулалтыг дагаж мөрддөг.

Төв банкны зүгээс энэ дээр уян хатан хандаад явах боломж нь нээлттэй байгаа. Тэгэхдээ энэ дээр уян хатан нөхцөл маань хандаад хандаад энэ маань суурь эдийн засгийнхаа нөхцөл байдалтай буюу инфляцтай бус, төлбөрийн тэнцэлтэй бус бүх юмтайгаа л уялдаад л явдаг. Тэгэхээр энэ маань бас урт хугацаандаа хэрэгжихэд бас хүндрэлтэй. 1 удаагийн чиглэлээр ингээд явахад.

Таны тавьж байгаа бодлогын саналуудыг бид яг дэлгэрэнгүйгээр нь яг заалт, заалтаар нь танд албан бичгээр яг хариу өгье. Ер нь арилжааны банкнууд энэ дээр тэтгэврийн зээлтэй холбоотой зохицуулалтуудыг өөрсдөө хийгээд явж байгаа. Төв банкны зүгээс энэ дээр ямар ч тийм юу гэдэг юм хязгаарлалтуудыг тавихгүй гэж Төв банк шийдэж байгаа. Гэр бүл, нийгмийн хамгаалал, хөгжлийн яам болон бусад байгууллагуудаас бид бүхэнд өөрсдийн саналаа илэрхийлдэг. Бид бүхний үйл ажиллагаанд хөндлөнгөөс юу гэдэг юм дарамт, шахалт үзүүлж тэгж оролцдог зүйл байхгүй. Зүгээр саналаа илэрхийлээд Төв банкны хараат бус Мөнгөний бодлогын зөвлөл энэ дээр өөрсдөө шийдвэрээ гаргадаг.

Мөнгөний бодлогын зөвлөл бол 7 хүнтэй. 7 хүний 4 нь хараат бусаар буюу Улсын Их Хурлаас томилогддог. Тэгээд олонхынхоо саналаар шийдвэрээ гаргаад явдаг. Ер нь тэтгэврийн зээлтэй холбоотой хэрвээ тухайлсан хууль гараад үйл ажиллагааг тэтгэврийн зээлийн зохицуулалтыг шийдээд явах юм бол энэ маань өөрөө Төв банкны тухай хууль, Банкны тухай хууль болон бусад холбогдох хуулийн зохицуулалтаас гараад тухайн яг тухайлсан хуулиар зохицуулагдаад явна. Энэ дээр тухайлсан хууль гараад яг энэ үйл ажиллагааг зохицуулаад явах боломж нь бол нээлттэй байгаад байгаа юм.

О.Номинчимэг: Жаргалсайханы Золжаргал гишүүн асууя.

Ж.Золжаргал: Би арилжааны банкнуудаас асуучихъя гэж бодож байгаа юм. Энэ тэтгэврийн зээлийг 18, 24 сар гээд 36 бил үү хамгийн урт нь, 30 бил үү айн? 36 сараар нь өгчихөд яагаад болдоггүй юм? Настай хүн үхчихнэ гээд эрсдэлтэй ангилалд ороод байдаг юм уу энэ талаар асуучихъя. Тэтгэврийн хүний ингээд тусгай нөхцөл гаргаад өгөөд байгаа нь хаашаа ч юм, зүгээр ийм үндсэн юу байгаа шүү дээ ялгаварлах, насаар ялгаварлаж болохгүй вэ гээд Үндсэн хуулийн заалт. Тэрийг бас бодмоор л юм шиг байдаг юм. Энэ 36 сараар өгөхөд ямар асуудал байгаад байдаг юм бэ гэж?

О.Номинчимэг: Арилжааны банкнууд хэн хариулах вэ? Хаан банк, Төрийн банк, Голомт банк индэр дээр очоод тэтгэврийн зээлийг 36 сар болгоход юу нь болохгүй байгаад байдаг юм бэ гэдэг дээр тодорхой хариулт авъя. Индэрийн микрофон Хаан Банк асуултад нь хариулъя.

С.Энх-Ирээдүй: Энх-Ирээдүй байна Хаан Банкнаас. Бид хэдийн зүгээс өмнө нь би бас саналаа илэрхийлж байсан. Хамтдаа, судалгаан дээр бид хэдтэй хамтраад судалгаа хийгээд өгөөч, бид хэд судалгааг нь хийгээд өгье өө гэсэн юм байгаад байгаа юм. Яагаад 36 гэдэг тоо, 18 гэдэг тоо гэж гараад байгаа юм бэ гэхлээр хадгаламж барьцаалсан зээл авсан өдрөөсөө 72 цагийн дотор тэр зээлийн

дүнгийн 75 хувь нь хувь хүний данс руу гүйлгээгээр гараад явдаг. Хувь хүний данс руу шүү. Харамсалтай байгаад байгаа биз.

Тэгэхлээр яагаад гэхлээр бид нар энэ жишээ нь түрүүний хэлснээр хэрвээ нэгэнт хугацаа хэтэрдэггүй ийм зээл бид нар ашгаа бодох юм бол 36 сараар тавьчих юм бол бид нар дээр ингээд зээлийн багц өсөөд ашигтай л байх гээд байгаа. Бид хэдэд байгаа судалгаа нь болохлоор энэ зээл өөрөө яаж зориулалттай зарцуулагддаг вэ гэдэг дээр асар их судалгаа хийдэг л гэсэн үг.

Дахиад саяын тоог хэлээд өгье. Нийт зээл олгогдонгуутаа олгогдсон өдрөөсөө 72 цагийн дотор нийт үнийн дүнгийн 75 хувь нь хувь хүний данс руу шилждэг байгаа. Тэгэхлээр энэ тэтгэвэр авагч юунд зарцуулаад байгаа юм бэ гэдгээ бид нар судлах гэхээр дандаа ингэж гараад явчихдаг. Тэгэхээр бид хэд хэрвээ өнөөдрөөс ингээд тэтгэвэр авагчдын хувьд хамгийн томоохон 2 цикл байдаг байхгүй юу. Цагаан сарын өмнө асар их санхүүгийн хэрэгцээ үүсдэг, наадмаар, тэгээд юун дээр бас үүсдэг юм намар бас үүсдэг юм.

Тэгэхээр хэдүүлээ жишээ нь бодчихъё. Ингээд дахиад 18 сарыг нь 36 болоод тавьчихлаа гэх юм бол одоо манай дээр байгаа 1.5 их наяд чинь шууд double-даад 3 их наяд болно гэсэн үг. Тэгээд тэр хүмүүс дахиад бүх зээлийг нь харуулахгүйгээр дахиад 18 сар нар үзэхгүй болж байгаа байхгүй юу. Тэгээд тэр мөнгө нь хаашаа явахыг би баталгаатай хэлж чадаж байна уу гэхлээр 3 хоногийн дотор иргэний данс руу 75 хувь нь гараад явчихна гэсэн үг.

Тэгэхээр хэдүүлээ өөрөөр хэлбэл би эмээгээ, би ээжийгээ, аавыгаа дахиад өнөөдрөөс эхлээд 36 сар нэг ч мөнгө үзүүлэхгүйгээр тэгээд тэр өгсөн мөнгө нь 72 цагийн дотор 75 хувь нь гараад явчихна гэж байна. Тэгээд би хүнлэг чанартай байх гээд байгаа учраас энийг 18 дээр байлгах гээд байгаа байхгүй юу. Энэ хүмүүс жилд 3 удаа цикл ядаж цагаан сараараа юмтай байгаасай, хичээл эхлэхийн өмнө юмтай байгаасай л гэж үзээд байна.

Тэгэхээр би энэ дээр өөрийн одоо миний өгч чадах амлалт би та бүхэнтэй судалгаан дээр нь хамтарч ажиллаж болно шүү гэж хэлэх гээд байгаа юм. Тэгэхлээр энэ дээр надтай хамтраад явна гэх юм бол багаа гаргаад энэ мөнгө юунд зарцуулагддаг вэ гэдэг та бүхэнд аягүй сайн ойлголтоор би өөрийн зүгээс хичээгээд ажиллаж болно. Энэ мөнгө яадаг вэ гэдэг дээр л хэлэх гэсэн юм. Тэгэхлээр ингэж судалгаан дээр л энэ циклийг бид нар бодоод байгаа юм. Хүмүүнлэг байдлаар ингэхгүй бол нар үзэхгүй дахиад 36 сар явах гээд байна шүү дээ. Цагаан сарыг нь би яаж хийлгэх юм бэ, намар болонгуут хичээлд ороход яах юм бэ л гээд байгаа юм.

Түрүүн хэлсэн угаасаа жишээ нь нийгмийн даатгал дээр хэрвээ чөлөөт эх үүсвэр үлдэх юм бол бид нар дээр 15 хувиар өгч байгааг би 16.8-аар л одоо өгч байгаа ... 15-аар авах боломжтой байсан юмыг 16.8-аар гаргаж байна гэдэг чинь энэ чинь яг түрүүний хэлж байгаа үнэн. Бид нар ямар ч “margin” нь байгаад байгаа юм байхгүй. Хамгийн бага хүү дээр л Хаан банк барьж ажиллаад байгаа гэсэн үг шүү. Бид нарын зүгээс нээлттэй. Түрүүн Монголбанкнаас тавьж байгаа зүйл үнэн шүү. Хэрвээ хүүг ярьа гэх юм бол асуултын 83 хувь нь эх үүсвэрийн зардлаас хамааралтай байгаа учраас хэдүүлээ татаас болон хүү дээр хамтраад ажиллачихвал энэ асуудлыг гаргаад шийдчихэж болно. Хүүг нь бууруулчихаж болно гэж. Хугацаа бол ийм ярвигтай зүйл байдаг юм байгаа юм гэж та бүхэнд хэлэх гэсэн юм. Баярлалаа.

О.Номинчимэг: Золжаргал гишүүн тодруулга 1 минут.

Ж.Золжаргал: 36 сар гэдэг нь нөгөө ахмадууд чинь аваад тэгээд мөнгийг нь үр хүүхэд нь авдаг юм уу хэн нэгэн аваад ингээд 36 сарын турш орлогогүй болчих учраас ингэж болохгүй юм байна гэдэг сайхан сэтгэлийн үүднээс гэж ойлголоо. Тэрнээс биш 36-гаар өгчих юм бол настай хүн үхчихнэ гэж ангилалд оруулаагүй юм байна гэж ойлголоо. Тэгэхээр зэрэг эрсдэлийг бодохгүй бол нийгэм өөрөө хямарч болзошгүй. Тэгээд бүх ахмадууд 36 сарын зээл авчхаад бүгдээрээ мөнгөө дор нь үрж хаяад байх юм бол тэр чигээрээ хямрал үүсэж болзошгүй байхгүй юу. Тэгэхдээ энийг би арилжааны банк ийм юманд санаа зовж байна гэдэгт л гайхаж байна л даа. Боллоо.

О.Номинчимэг: Саранчулуун гишүүн асуулт асууя.

О.Саранчулуун: Сайн байцгаана уу? Монголбанкнаас асууя. Тэтгэврийн зээлтэй иргэдийн ахмад настны дундаж “median” хэд байна? Хэдээс хэдэн настай хүмүүс нийт зээлийн хэдэн хувийг авч байна? Би дундаж асуугаагүй “median” асууж байгаа шүү. Тэрийг тайлбарлаад хэдэн хувь нь 50-60-тай, хэдэн хувь нь 60-70 гээд 10, 10-н насны түвшнээр, интервалаар хариулаадах уу?

Хоёрдугаарх нь арилжааны банкнуудаас, Монголбанкнаас үргэлжлүүлэе. Танайх 7 сарын 8-нд баталсан Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах арга хэмжээний тухай 79 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангахаар нэг судалгааг хийж эхэлсэн юм байна. Тэгээд тэр судалгаан дээр зээлийн хүүгийн мэдээллийг ил тод, нээлттэй болгохыг зарладаг боломжийн талаар судалж байгаа юм байна. Одоо 11 сар, 12 сар гарчихлаа. 5 сарын хугацаанд энэ судалгааны чинь үр дүн юу гарсан юм, ямар шийдвэр гарсан юм? Энийгээ тайлбарлая.

Арилжааны банкнуудаас асууя санаачилга гаргаад, гаргасан ийм Энх-Одыг бас сонслоо маш баяртай байна. Гэхдээ ер нь Монголбанк өөрсдөө юу гэдэг юм нийгмийн хариуцлагын хүрээнд гэдэг зүйлийг хийж өгөх боломжгүй ийм бодлого гаргадаггүй юм гэхэд арилжааны банкнууд өөрсдөө бас нийгмийн хариуцлагын хүрээнд гэдэг юм уу, ахмадуудад өөрөөр хэлбэл, ахмадууд чинь танай банкны хэрэглэгч шүү дээ нэг талдаа. Тэгэхээр тэд нарт зориулсан зээлийн бүтээгдэхүүн, санхүүгийн бүтээгдэхүүний ямар ямар боломжууд одоо байгаа юм ер нь? Ядаж өнөөдөр зээлийн хүү нь ингээд мөс шиг хөлдөхгүй, өөрчлөгдөхгүй. Хугацааг нь ингээд 36 болгохгүй гэж байгаа бол ямар настай, ямар ахмадад, ямар санхүүгийн бүтээгдэхүүн одоо яг банкин дээр байна? Хүмүүс тэрийг ядаж мэдэж аваг тэгэх үү? Тэгэхээр боломжоороо товчхон товчхон хариулаад өгөөч. Баярлалаа.

О.Номинчимэг: Саранчулууны гишүүнээс. Монголбанк индэр дээр хариулъя. Дараа нь арилжааны банкнуудаас асуусан асуулт.

Н.Батболд: Монголбанкнаас хэлтсийн захирал Батболд. Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Зээлдэгчийн насны ангиллаар яг ангилчихсан тоо хараахан байхгүй байгаад байна. Гэхдээ бид хэд 10 сарын байдлаар нийт 5 арилжааны банкнуудаасаа нийт 294 мянган зээлдэгчийн микро тоон өгөгдлийг авч шинжилгээ энэ тэр хийсэн байгаа. Энэхүү тооноос харахад зээлийн үлдэгдлийнх нь хувьд авч үзэх юм бол 1 зээлдэгч дунджаар 8 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа. Харин энэхүү 294 мянган зээлдэгчийн тархалтаар нь авч үзээд 10 дахь презентэйл дээрх утгыг нь авч үзэх юм бол зээлдэгч нь яг 10 дахь

пресентэйл дээр зээлдэгч нь гэх юм бол 1.2 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй. Харин 90 дэх пресентэйл дээрх утга нь гэх юм бол 14.3 сая төгрөгийн зээлтэй байна. Орлогыг нь авч үзэх юм бол энэ 294 мянган зээлдэгчийн дундаж орлого нь өөрөө 859 мянган төгрөг байна. Үүний хамгийн бага буюу 10 дахь, бага талдаа буюу 10 дахь пресентэйл дээрх зээлдэгчийн орлого гэх юм бол 572 мянган төгрөгийн орлоготой. Харин 90 дэх буюу харьцангуй өндөр орлоготой хүн нь гэх юм бол 1.3 сая, 1.4 сая төгрөгийн орлоготой байгаа.

Харин өр, орлогын харьцааг нь авч үзэх юм бол дунджаар энэ 294 мянган зээлдэгчийн дунджийг тооцох юм бол өр, орлогын харьцаа маань өөрөө 83 орчим хувьтай байгаа. Өөрөөр хэлэх юм бол дундаж зээлдэгч сарын орлогынхоо 83 хувийг зээлийн төлбөртөө өгөөд үлдэх 17 орчим хувь нь гар дээр нь үлдэж байна гэсэн үг дунджаар. Харин энэ үзүүлэлтийг бас 10 дахь пресентэйл дээрх утгыг нь аваад үзэх юм бол өр, орлогын харьцаа маань өөрөө 49 хувьтай.

Харин 90 дэх пресентэйл дээрх утгыг нь авах юм бол энэ харьцаа маань өөрөө 100 хувь байгаа. Өөрөөр хэлбэл, 100 хувь зээлдээ орлогоо татуулж байна гэсэн үг. Энэ дээр нэмээд хэлэхэд саяын ярьсан 294 мянган зээлдэгчийн хувьд нарийвчилсан тооцоо хийгээд үзэх юм бол нийтдээ зээлдэгчийн маань 45 мянган зээлдэгч бол 100 хувь, орлогоо 100 хувь тэтгэврийн зээлдээ татуулж байгаа гэдэг үр дүн гарсан байгаа. Тэгээд 90-100 хувийн өр, орлогын харьцаатай зээлдэгчдийн тоо маань өөрөө 70 гаруй хувьтай байгаа. Өөрөөр хэлбэл, нийт зээлдэгчдийн маань 70 гаруй хувь нь сарын орлогынхоо 90-ээс дээш хувийг зээлийнхээ төлбөртөө суутгуулж байна гэсэн үг.

Судалгааны үр дүн. Та хэлсэн Улсын Их Хурлаас тогтоол батлагдсан “Зээлийн хүүг бууруулах чиглэлд авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” гээд. Энэ хүрээнд тусгагдсан ажил нь гэх юм бол банкнуудын хамгийн эрсдэл багатай зээлдэгчтэй санал болгож байгаа буюу прайм хүү гэж нэрлээд байгаа хүүг нээлттэй, ил тод байдлаар зарладаг болох ажил тусгагдсан байгаа. Энэ хүрээнд Монголбанкнаас холбогдох журамд өөрчлөлт оруулаад одоогоор хуулийн дагуу олон нийтээс санал авах ажлыг гүйцэтгэж байгаа. Энэ бага хүүг харьцангуй эрсдэлтэй зээлдэгч санал болгож байгаа хүүгээ зарладаг болсноос ямар давуу тал үүсэх вэ гэхээр тухайн зээлдэгч болгон өөрийнхөө эрсдэлийн түвшнийг бас харах боломжтой байгаа. Энэ тухайн банк хамгийн эрсдэл багатай зээлдэгчтэй ийм хэмжээний зээлийг санал болгож байгаа юм байна. Миний хувьд болохоор ийм хүүгээр зээл авах боломжтой юм байна, миний эрсдэлийн нэмэгдэл ийм байна гэдэг. Мөн бусад банкнуудтай бас харилцуулах боломжтой. Мөн дунд, урт хугацаандаа ийнхүү суурь хүү, жишиг хүүг нээлттэй зарладаг болсноор зээл дээр хувьсах хүүтэй зээлийн зах зээл бас хөгжих боломжтой гэж гарж ирж байгаа юм.

О.Номинчимэг: Арилжааны банкнууд Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Индэрийн микрофон.

С.Энх-Ирээдүй: Энх-Ирээдүй байна. Хаан банкнаас. Арилжааны банкнуудад ингээд хүмүүсийн хэрэглээн дээр үндэслээд лизингийн байна уу, хэрэглээний байна уу, кредит картын байна уу гээд зөндөө олон бүтээгдэхүүн байдаг. Тэр нь өөрсдөө бүгдээрээ тусгайлан зориулалттай, тусдаа нөхцөлтэй. Ганцхан энэ тэтгэврийн зээл ямар ч зориулалт хамаа байхгүйгээр ингээд бүх “multi-purpose” гэдэг шиг олон зориулалттай зээл шиг олгож байгаа учраас ганцаараа ийм “universal” зээлийн бүтээгдэхүүнийг гаргаж өгсөн байгаад байгаа. Тэгэхлээр энэ өөрөө хэрэглээн дээр ч явдаг, лизинг дээр ч бүхий л зориулалтад

хэрэглэдэг ийм бараг цорын ганц бүтээгдэхүүн гэдэг шиг байгаа учраас энэ хамгийн хүртээмж сайтай уул нь санхүүгийн бүтээгдэхүүн юм байгаа юм. Зээлийнхээ юу талаасаа зориулалт болон нөхцөл талаасаа.

О.Номинчимэг: Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Сая Монголбанкны судалгааны дүнг харж байна. Тэгэхээр саяын ингээд насны range-ээр гаргадаггүй юм байна. Тэгэхдээ ер нь зээл олгоход, ер нь янз бүрийн зээлийн бүтээгдэхүүнийг гаргахад нийгэм, эдийн засгийн эрсдэл хүчин зүйл тэр дээр суурилад зээлүүд, зээлийн бүтээгдэхүүнээ тооцож байгаа шүү дээ. Тэгэхээр тэр шиг ахмадын зээлийн энэ 294 мянган хүн гэдэг чинь бараг Монгол улсын бараг нийт ахмадуудын бараг хэдэн хувь нь юм бэ тээ? Бараг ихэнх нь байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр энэ насны дүн, жингээр бодоод ч байдаг юм уу энэ зарим нь бараг нийт орлогынх нь 100 хувь байхад бүгдээрээ бас биш юм байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр нь тулгуурлаад Засгийн газарт ийм санал гаргаад, эрсдэлийг нь ингэж хувь гаргаад, арилжааны банкнууд энийг нь хариуцаад гэдэг ийм дундын бодлого энэ тэр гаргаад хийчхэж болдоггүй юм уу танайх чинь? Өөрсдөө тийм юм гаргах чиг үүрэг энэ тэр байхгүй гэсэн үг үү? Ер нь Монголбанк энэ дээр ямар санаачилга гаргах юм бэ? Одоо цаашдаа яах юм?

О.Номинчимэг: 1 минут тодруулна.

О.Саранчулуун: Одоо энэ гадаа энэ хүмүүс өнөөдөр энэ байдлаас чинь болоод түрүүчээсээ зарим хүмүүс нь нас барж байна шүү дээ. Энэ асуудлыг ямар ч байсан шийдлийг нь хүлээгээд. Тэгээд хүний үхэлтэй хүртэл ингээд оролцож байна. Тэгэхээр та нар энэ дээр санаачилга гаргаж, манлайлж шийдвэр гаргахгүй юм уу? Гол байгууллага нь юм чинь. Энэ дээр бодлогын шийдэл яриад байна шүү дээ. Тэгэхээр бид нар болохгүй болохгүй л гээд байх юм. Одоо тэгэхээр 36 сар болохгүй юм байна, хүүг багасгахгүй юм байна гэдэг хариултыг манай өнөөдрийн хурлаас гарч байгаа гэсэн үг үү? Хэдүүлээ энэ яриагаа нэг тийш нь болгож дуусгах ёстой шүү дээ?

О.Номинчимэг: Хариулъя. Тийм энэ шийдвэрийг мэдээж Улсын Их Хурлын гишүүд гаргана. Тэгэхээр энэ ингээд өнөөдрийн хуралдаанаар шууд шийдэгдэх гэхээсээ илүү бид нар бас дараа дараагийн арга хэмжээг авахаар төлөвлөж мэдээж шийдэлтэйгээ ажиллана гээд хэлмээр байна. Тодруулах юун дээр Монголбанк хариулах уу? Ямар судалгаа хийж байгаа юм? Танайх чинь уг нь судалгааны бүр багтай биз дээ тээ Монголбанкны? Ипотекийн зээл дээр нэлээн сайн судалгаа хийсэн байсан шүү дээ. Энэ дээр өшөө тийм юмнууд байна уу гэдэг дээр. Индрийн микрофон өгье.

Г.Энхтайван: Төв банкны зүгээс энэ тэтгэвэр, тэтгэмж барьцаалсан зээлтэй холбоотой судалгааг хийж гүйцэтгэдэг. Энэ хүрээнд нийт тэтгэвэр авагч, тэтгэврийн зээл авч байгаа иргэд маань зээлээ юунд зарцуулж байгаа, энэ нь эргээд тухайн ахмад настны нийгмийн асуудал, эдийн засгийн аюулгүй байдал, бусдаас хараат байх, бусдын халамжид орох гэх мэтчилэн нийгэм, эдийн засагт үзүүлж байгаа хувь хүний аюулгүй байдалтай холбоотой асуудал дээр нь Гэр бүл, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам бол судалгаа хийсэн байсан. Төв банкны зүгээс энэ нь өөрөө эдийн засагт хэрхэн нөлөөлж байгаа талаар өөр өөрсдийн бодлого, чиглэлийн хүрээнд судалгаа хийгээд явдаг.

Мэдээж энэ дээр тэтгэврийн зээлтэй холбоотой нэгдсэн бодлого буюу ахмад настны энэ амьжиргааны баталгаажих түвшнийг хэрхэн хангахтай холбоотой судалгаануудыг Төв банкны зүгээс, холбогдох яам буюу яг энэ асуудлыг бүрэн хариуцаж байгаа Засгийн газартай хамтраад бид бүхэн судалгаа хийгээд явдаг. Энэ дээр яг бидний зүгээс.../минут дуусав./

О.Номинчимэг: Нэмэлт 1 минут өгье. Индэрийн микрофон.

Г.Энхтайван: Тухайлсан яг юу гэдэг юм энэ тэтгэврийн зээл ийм байх ёстой, 36 сар чинь түрүүн бас гишүүн хөндөөд байна 36 сар чинь бүтэхгүй юм байна, зээлийн хүү буурахгүй юм байна энэ тэр гэсэн тийм шууд ийм өрөөсгөл шийдвэр ерөөсөө гарахгүй. Энэ дээр бид бүхэн нөхцөл байдлаа уялдуулаад хамгийн боломжтой нь яг юу байна вэ гэдэг дээр л бид бүхэн судалгаагаа чиглүүлээд явна. Бид бүхний хийсэн судалгаагаар хамгийн үр дүнтэй нь тэр эх үүсвэрийн зардал дээр нь бид бүхэн дэмжлэг үзүүлээд явах юм бол энэ хүү буурах, уян хатан болох хамгийн өндөр юу гэдэг юм боломжтой байгаад байгаа юм. Зохицуулалтын хувьд бид бүхэн арга хэмжээ аваад байна. Гэхдээ энэ маань урт хугацаандаа нөлөө их багатай, маш богино хугацаанд нөлөөлнө. Эргээд үзүүлэх сөрөг үр дагавар ихтэй юм байна гэдэг тийм судалгааны үр дүн гараад байгаа.

Тэр түрүүн гишүүн бас асуугаад байсан тэр праймрэт буюу эрсдэлгүй зээлийн судалгаагаа нийтлээч гэж байгаа юм. Энэ дээр бид бүхэн судлаад явж байгаа. Эрсдэлгүй зээлийн доод хэмжээг ерөнхийдөө дэлхийн бүхий л банкууд гаргадаг. Энэ дээр судалгаа гарахад 24.../минут дуусав./

О.Номинчимэг: Гишүүд асуулт асууж дууслаа.

Нэлээн бас энэ чухал олон ахмадуудын асуудал энд яригдаж байгаа болохоор манай Өргөдлийн байнгын хорооны гишүүд бас идэвхтэй тэр тодруулах асуултууддаа мэдээллүүдийг авлаа гэж бодож байна.

Асуулт асууж дууссан учир уг асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Үг.

Саранчулуун гишүүнээр тасаллаа. Манай гишүүд маань бас энэ дээр бид нар ажил хэрэгч ямар шийдэлтэй байх вэ гэдэг дээр байр сууриа илэрхийлээд, энэнээс цаашлаад бас Байнгын хорооноос юу хийх вэ гэдгээ ч гэсэн бид бас ярилцах хэрэгтэй байгаа учраас энийг бас анхаарахыг хүсье. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн үг хэлнэ.

Д.Эрдэнэбат: Тэгэхээр энэ ахмадын асуудал гээд яагаад ингээд гишүүд дахин дахин тавиад асуудалд ингээд хандаад байгаа вэ гэхээр яах аргагүй манай нийгмийн зорилтот, бас эмзэг гэж хэлж болохуйц ийм бүлгийн асуудал байгаа юм. Энэ хүмүүс бол зүгээр мөнгө өгөөч, миний зээлийг тэглээд өгөөч ч гэдэг юм уу ийм зүйл тавиагүй. Өөрт нь олгож байгаа ганцхан боломж нь тэтгэврийн зээлийн асуудал байгаа. Дээрээс нь бид нар тэтгэврээ олигтой нэмж чадахгүй байна. Тэр Япон тэр барууны орнуудын хийсэн судалгаа гэдэг чинь тэд нарын нөхцөл шал өөр байна. Тэд нар чинь үндсэндээ дундаж тэтгэвэр нь бараг 2, 3 мянган доллар байдаг хүмүүс. Бид нар чинь өнөөдөр 200 доллар байдаг хүмүүс байхгүй юу.

Тийм учраас энэ Монгол улсыг нэг айл өрх гээд аваад үзэх юм бол яах аргагүй олон хүний асуудал 540-өөд мянган ахмадын асуудал байж байгаа. Тийм учраас энэ тал дээр та бүгд маань нэгдүгээрт нийгмийн хариуцлагын асуудал. Хоёрдугаарт, бодлогын асуудлууд байж байна.

Тэр түрүүн 0.5 хувь бол тийм их нөлөө биш гэж байна. Дундаж ахмадын авч байгаа зээлтэй нь харьцуулаад үзэх юм бол сард 50-60 мянга, заримд нь 100 мянган төгрөгийн зээлийн хүүгийн хүү буурах. Тэгэхээр бид нар чинь ахмадын тэтгэврийг 60 мянгаар, 100 мянгаар нэмэх гэж бөөн юм болоод байгаа шүү дээ сар болгон. Тэгээд энэ чинь өөрөө ахмадуудад их юм байхгүй юу. Тийм учраас тэр 50 хувийн, 150 хувь гэж байгаа юм. Жирийн зээлүүд нь 100 хувь гэж байхад 150 болгоод тавьчихсан. Би энийг магадгүй өөр эрсдэлтэй баахан зээлүүдийн эрсдэлийг ахмадуудад үүрүүлээд байгаа юм болов уу гэж харж байна. Тийм учраас энийгээ нэгдүгээрт Монголбанк маань эргэж авч үзээд 100 хувь болгочих Энхтайван Ерөнхийлөгч өө Мөнгөний бодлогынхоо зөвлөлөөр. Энэ чинь бас арилжааны банкнуудад хүүгээ бууруулах зээл яах боломж бас гарч байна шүү дээ зардлаа бууруулах.

Хоёрдугаарт, заавал байлгах нөөцийнхөө хэмжээг бууруулчих. Энэ тал дээр тодорхой зорилтот бүлэг гэдэг үүдээд. Энэ чинь өөрөө ахмадын тэтгэвэр өөрөө онцгой төрлийн нэг талаараа төр өөрөө баталгааг нь аль хэдийн гаргачихсан байхгүй юу энэ хүмүүст чинь. Цалин бол өөрөө юу гэвэл тэр хүн ажилгүй бол төлөхгүй байх эрсдэлтэй байдаг бол, тэтгэвэр бол тэр хүн амьд л байвал төлдөг. Одоо бүр өвлүүлэх, тодорхой хэмжээг нь хэрэглэж болох ч гэдэг юм уу ийм зүйлүүдийг нь бодлогоороо Нийгмийн даатгалын хуулиар оруулаад өгчихсөн байж байгаа. Тийм учраас энэ тал дээр та бүгд маань арга хэмжээ аваач гэдгийг хэлмээр байна.

Дээрээс нь тэр ахмадуудын зээлийн төрлүүдийг нэмэх юм бол энэ зөвхөн тэтгэврийн зээл гээд л ингээд л заавал 36 гээд байх юм байхгүй. Энэ төрлүүдийг нь нэмээд өгөөч гэдэг дээр би арилжааны банкнууд, Монголбанк маань судалж байгаа боломжтой л гээд тавиад байгаа. Гэхдээ яг бодит байдал дээр ахмадуудад олдохгүй байна аа.

Арилжааны банкнууд маань 36 сар болонгуут шууд double-даад өсчихнө энэ тэр гэдэг бас шууд арифметик механик тийм тооцоо хийж болохгүй л дээ. Зарим нь яг ний нуугүй хэлэхэд ингээд 24-ийг авчихсан хүн маань 4 сарыгаа төлөөд буцаагаад дахиад 4 сарыг авчихмаар байгаад байдаг. Нэг талаар эрсдэлд орчихсон нь үнэн. Тэгээд энэ циклээс гарах хугацаа хэрэгтэй байна гээд байгаа юм. Энэ чинь нөгөө талдаа бас амьжиргааны асуудал байгаад байгаа учраас энийг нь харж үзээд банкнууд Монголбанк тал талаасаа шаардлагатай арга хэмжээгээ аваад өнөөдөр бол ахмадууд бид нараас бодит үр дүн хүлээж байна. Тэгэхээр энэ тал дээр нь та бүгд маань сэтгэл гаргаад. Өнөөдөр бол энэ маш чухал чухал бас би судалгаануудыг харлаа, боломжуудыг харлаа. Монголбанк маань бас тодорхой ийм бодлогын хүүг 9 хувь руу оруулах боломжтой гэж ярих шиг боллоо 3 функтээр бууруулах. Энэ чинь зээлийн хүү буурна гэсэн үг.

Тийм учраас энэ гадаад, дотоодын тэр “Moody’s” агентлаг дээр манай санхүүгийн чадавх сайжраад үзүүлэлт дээшлэх тусам хүү буурах ёстой. Тийм учраас ахмадууд хүүг бодитоор бууруулах, хугацааг бүх ахмадууд 36 сар авах гээд байгаа юм ерөөсөө байхгүй. Сая одоо харлаа шүү дээ тийм үү? Харьцангуй энийг эрт тэтгэвэрт гардаг өндөр тэтгэвэртэй хүмүүс нь дийлэнхийг нь авдаг юм байна.

Тэр юун дээр дийлэнх нь байгаад байна шүү дээ тийм үү? Тийм учраас энэ нөхцөлийг нь харж үзээд зээлийнх нь уян хатан нөхцөлийг нь шийдээч гэдэг ийм л үгийг хэлмээр байна.

О.Номинчимэг: Сонгобайн Замира гишүүн үг хэлье.

С.Замира: Баярлалаа. Сая Хаан банкны захирал билүү энэ залуу их л санаа зовж байна шүү дээ 30 хэдэн сараар авахад дараа нь яах уу хөөрхий ахмадууд гээд. Тэр шиг Монголбанкныхан толгойгоо ажиллуулаач. Бид мэдэхгүй, арилжааны банк мэднэ гээд ингээд суугаад байхын оронд бодлогоо нэг тийшээ чиглүүлчих. Яагаад гэвэл та хэд маань дараа дараачийн жилүүдэд бас өрснөө бас тэтгэвэртэн болно, тэтгэвэрт гарна. Тэрийг бодоорой.

Тэгээд энэ сая Нийгмийн даатгалын газраас ярилаа тэтгэврээс гарсан үлдэгдэл мөнгийг арилжааны банкнуудад байршуулаад хүүг нь өсгөх юм байна шүү дээ. Тэгэхээр тэгж хүүг нь өсгөөд, ахмадууддаа өгөөд дахиад хүүг нь өсгөөд давхар давхар бас банкнууд ашиг олж байгаа юм шиг надад тийм мэдрэмж төрлөө л дөө. Эсвэл би буруу бодоод байна уу? Тийм учраас ахмадууд яг 36 сараар тэтгэвэр авъя гэсэн нэг хэсэг нь байна. Бүгд биш шүү. Нэг хэсэг нь 24 сараар, нэг хэсэг нь бүүр зээл авахгүй энэ бүх ахмадууд. Гуйлгуулж байгаа юм шиг тэгж харж хандаж болохгүй.

Тийм учраас та нар сая гишүүний хэлснээр бодлогын зогсолтоо хийгээд зөвхөн тэтгэврийн зээл гэхгүйгээр бусад бас зээл авах боломж гаргаач. Тэтгэвэртэй хүн байр авъя гэхээр нь өгдөггүй юм байна лээ шүү дээ. Тэтгэвэртэй хүнд бүрт бид байр өгөхгүй. Тэтгэвэр нь бид нарт тэр чинь барьцаа болохгүй гээд. Тэгэхээр бидний бодлого гэж нэг юм ярина. Байхгүй болчихсон байна аа. Тийм учраас энэ тэтгэвэрт байгаа хүмүүс ядраад, ядарсандаа л болоод ингээд явж байгаа юм. Энэ дээр толгойгоо ажиллуулаад дараа нь ингээд хурал хийхэд яг шийдэл, шийдэл шүү тэрийг хэдүүлээ ярьж тэгэх үү. Баярлалаа.

О.Номинчимэг: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн үг хэлнэ.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Энхтайван Дэд ерөнхийлөгчтэй сайн байцгаана уу гэж мэндлэхээр түвшинд л оччихсон юм шиг байна. Хоёр талтай л юм яриад байна л даа. Нэг хүн яваад байна уу, хоёр хүн яваад байна уу? Ойлгохгүй байна таныг ний нуугүй хэлэхэд. Та энэ Монголбанкны Ерөнхийлөгчийнхөө яг энэ ирүүлсэн бичигтэй санал нэг байгаа юм уу, эсрэг саналтай байгаа юм уу? Яагаад гэхлээр гишүүдийн ярьсан юман дээр тантай санал нэг байна гээд яриад байх юм. Тэгээд гишүүд чинь дандаа энэний эсрэг юм яриад байна шүү дээ.

Тэгэхээр та Монголбанкны Ерөнхийлөгчийн буюу өөрийнхөө дээд, дээр байдаг албан тушаалтны эсрэг зүйлийг яриад байна гэж зүгээр хувь хүнийхээ хувьд би ойлгоод байна. Тэгээд санал нэг байгаа юм бол тэгээд хэдүүлээ өөрчилье л дөө. Хэрвээ өөрчилж чадахгүй юм бол наад албан тушаал дээрээ байх шаардлага юу байгаа юм. Ийм жижүүрийн үгтэй болчихсон яваад баймааргүй байна Энхтайван Ерөнхийлөгч өө. Монголбанкны албан тушаалтнууд шиг тэтгэврийн ахмадууд гараад валютын ханшийн зөрүү дээр ажилладаггүй шүү. Энийг би албан ёсоор хэлмээр байгаа юм.

Яагаад өнөөдөр энэ асуудал хөндөгдөөд байгаа вэ гэдгээ л бид нар бодох ёстой байхгүй юу. 36 сарыг ойлгож байна. 24 сарыг ч ойлгож байна. Ахмадуудад

дарамт болж байгаа. Өрнөөс өрний хооронд яваад дуусаж байгаа нэг талдаа. Тэтгэвэр гэж авч чадахаа больчихоод байгаа. Энэ үнэн.

Гэхдээ та бид нар энийг зохицуулахгүй гэж яриад байх шиг байна. Та нарын зохицуулах үүрэг чинь инфляц, бодлогын үр шүү дээ. Тэгвэл яагаад бараа, бүтээгдэхүүний чинь үнэ өсөөд, яагаад бодлогын хүч нь нэмэгдээд, яагаад инфляц чинь нэмэгдээд яваад байгаа юм? Энийг чинь дагаад л асуудал үүсчхээд байгаа шүү дээ. Та нарын хийх ёстой үндсэн ажил чинь энэ шүү дээ. Тэгээд энэ үндсэн ажлаа хамгийн муу хийхээд тэтгэврийн зээл, тэтгэвэртэй холбоотой асуудал дээр манай Монголбанк хөндлөнгөөс нөлөөлөхгүй гээд суугаад байгаа чинь өөрөө үндсэн уг асуудлаа углуургаар нь ойлгохгүй байна л гэсэн үг байхгүй юу.

Яагаад өнөөдөр өнөөдөр энэ асуудлыг бид нар 2025 оны 12 дугаар сарын 2-ны өдөр хэлэлцээд сууж байгаа юм. 2016 онд улсын дундаж цалин 800 мянга байсан байхгүй юу. Өнөөдөр 2025 он. 9 жилийн өмнөх дээр энэ ахмадуудын чинь авч байгаа тэтгэвэр гацчихаад байна шүү дээ. 2016 онд “Атар” талх 1100-1200 төгрөг байсан юм. Би өөрөө Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын даргаар ажиллаж байсан. Бүүр сүүлд гуйж байж 2020 онд “Атар” талхны үнийг надаас зөвшөөрөл манай Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас зөвшөөрөл авч байж нэмж байсан юм. 2016 онд 1100-1200 төгрөгийн үнэтэй байсан “Атар” талх өнөөдөр өдөр 2400-2700 төгрөг болчихоод байгаа байхгүй юу. Тэгээд яаж энэ ахмадуудын чинь тэтгэвэр нэмэгдээгүй, зээлийн хүү, илүү дутуу асуудлууд нь бөөн дарамт болчихсон байж байхад өнөөдөр ийм зүйл яриад зогсож чадаж байна гэдэг дээр чинь би гайхаад байгаа юм. Тийм учраас би тантай сайн байцгаана уу гэж мэндэлмээр байна, түвшинд очжээ гэдгийг хэлэх гээд байгаа юм.

Инфляц чинь сар болгон нэмэгдэж байна шүү дээ. Сар болгон өөрчлөгдөж байна шүү дээ. Сар болгон 0.2, 0.3, 0.4 функтээр өөрчлөгдөөд байгаа байхгүй юу. Энийг чинь дагаад бараа, бүтээгдэхүүний чинь үнэ бараг өдрөөр өөрчлөгдөж байна шүү дээ. Тэгээд та нар яаж инфляцыг барьж чадаагүй байж байж, бодлогын хүүгээ барьж чадаагүй байж байж өнөөдөр энэ арилжааны банкнуудтай бид нар хөндлөнгөөс нөлөөлж чадахгүй ээ, энэ байж байгаа зарчмаараа явна гэж яриад байгаа юм? Энэ олон мянган ахмадуудын асуудлыг яаж шийд гээд байгааг чинь би ерөөсөө ойлгохгүй байна. Улсын Их Хурлын гишүүдийн хувьд ч гэсэн бид нар өөр өөрсөд дээрээ анхаарлын тэмдэг тавьж ажиллах ёстой цаг хугацаа болсон ний нуугүй хэлэхэд. Бид нар энэ тэтгэврийг тэгшитгэсэнтэй холбогдуулаад гарч байгаа асуудлуудыг бид нар шийдвэрлэх ёстой.

Өнөөдөр тэгш бусын асуудал хөндөгдөж байна шүү дээ. Бага тэтгэвэртэй ахмадуудын тэтгэврийг ихээр нэмье, өндөр тэтгэвэр авч байгаа хүмүүсийн тэтгэврийг багаар нэмье гээд. Энэ чинь Үндсэн хуулийн ялгаварлал шүү дээ. Энийг бид нар яаж янзлах юм? Энэ төрийн гаргасан шийдвэр. Сая 400 мянган төгрөгийн тэтгэвэр авдаг байсан хүмүүстээ 2023 он би буруу санаагүй бол тэгшитгэсэнтэй холбоотой асуудал байхгүй юу. Үгүй тэгээд тэр хүмүүс ч гэсэн нөгөө талдаа хийх ажлаа хийгээд, хүнд нөхцөлд ажиллаад, магадгүй олон сараар ажиллаад, магадгүй илүү их авч байсан цалингаасаа илүү их нийгмийн даатгалын шимтгэл төлж байгаад тэтгэврийнх нь харилцаа тогт.../минут дуусав./

О.Номинчимэг: Жаргалсайханы Золжаргал гишүүн үг хэлье.

Ж.Золжаргал: Эхлээд ямар ч байсан зээлийн эрсдэлийн ангилал дээр ажиллах юм бол 0.5 хувиар буурч магадгүй юм байна.

Хоёрдугаарт нь зээлийн төрлүүдийг, нэр төрлүүдийг нэмэх юм бол хэрэглээ, хүний хэрэгцээтэй холбоотой нэр төрлүүдийн нэмэх асуудал байна.

Гуравт нь болохоор гол нь эх үүсвэр байна шүү дээ. Эх үүсвэрээ нэмэх юм бол, эх үүсвэрээ болохоор зэрэг заавал байх нөөцөөс гаргах талаар нэлээн юмнууд ярилаа.

Ерөнхийдөө ахмадын зээлийг олгохын тулд, хөнгөлөхийн тулд яах вэ гээд ийм тусгай авч хэлэлцээд байх нь зохисгүй юм шиг боловч эдийн засгийн байдлаасаа, орлогоосоо болоод, тэгээд өндөр наснаасаа болоод ялгаварлалтад өртөх нөхцөл үүсчихсэн байгаа. Тэгэхээр Үндсэн хуулийн насаар ялгахгүй гэдэг заалтыг хэрэгжүүлэхийн тулд ямар ч байсан хэлэлцэж байж зохицуулалт гаргах нь хэрэгтэй юм байна гэдэг дүгнэлт байна.

Хоёрт нь, хоёрдугаар гол асуудал байна. Одоо бид нар ингээд мөнгө хаана байна вэ, эх үүсвэр хаанаас олох вэ л гэдэг гол юман дээр очиж байна шүү дээ. Банкнуудын заавал байлгах нөөцөөс нэг эх үүсвэр, түрүүн өөр Төв банкин дахь үнэт цаасны эх үүсвэр, арилжааны банкнуудын юуг эх үүсвэр болгож ашиглавал яах вэ гэдэг санаа бас яригдлаа.

Тэгэхээр эх үүсвэр рүү хамаагүй орох юм бол банкны систем энэ банкнууд чинь өөрсдөө зах зээлийн зарчмаар ажиллаж байгаа арилжааны байгууллагууд, тэрийгээ эвдээд мөнгөний бодлого нь алдагдаад маш том эрсдэл үүсэх нөхцөл бий болж болзошгүй. Тийм болохоор хэрвээ 302 тэрбум төгрөгийг эх үүсвэрээс нь заавал байх нөөцийн ялгавраас тооцно гэх юм бол тэр дээрх бас гарах сөрөг үр дагавруудын тоонуудыг яг 1, 2, 3, 4, 5, 6, 7 энэ тэр гэсэн тоонуудыг маш сайн гаргаж ирж танилцуулж байж шийдэх ёстой байх гэдгийг хэлмээр байгаа юм.

Тэгээд мөнгө хаана байна вэ гэдэг асуулт руу дахиад хармаар байна. Би фокусыг өөр чиглэл рүү явуулмаар байна. Мөнгө хаана байгаа юм? Арилжааны банкнуудын Төв банканд байршуулсан үнэт цаасанд байгаа юм уу? Эсвэл заавал байлгах нөөцөд байгаа юм уу? Монгол Улсын Нийгмийн даатгалын сангийн 1.1 их наяд гэсэн тоон дүнг төсвийн алдагдалд нөхдөг. Би Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар ярьсан. Энийг болиулах хэрэгтэй. Нийгмийн даатгалын сан хүмүүсийн дундаа хуримтлуулж байгаа мөнгө болохоос биш төсвийн алдагдал нөхдөг орлогын хэрэгсэл биш. 10 жилийн нийт зарцуулсан мөнгийг нь тооцохоор 1.5 их наяд болж байна лээ.

Тэгэхээр жил болгон 1 их наяд төгрөгөөр бид нар төсвийн алдагдал нөхөж байна. Өө энэ чинь бид нар улсаас нийгмийн даатгал, тэтгэвэр, тэтгэмжид мөнгө өгдөг болохоос биш авдаггүй гэж тайлбарлаад байдаг юм байна лээ. Бичилтдээ тэгээд нэрлэчихсэн. Төрөөс даах нийгмийн даатгал тэр мөнгөн дүнг татаас, шимтгэлийн татаас энэ тэр гээд нэрлэчихсэн. Тэгэхээр зэрэг нэгэнт л малчдыг, цэрэг, цагдааг төр дааж байгаа бол тэр мөнгөө төлөөд, тэр мөнгө нь нийтийн дундын Засгийн газрын биш шүү, нийтийн дундын Нийгмийн даатгалын сандаа төвлөрөөд тэндээс нь одоо бид нар 300 тэрбумыг олж авбал яах вэ гээд толгой гашилгаад байдаг. Тэнд чинь 1 их наяд төгрөг байна. Тэр 1 их наяд төгрөгийг банканд байршуулж хүүг нь аваад, Нийгмийн даатгалынхаа санг арвижуулаад, тэтгэврээ нэмээд, тэтгэврийн зээлийнхээ эх үүсвэрийг нэмээд, хүүг нь бууруулаад хүн шиг амьдармаар байна. Ингээд мөнгөний эх үүсвэр хаана байна вэ гэхээр арилжааны банкнуудын үнэт цаасанд биш буруу төлөвлөлттэй хийсэн Засгийн

газрын үйл ажиллагаа 10 жилийн турш нэг аравны их наядыг төсвийн алдагдалд нь өгсөн шүү. Энийг бид нар эргэж харах хэрэгтэй. Энэ дээр ажиллаж байгаа хүмүүс байгаа гэдгийг мэдээлэх.

О.Номинчимэг: Отгоны Саранчулуун гишүүн үг хэлье.

О.Саранчулуун: Манай улсад төрж өсөөд бүх залуу насаа улсдаа зориулсан ахмадуудын, манай улсын ахмад иргэний асуудлыг бид нар өөрсдөө л шийдэхгүй юм бол өөр хэн шийдэх юм бэ? Би эндээс асуумаар байгаа байхгүй юу би. Өөр хэн шийдэх вэ? Банкных нь хүмүүс нь шийдэхгүй, санхүүгийн бодлого зохицуулдаг хүмүүс нь шийдэхгүй юм бол өөр ер нь хэн шийдэх вэ? Нэгдүгээр асуудал. Энэ дээр та нар жаахан сэтгэл гарга л даа.

Хоёрдугаарт нь арилжааны банкнуудад уриалмаар байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ахмад настай хүмүүс чинь бүгдээрээ халамж авдаг хүмүүс биш. Боломж нь байвал зээл аваад бизнес хийгээд ажиллая гээд байгаа. Тэд нарт зориулсан бүтээгдэхүүн, бүтээгдэхүүнээ ядаж хүртээмжтэй болгох дээр манлайлаад юм яриадхаач, гаргаадхаач та нар чинь хувийн хэвшил шүү дээ.

Гуравдугаарт, Монголбанк сүүлийн 20, 30 жил урьд хожид байгаагүйгээрээ хүний нөөцөө тэлсэн. Олон салбартай болсон. Хэчнээн олон мянган ажилтантай билээ? Ийм олон мянган ажилтантай, ийм том бүтэцтэй байж байж эмзэг бүлгийн хэдэн хүмүүст зориулсан судалгаа энэ тэр хийх болохоороо хөдөлж ядаад байх юм. Ерөөсөө ярихгүй юм. Бүтэн жил та нараас би хүртээмжийн асуудлуудыг ямар хариу ярих бол гэж хүлээж байгаа шүү дээ. Тэр тоон гарын үсэг, тэр IBAN код энэ тэр чинь ерөөсөө хүртээмжгүй байгаа шүү дээ. Та нар тэрийгээ өөрсдөө мэдэж байгаа юу? Хараа муутай хүмүүс, гар муутай хүмүүс, хөл муутай хүмүүс банкны үйлчилгээ авахад ямар хэцүү байна. Ядаж та нар тэр банкнуудад чиглэж байгаа бодлогодоо энэ зэргийн жижиг сажиг асуудлаа шийдмээр байна одоо нэгэнт уулзсаных. Хэчнээн хүнтэй юм танайх? Ийм олон хүнтэй байж байж энэ судалгаа хийж чадахгүй бүтэн 5, 6 сар ингээд судалгаа хийж байна л гээд байх юм.

Тэгээд энэ хүмүүсийн насаар ингээд хувилбар гаргаж байгаад залуу ахмад настан гээд байдаг л даа. Хөдөлмөрлөж байгаа насаар, тэтгэвэрт гарсан жилээр нь зээлийн сонголттой бүтээгдэхүүн, энэ хүн ам нь ийм байна, энэ дээр нь ийм эх үүсвэрийг гаргая энэ тэр гээд бодлого энэ тэр гаргахгүй юм уу? Тэгээд та нар энийг санаачилга гаргаж мэргэжлийн хүмүүс нь хийхгүй бол өөр энийг чинь аль улсын хаашаа хүмүүс очих юм, хүмүүс хаана хандах юм бэ? Энэ чинь төр засаг руугаа л хандахгүй бол энэ хэдэн ахмад хүмүүс чинь хаана очих уу? Энэ чинь манай улсын иргэд биз дээ? Би энэнээс өөр хэлэх үг алга жагсаж байгаа хүмүүсийн өмнөөс. Өвдөж байгаа өчнөөн ахмадууд надтай холбогдож байгаа.

Тэгэхээр энэ дээр та нар сэтгэл гаргамаар байна. Арилжааны банкнууд ч гэсэн энэ дээр боломжтой бүтээгдэхүүн гаргамаар байна. Чаддаггүй юм аа гэхэд байгаа банкны зээлийн санхүүгийн бүх бүтээгдэхүүнээ хүртээмжтэй болгомоор байна. Нээх их олон кодтой шилжилтүүд байж байдаг. IBAN кодыг өнөөдөр хүмүүст ямар түүртэй байгааг та нар өөрсдөө ер нь мэдэж байгаа юу? Нээх их олон бүх газар дандаа утсаар QR-аар төлбөр тооцоо хийнэ. Бүгдээрээ хүртээмжгүй, хар муутай хүнд хүртээмжгүй, ахмадуудад хүртээмжгүй, аягүй хэцүү, гар муутай хүмүүст ч хүртээмжгүй. Тэгээд та нар энийг шийдэхгүй тэгээд өөр хэн шийдэх юм, бид нар энийг ярихгүй өөр хэн ярих юм? Тийм болохоор л ингээд асуугаад байгаа шүү дээ. Тэгэхээр та нараас би сэтгэлтэй байгаач л гэж хүсээд

байна. Банкнууд ийм шийдвэр энэ тэр гаргавал гарга л даа. Одоо ахмадын эрхийн өдрөөр та нар яадаг юм? Ийм нэг өдөр хүмүүст ийм аян шиг юм хийчхээд л болчихлоо гэдэг ийм хандлагаа боль л доо банк санхүүгийнхэн.

О.Номинчимэг: Гишүүд үг хэлж дууслаа. Энэ чинь зүгээр хэлэлцэж байгаа асуудал байх аа. Санал хураалт байхгүй юу тээ? Гишүүд үг хэлээд дууссан байна.

Ер нь бид нар олон талаас нь энэ асуудлыг харах ёстой. Ахмадуудынхаа бид нар үгийг мэдээж сонсож байгаа. Гэхдээ ямар нөөц, бололцоонууд байна гэдгийг харахаар их л нухацтай л харах ёстой байгаад байна. Тэгээд энийг Улсын Их Хурлын дарга ч гэсэн бас байр суурь илэрхийлж байгаа болохоор манай Өргөдлийн байнгын хорооноос энэ сонссон мэдээлэл, гарц, гаргалгаанууд, гишүүдийн дэвшүүлж байгаа саналыг тусгаад тэгээд дараа дараагийн шийдвэр рүү явах юмыг бид нар бас хийх ёстой байх. Манай Эрдэнэбат гишүүн бас энэ дээр манлайлж байгаа.

Ялангуяа сая хамгийн ойрын зуур хийгдэж боломжтой зүйл нь тэр эрсдэлийн үнэлгээ эд нартай холбоотой зүйл байна тээ. Тэр хамгийн боломжит зүйлүүдээсээ эхлээд юу ч гэсэн бид нар хийх л ёстой байгаад байна. Сая төсвөөр тэтгэврийн хэмжээ бас бага зэрэг нэмэгдсэн байгаа тээ? Чадлынхаа хэрээр, төсвийнхөө хэмжээний юугаар нэмэгдсэн байгаа. Энэ маань өөрөө эдийн засагт бид нар бас яаж нөлөөлж байна, хэрэглээн дээрээ яаж байна гэдгийг их сайн олон талаас нь харах ёстой л харагдаж байна даа.

Бид нар Нийгмийн даатгал энэ юу нь явж явж нийгмийн даатгалын өөрөө тогтолцоо маань их буруу байгаатай, мэдээж амьжиргааны түвшин Монгол Улсын нийгэм эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотой боловчиг гол уг нь шийдлийн асуудал тэгээд нийгмийн даатгалын тогтолцоо л байгаад байгаа юм. Тэгээд тэрийгээ бид нар 90-ээд оноос хойш мөнгөжүүлэхгүйгээр явчихсан. Дундаас нь популист улс төрч нар иргэдэд таалагдах шийдвэр хэд хэд гаргасны улмаас энийг гажуудуулчихсан. Тэгээд энийгээ даахаа больчихсон ийм нөхцөлд ингээд байгаа болохоор аргацаасан бас нэг асуудлаас илүү тогтолцооныхоо шинж чанартай юм руу хурдан л бид бас энэ төр засаг үнэхээр иргэдийнхээ асуудлыг шийдье гэж байвал иймэрхүү юмнууд руугаа ормоор байгаа юм.

Тэгээд өнөөдөр бол 24 сар байна уу, 36 сар байна уу гээд бид шийдчихэж болно. Гэхдээ энэ бол манай ахмадуудын асуудлыг шийдэхгүй шүү дээ тээ. Нэгмөсөн шийдэж чадахгүй л. Тэгэхээр энийг бас илүү тогтолцооных нь хүрээнд бас харах ёстой. Энийг тал талдаа цөмөөрөө шийдэл боловсруулж бас ярилцъя гэж бодож байна.

Ингээд өнөөдрийн хэлэлцэх асуудал, хааж үг хэлэх ёстой юу тээ? Дэгийн дагуу юутай холбоотойгоор асуулт тавьсан гишүүн болох Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбат гишүүн үг хэлнэ.

Д.Эрдэнэбат: Ямар ч байсан энэ асуудлыг нэг тийш нь шийдэхгүй бол ахмадуудыг арилжааны банкнуудтай хооронд нь хаячхаад Монголбанк ямар ч бид нарын зүгээс шалтгаалсан бүх зүйл болчихсон, Засгийн газар бид нараас хамаарах юу ч байхгүй гэж хаяж болохгүй байсан юм. Тэгэхээр бид нар энийг араас нь өнөөдөр маш олон ахмадууд яг одоо шийд, шийдлийг нь гарга гэсэн хүмүүс байгаа. Гэхдээ нэгхэн асуудал биш олон тавьж байгаа асуудлынх нь. Тийм учраас өнөөдөр нэлээн нухацтай ярилаа. Би бас өнөөдөр ирсэн арилжааны

банкнууд, Монголбанк, манай гишүүд ч гэсэн өөрөө бараг мэргэжлийн Байнгын хорооны хэмжээнд энэ асуудлуудыг нь ярилаа.

Тийм учраас энийг би Улсын Их Хурлын бас тогтоол санаачилъя. Энийг Их Хурлын дарга өөрөө хэлсэн. Энэ зээлийн асуудлыг нэг тийш нь шийдье. Тэгэхгүй бол яах аргагүй энэ ахмадуудын тавьж байгаа хамгийн энэ төр засаг Их Хуралд тавиад байгаа хамгийн их санал тавьж байгаа асуудал байгаад байгаа юм. Тийм учраас энэ тал дээр Их Хурлаар шаардлагатай бид нар тэр хууль, эрх зүй мөн бусад шаардлагатай юу байвал манай арилжааны банкнууд ч гэсэн тодорхой саналууд ирүүлсэн. Энийг хууль, эрх зүйн хэмжээнд нь зохицуулж болохоор бол тэр зүйлүүдийг нь бид нар шийдье.

Зөвхөн өнөөдөр Өргөдлийн байнгын хорооноос нэлээн үр дүнтэй зүйлүүд нь би бас олзуурхаж байна.

Нэгдүгээрт тэр эрсдэлийн хэмжээг тогтоосон асуудлаа эргэж авч үзье гэж Монголбанк ярьж байна. Энийг ойрын хугацаанд хуралдвал тун сайн байна. Оны асуудлыг он дотор нь шийдмээр байна. Он гаргах гэж байна. Олон ахмадууд олон хүмүүс хүлээж байгаа.

Хоёрдугаарт нь заавал байлгах нөөцийн хэмжээн дээр нь яах вэ тэр эрсдэлийнх нь түвшнийг нь харгалзаж байгаа тодорхой хэмжээний эх үүсвэр гаргах тал дээр нь Монголбанк маань гаргаад, арилжааны банкнууд нөгөө талаас нь ялангуяа энэ ахмадын тэтгэврийн тэтгэврийн дийлэнх багцыг эзэмшиж эзэмшиж байгаа системийн банкнууд маань хамтарч ажиллах юм бол энэ дээр хүү буурах, тэр тодорхой эх үүсвэрүүдийг нь хугацааг нь нэмэх ийм боломжууд гарна гэдэг дээр өнөөдрийн бас энэ ойлголцож тодорхой нааштай юунууд сонсож байгаад нь бас би олзуурхаж байна.

Гуравдугаарт нь шаардлагатай эх үүсвэр гээд тавьж байгаа. Энийг бас судалъя. Өөрөөр хэлбэл, арилжааны банкнуудад одоо бид нар чинь маш олон зээлийн хүүгийн татаас өгдөг шүү дээ. Ипотек дээр хүртэл өгөөд л яваад байгаа. Баахан юм өгөөд л яваад байгаа. Гэтэл хамгийн зорилтод жилд 13500 хүн нас барж байна шүү дээ хөөрхий энийг. Тэгээд энийгээ эргээд нас барчихсан ч гэсэн үр хүүхдүүд нь, ах дүү нар нь төлчихдөг.

Гэтэл тэр үлдэж байгаа тэтгэврээ ч авч чадахгүй 30 жил төлчхөөд 5-хан жил тэтгэврээ аваад нас барж байгаа ахмадууд дийлэнх нь байгаа. Тэр нь үндсэндээ Нийгмийн даатгалтайгаа сандаа үлдэж байгаа. Тэгээд энэ олон зүйлийг харгалзаад бас энэ нийгмийн том асуудал учраас энийг шийдэх тал дээр та бүгд маань зөвхөн хууль яриад байвал бүтэхгүй. Хуулийн дагуу гээд. Сая манай Монголбанкны бас ирүүлсэн санал дээр нэр бүхий гишүүд Монголбанкны эрх мэдэлд халдаж бууруулсан нь харамсаж байна энэ тэр гээд энэ чинь улс төрийн мэдэгдэл юм уу юу юм тээ? Их Хурлын гишүүд энийг ярихгүй бол тэр ахмадууд чинь Их Хурлын гишүүдэд хандана. Их Хурлын гишүүнд нь өөрийнхөө томилсон байгууллага, харьяаны байгууллагадаа асуудлаа тавихгүйгээр өөр хаана тавих юм. Монголбанк мэдэж байгаа гээд л хаяад байвал энэ чинь юу ч шийдэгдэхгүй.

Тийм учраас тэр Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл байна уу Хяналтын зөвлөлд байна уу бас энэ зээлдэгчдийн эрх ашгийг хамгаалж төлөөлөх ийм юмыг би Монголбанкны хуульд өөрчлөлт оруулж тодорхой тэр төлөөллийн жинхэнэ хараат бус гэж байгаа, улс төрчдөөс хараат бус биш, хий хоосон улс

төрждөг биш, бодит шийдвэр гаргадаг ийм хүмүүсийг бас оруулах тал дээр нь ажиллая гэж бодож байгаа.

Тэгээд арилжааны банкнуудтай эцэслэн хүсэхэд та бүгдэд олгох эх үүсвэр нь нээлттэй байна. Тэгээд саяын арга хэмжээнүүдийг Монголбанк хурдан аваасай. Арилжааны банкнууд маань 36 сарын хүртэл олгох гэдэг зүйлийг нь судлаач. Түрүүн манай Хаан банкны хүмүүс бас сонирхолтой судалгаа хийсэн байна. Дийлэнх нь 75 хувь нь ингээд өөр хүмүүсийн данс руу гараад явчихдаг. Үнэхээр тэр дунд чинь жижигхэн бизнес эрхлэх гэж байгаа, өрхийн аж ахуй эрхлэх гэж байгаа, янз бүрийн орон сууц авах гэж байгаа ч гэдэг юм уу ийм олон төрлүүд байгаа. Энэ боломжтой хүмүүст нь тэр заавал энэ Монголбанкны юмыг хүлээхгүйгээр олгоод шийдээд ингээд явах тал дээр санаачилгатай ажиллаач гэж хүсэж байна. Баярлалаа.

О.Номинчимэг: Баярлалаа. Үг хэлж дууслаа. Ингээд энэ 1 дүгээр асуудлыг хэлэлцэж дууслаа.

Дараагийн асуудал.

13.56 цаг

Хоёрдугаар асуудал буюу Иргэдээс ирүүлсэн өргөдлийн талаар буюу Бэрхийн уурхайн нэр бүхий 112 иргэнээс ирүүлсэн өргөдлийн тухай авч хэлэлцэнэ.

Бэрхийн уурхайн нэр бүхий иргэдийн итгэмжилсэн төлөөлөгч Д.Алтангэрэлээс Монгол Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороонд хандан ирүүлсэн Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатын шүүхээс Монгол Улсын Засгийн газрын эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоож, Бэрхийн уурхайн нэр бүхий 112 иргэдэд нөхөн төлбөр олгох эсэх асуудлыг Засгийн газарт даалгасан боловч шүүхийн шийдвэр биелэгдэхгүй 2 жил гаруй хугацаа өнгөрч байгаа талаар өргөдөл бас Өргөдлийн байнгын хороонд ирсэн.

Энэ өргөдлийн дагуу бид нар ажлын албанаас холбогдох байгууллагуудаас мэдээлэл авч, ажиллагаа хийсэн байгаа. Тэгэхээр энэ асуудлыг хэлэлцэж эхэлье.

Уг өргөдлийг Улсын Их Хурлын гишүүн Далайн Батбаяр, Даваасамбуугийн Ганмаа нар судалсан. Ингээд Улсын Их Хурлын гишүүн Даваасамбуугийн Ганмаа энэ асуудалтай холбоотой танилцуулга, саналыг танилцуулна.

Д.Ганмаа: Сайн байцгаана уу? Танилцуулгыг уншъя. Хэнтий аймгийн Бэрхийн уурхайн нэр бүхий 112 иргэний итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Алтангэрэлээс Монгол Улсын Их Хурлын удирдлага болон Өргөдлийн байнгын хороонд хандан ирүүлсэн өргөдөл, гомдлыг Байнгын хорооны даргаас Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр бид хоёрт судалж, санал танилцуулахаар хуваарилсан.

Бэрхийн уурхай нь 1954 онд байгуулагдсан. Уурхайн асуудлыг 2004 он хүртэл Төрийн өмчийн хороо хариуцаж байсан. 2004 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр худалдах, худалдан авах гэрээ байгуулан өмчлөгчийн эрхийг шилжүүлж, “Бэрх-Уул” ХК аливаа үүргийг хариуцах болж Бэрхийн уурхайд ажиллаж байгаад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдагдсан иргэдийн асуудлыг хариуцах эзэн нь тодорхойгүй болсон байна.

Хэнтий аймгийн Бэрхийн уурхайчдын төлөөлөл “Асар их хүч” ТББ-ын тэргүүн Д.Алтангэрэл одоогоор 88 нэхэмжлэгчтэй итгэмжлэл олгосон ба Алтангэрэл нь 2007 оноос Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд болон Улсын Их Хурлын гишүүд, Нийгэм хамгаалал, хөдөлмөрийн яам, Төрийн өмчийн хороонд удаа дараа асуудлыг тавьж хандсан байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.4 дэх заалтыг үндэслэн 2001 он, 2003 он, 2007 онуудад улсын хэмжээгээр 2659 хүнд 610 гаруй сая төгрөг, 2011 онд 1731 хүнд 486 сая төгрөг, 2012 онд 337 хүнд 94.6 сая төгрөгийн нөхөн төлбөрийг уурхайчдаас тус тус олгосон.

Үүний дотор Хэнтий аймгийн Бэрхийн уурхайд ажиллаж байсан 188 иргэнд 2003 онд 59 сая төгрөг, 2007 онд 18 сая төгрөг, 2011 онд 245 хүнд 68.7 сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс олгожээ. 2013 онд Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Төрийн өмчийн хорооноос ажлын хэсэг байгуулж ажилласан бөгөөд уг ажлын хэсгээс нийт 196 хүнд 4.5 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгуулах асуудлыг Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх дүгнэлт гаргасан байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар 2015 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр 5/28/58 тоот албан бичгээр нөхөн төлбөр олгох асуудлыг дэмжсэн байдаг хэдий ч тухайн үеийн Засгийн газар нь шийдээгүй байна.

Бэрхийн уурхайчдыг төлөөлөн Д.Алтангэрэл уурхайчдад олгох 2 удаагийн нөхөн төлбөрт 4 тэрбум 513 сая 480 мянга 334 төгрөгийг Засгийн газраас гаргуулах асуудлаар 2017 оноос нийслэлийн СБД-ийн шүүхэд хандаж, шүүхийн үйл ажиллагаанд Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас төлөөлөл оролцож байсан.

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатын шүүхийн 2002 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 04/04 шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатын шүүхийн 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 570 дугаар магадлалаар Бэрхийн уурхайд ажиллаж байхдаа үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсан, нас барсан иргэдэд нөхөн төлбөр олгох эсэх асуудлыг зохих журмын дагуу шуурхай шийдвэрлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан байна.

Дээрх шийдвэрийн дагуу Гэр бүл, нийгмийн хамгааллын яамны яам, ажлын хэсгийн Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 174 дүгээр тушаалаар байгуулагдсан бөгөөд улмаар 2024 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн А79 дүгээр тушаалаар ажлын хэсгийг шинэчлэн байгуулан ажиллуулсан.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналтын хэлтсээс Бэрхийн уурхайд ажиллаж байсан нэхэмжлэгч нэр бүхий 112 иргэдэд олгох нөхөн төлбөрийн хэмжээг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Итгэлцүүр шинэчлэн тогтоох тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 238 дугаар тогтоолд заасан цалингийн итгэлцүүрийг ашиглан тооцоолоход 9 тэрбум 450 сая 196 мянга 866 төгрөг байна.

Тус ажлын хэсгээс Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчтөний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 3.1.1 дэх заалт, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 04/04-өөр шийдвэрийг тус тус үндэслэн “Нөхөн төлбөр олгох тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр хүргүүлсэн байна.

Иймд уг асуудлыг Өргөдлийн байнгын хорооны 25 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, үр дүнг Монгол Улсын Засгийн газарт Байнгын хорооны албан бичгээр хүргүүлэх саналтай байна.

Танилцуулга дууссан.

О.Номинчимэг: Ганмаа гишүүнд баярлалаа. Манай Өргөдлийн байнгын хорооны гишүүд энэ иргэдээс ирж байгаа өргөдөл, гомдлууд дээр хоёр хоёроороо ажиллаж байгаа. Тэгээд зарим ингээд ийм хариуцлагатай гишүүд эхнээс нь ажиллаад, санал, дүгнэлтээ гаргаад асуудлуудаа хэлэлцэж эхэлж байгаа. Гишүүддээ бас хэлэхэд энэ иргэдийнхээ дуу хоолойг сонсож, энэ өргөдлүүд дээр ажиллаж хурдан асуудлуудаа Байнгын хороогоор оруулж, шийдвэр гаргах дээр бас анхаарч ажиллаасай гэж хүсэж байна.

Энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Сандагийн Бямбацогт гишүүн, сайд, Засгийн газар Хэрэг эрхлэхийн сайд? Хууль зүйн байнгын хороон дээр байнаа? Дуудаач. Дуудаарай. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайд Аубакир сайд хаа байна? Энэ асуудлыг ялангуяа сая Ганмаа гишүүний энэ асуудал аль 9 сард ирсэн бид нарт өргөдөл байхгүй юу. Тэгээд энэ чинь захиргааны хэргийн шийдвэр гарчихсан маш тодорхой, асуудлаа шийд гээд тэгэхээр яам нь бид нар Засгийн хурал руу энийг оруулах гэж байгаа, оруулах гэж байгаа гээд хоёр 7 хоногоор л баахан хойшилсон. Тэр хүрээндээ Засаг нь шийдчих юм болов уу тэгвэл бас Байнгын хороогоор эд нар оруулж энэ баахан цаг үрээд яах вэ гээд хүлээсээр байтал 12 сар боллоо шүү дээ. Тэгээд асуудлыг нь хэлэлцэх болохоор хариуцсан сайд нар нь байхгүй. Иргэдийнхээ асуудалд яагаад ийм хариуцлагагүй ханддаг юм? Аубакир сайд ирэх хэрэгтэй шүү дээ. Энэ асуудлыг чинь аль хэдийн тов, дараалалд түрүү 7 хоногийн 5 дахь өдөр ороод л зарласан байгаа шүү дээ. Алимаа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газрын дарга байна уу?

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.31 чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож, тухайн этгээдэд Төрийн албаны тухай болон холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж заасан байгаа.

Ялангуяа иргэдийн өргөдлийг авч хэлэлцдэг Өргөдлийн байнгын хороонд үл тоомсорлож удаа дараа ирэхгүй байгаа энэ хүмүүстэй ярина шүү. Та нар тэр юу гэдэг юм эд нар яавал гэж бодоод ингээд явж байж болохгүй. Хэвлэл мэдээлэл, олон нийтэд нээлттэй хуралдаад явж байгаа. Иргэдийн асуудлаа шийдье гэхээр зугтаад алга болчихдог сайд нар, албан тушаалтнууд байж болохгүй шүү.

Ренчиндорж Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбар хяналт-шинжилгээ үнэлгээ, бодлогын газрын дарга, Рэнцэнханд Гэр бүл, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал хариуцсан сангийн бодлогын газрын дарга хаа байна? Дууд. Батжаргал Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Сангийн яамны төсвийн зарлагын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ? Ирсэн байна. Нийгмийн даатгал ерөнхий газар Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ганцэцэг ирсэн байна. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын мэргэжилтэн Энхзаяа хаана байгаа юм? Яагаад ирээгүй байдаг юм. Дууд. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Дэлгэрмаа? Дуудаарай. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газрын ахлах шинжээч Хишигжаргал ирсэн байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн хяналтын хэлтсийн Хөдөлмөрийн хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн Ууганбаатар ирсэн байна. Нэхэмжлэгчдийн энэ иргэдийн маань итгэмжилсэн төлөөлөгч Д.Алтангэрэл ийм бүрэлдэхүүнтэй ирсэн байна.

Гишүүд ч гэсэн бас эндээс асуудлыг ер нь та бүхэн сая Ганмаа гишүүн танилцууллаа. Маш тодорхой асуудал байгаад байгаа юм. Тэгээд яагаад иргэдийнхээ асуудлыг шийдээд, шүүхийнхээ шийдвэрийг гүйцээгээд биелүүл гэхээр Засгийн газар ингээд удаа дараа 2 жил хойшлуулчихаад байгаад байдгийг би ерөөсөө ойлгохгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгээд тэрийг нь л асууя гэсэн юм. Яагаад Засгийн газрын хуралдаанаар оруулахгүй байгаа юм Засгийн газрын Хэрэг эрхлэх, Сангийн яам? Яагаад энэ асуудлаа оруулж чадахгүй байгаа юм Аубакир сайд? Яагаад энэ асуудлыг Байнгын хороогоор хэлэлцье гэхээр бүгдээрээ зугтаад алга болчихсон байхгүй байгаад байгаа юм. Надад өөрсдөө ямар нэгэн шалтгаан хэлээгүй шүү. Ийм асуудалтай байна гэдэг асуудлыг Байнгын хорооны даргын хувьд өнөөдөр ийм асуудал болох гэж байгаа гэдэг асуудал дээр надад хэн нэг нь албан ёсоор ерөөсөө мэдэгдсэн юм байхгүй. Бямбацогт сайдыг дуудъя. Дуудахаас нааш эхлэхгүй. Дуудаад орж ирэхгүй бол дараагийн арга хэмжээг нь авъя.

Хариуцаж байгаа сайд нар орж ирэхгүй байгаа, хариуцаж байгаа албан тушаалтнууд орж ирэхгүй байгаа учраас хойшлууллаа.

122 хүнийхээ, иргэнийхээ асуудлыг 3 жил удааж байгаа энэ Засгийн газар эндээсээ ичих хэрэгтэй шүү.

14.09 цаг

Дараагийн асуудалд оръё. Дараагийн асуудал. Сүүлийн асуудал.

Өргөдлийн байнгын хороонд иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийн шийдвэрлэлтийн явцын талаар мэдээлэл байгаа.

Монгол Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороо байгуулагдсанаасаа хойш иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийн тоймыг 14 хоног тутам бүхэнд хүргүүлж байгаа.

Байнгын хороонд ирүүлсэн ажиллагаа хийгдсэн өргөдөл, гомдлын холбогдох материалын хамт QR үүсгэн та бүхэнд бүх мэдээллийг өгсөн. Өнөөдөр энэ асуудлыг хэлэлцэхгүй. Мэдээллийг нь өгч байна.

Өнөөдөр тараагдсан өргөдлийг шийдвэрлэлтийн явцтай, шийдвэрлэх саналтай та бүхэн танилцаад дараагийн 7 хоногийн Байнгын хороогоор энэ дээр хэлэлцэнэ. Мэдээж эхлээд гишүүдээ бас мэдээллээр хангах нь зүйтэй гэсэн ийм саналтай байгаа учраас энэ мэдээллийг та бүхэнд, гишүүдэд өгсөн байгаа.

Манай Байнгын хороонд ахмад настнуудаас анх тэтгэвэр тогтоолгохдоо бодит цалингаа хязгаарлуулж тэтгэврээ тогтоолгосон бөгөөд тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлж, цалингийн итгэлцүүрээр тэтгэврийг шинэчлэн тогтооход дахин тайрагдаж тэтгэврийн хэмжээ багассан гэх асуудлаар нэр бүхий 12 иргэн болон нийт 21 ахмадуудаас өргөдөл, гомдол ирээд байгаа юм байна.

Тэгэхээр энэ ерөөсөө хувь хүний бүр асуудал биш ийм системийн асуудал болчихсон. Гол асуудал бол энэ анх тэтгэвэр тогтоолгохдоо тэр итгэлцүүрийг тэтгэврийг шинэчлэн тогтоолгоход тайрагдсан ийм ийм асуудлаас болоод ахмадуудын хувьд тэтгэврээ зөв тогтоолгохгүй, тэгш бус байдал алдагдсан байна гэдэг өргөдлийг ирээд байгаа юм. Тэгээд энийг эхнээс нь манай Рэгдэл гишүүн, Мөнхбаясгалан гишүүд бас 2 гишүүн маань томилогдоод яамтай хамтраад энийг асуудлуудыг хэлэлцэж байгаа боловч яг энэ төрлийн өргөдөл, гомдол байнга ирж байна. Нийтдээ 21 ахмадуудаас ирээд байна. Тэгэхээр энэтэй холбоотой асуудлыг ер нь бас ажлын хэсэг байгуулж, энэ хүрээнд бас шийдвэрлэсэн нь зүйтэй гэж үзэж байгаа учраас энэ талаар Улсын Их Хурлын гишүүн Рэгдэл, Мөнхбаясгалан нар ажиллаад энийг Рэгдэл гишүүн танилцуулаад саналаа бас та бүхэн хэлчихье. Тэн дээр Байнгын хорооны саналаар ажлын хэсэг бас өргөтгөсөн бүрэлдэхүүнтэй ажиллах шаардлагатай байна. Энэтэй холбоотой асуудлаар бас манай Ахмадын холбоо, Гэр бүл, нийгмийн хамгааллын яамнаас хариуцсан албан тушаалтнууд ирсэн байна.

Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүн Дүгэрийн Рэгдэл таныг саналаа танилцуулахыг хүсье.

Д.Рэгдэл: Энэ өдрийн амар амгаланг эрье. Монгол Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороонд тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох цалинг хөлс, түүнтэй адилтгах орлогын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлж, жаахан чимээгүй байхгүй юу нөхөд өө ... тодорхойлж цалингийн итгэлцүүрээр тэтгэврийг шинэчлэн тогтооход тэтгэврийн хэмжээ багассан гэх асуудлаар Магсар, Оюунчимэг, Баатар, Энхсайхан, Авирмэд, Цэдэв, Наранцэцэг, Батбаяр, Жавзандулам, Эрдэнэбазар нарын нэр бүхий 12 ахмадууд, ер нь нийт 21 ахмадуудаас өргөдөл, гомдол ирсэн байна.

Уг асуудлыг Өргөдлийн байнгын хорооноос Мөнхбаясгалан гишүүн бид хоёрт хариуцуулаад судалгаа хийж байгаа юм. Ингээд 25 оны 10 дугаар сарын 13-ны өдөр холбогдох албан тушаалтнуудыг оролцуулан уулзалт зохион байгуулж, тайлбар, мэдээллийг сонссон. Энэ уулзалт дээр холбогдох албан тушаалтнууд харин их сайн оролцсон.

Уулзалтаар ахмадуудаас ирүүлсэн өргөдөл тус бүрийг судлуулахаар Нийгмийн даатгалын ерөнхий газарт шилжүүлсэн. Хүн бүрийн өргөдлийг нягтлан шалгахад тодорхой хугацаа шаардлагатай байгаа талаар Нийгмийн даатгалын ерөнхий газраас мэдээлээд байгаа юм.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт итгэлцүүрийг улсын дундаж цалин, хэрэглээний үнийн өсөлттэй уялдуулан Үндэсний статистикийн хорооны саналыг үндэслэн Засгийн газар жил бүрийн 8 дугаар сарын 1-ний өдрийн дотор тогтоож, дараа жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөнө гэж заасан байгаа. Засгийн газрын 2025 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн “Итгэлцүүр батлах тухай” 65 дугаар тогтоолоор итгэлцүүрийг шинэчлэн баталсан бөгөөд энэхүү итгэлцүүрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай 7.8 тэрбум төгрөгийг Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд тусгаад байна.

Харин даатгуулагчид тэтгэвэр тогтоох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг 2013 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнөх хугацаанд 1 сая 404 мянга 400 төгрөгөөр тооцож байгаа. Энэхүү шийдвэрийг хэрэгжүүлснээр Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авч байгаа 493 мянган хүний 58.50 хувь нь буюу 288.4 мянган хүн тэтгэврийн доод хэмжээгээр, 204.6 мянган хүн тэтгэврийн доод хэмжээнээс дээгүүр тэтгэвэр авч байгаа юм. Тэтгэврийн доод хэмжээнээс дээгүүр тэтгэвэр авагчдын 87.8 хувь буюу 179.7 мянган хүний цалин хөлс, түүнтэй адилтгах орлого нь түрүүчийн хэлсэн 1 сая 404 мянган төгрөгийн хэмжээгээр хязгаарлагдсан байна.

1990, 2013 он хүртэлх хугацааны цалин хөлсөнд итгэлцүүр хэрэглэсэн боловч нэг ижил хязгаарлалтад оруулснаар тэтгэвэр авагчдын ажил мэргэжил, авч байсан цалин хөлс, шимтгэл төлсөн хугацааны ялгааг үл харгалзан ижил цалин хөлсөөр тэтгэвэр нь тогтоогдоод байгаа юм.

Иймд тэтгэвэр бодох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийн өсөлттэй уялдуулан шинэчлэн тогтоох зайлшгүй шаардлага үүсээд байгаа юм.

Ахмадуудаас ийм агуулгатай өргөдөл байнга ирж байгаатай холбогдуулан Өргөдлийн байнгын хорооноос ирүүлсэн нийт өргөдлийг нарийвчлан судалж цогцоор нь шийдвэрлэх хэрэгцээ, шаардлагад үндэслэн ажлын хэсэг байгуулж, судлан үзэх нь зүйтэй байна.

Байнгын хорооны ажлын хэсэг байгуулах тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

О.Номинчимэг: Рэгдэл гишүүнд баярлалаа. Тэгэхээр Байнгын хорооны тогтоолын төслүүд гишүүдэд тараасан байгаа. Тогтоолын төсөл дээр энэ ахмад настуудын тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох, цалин хөлс, түүнтэй адил орлогын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлж, цалингийн итгэлцүүрээр тэтгэврийг шинэчлэн тогтооход ахмадын тэтгэврийн хэмжээ багассан гэдэг энэ асуудлаар нэр бүхий иргэд, ахмадууд их хандаж байгаа учраас энийг боловсруулж, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж байгаа.

Энэ асуудлыг өмнө нь өмнөх Улсын Их Хурлын даргын дэргэд ч гэсэн Ахмадын холбоод хамтраад зөвлөхүүдтэй хамтраад ажиллаж байсан юм байгаа юм байна лээ. Тэгэхээр энэ ажил бас зогсчихсон байгаа учраас Өргөдлийн байнгын хороо үүнийг татаж авч бас олон, өргөн бүрэлдэхүүнтэйгээр хийе гэж бодож байгаа. Тэгэхээр энэ дээр ирж байгаа Ахмадын холбооноос гадна бусад олон одоо энэ байгууллагуудыг татан оролцуулж хийе гэж бодож байна.

Тогтоолын төслийг та бүхэндээ тараасан байгаа. Үүнтэй холбоотой асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу?

Би тэгвэл асуулт асуунгаа Ахмадын холбооноос асуучихъя. Энэнтэй холбоотой ер нь та бүхэн энэ дээр манай Байнгын хорооны гишүүдтэй хамтраад энэ асуудлыг хамтарч шийдвэрлэхэд дэмжиж ажиллана гэж ойлгож байгаа. Тодорхой хийгдсэн одоогийн явц, дүгнэлтүүд байвал бас та энд дурдаад өгөөрэй.

Энэ индэр дээр урьж байна. Индэрийн микрофоныг. Ахмадын холбооны дарга Сүхбаатар.

Ц.Сүхбаатар: Гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Тэгэхээр энэ Монголын ахмадуудын өмнө тулгамдсан маш чухал асуудлын нэгийг хөндөж тавьж байгаад баяртай байна. Саяхан энэ ахмадууд жагсаал, суулт хийгээд энэ тэтгэврийн доод хэмжээг сая 500 болгож өгөөч гэж асуудал тавьсан шүү дээ. Тэгэхээр энэний цаана талд байж байгаа 170 гаруй ахмад настнууд сая Рэгдэл гишүүний ярьдаг шиг ийм асуудал байгаа юм.

Тэгэхээр энийг тусад нь өөрөөр хэлбэл, тэтгэврийн доод хэмжээг нэмэх гэсэн саяын жагсагчдын асуудалтай хамтад нь авч шийдэхгүй бол зөвхөн доод хэмжээг хэт өндөр өсгөөд тэгээд 30, 40-н жил ажилласан, өндөр шимтгэл төлсөн, өндөр цалин авч байсан хүмүүсийг тэр сая 404-өөр тайрснаас болоод олон ахмадууд авах ёстой тэтгэврээ авч чадахгүй байгаа юм. Тэгэхээр энийг нухацтай судалж шийдэхийг Ахмадын холбоо дэмжиж байгаа.

Бид нар өмнө нь бидэнд судалгаа тооцоо бий ахмадын энэ тэтгэврийн хэмжээ, ялангуяа тэтгэврийн зөрүүг арилгах асуудалтай холбогдуулаад Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд урдах жилүүдэд гаргасан судалгаа, тооцоо бидэнд бий. Итгэлцүүрийг батлах үед хүртэл бид нар өөрийн гэсэн санал онолоо тавьж байсан.

Энэ Үндсэн хуулийн цэцэд хүрэхээр хэмжээний гомдол, саналыг хамтад тавьж байгаа шүү. Тийм учраас энэ тэр цалингийн дээд хязгаар тавиад ингээд тайрч байгаа нь Үндсэн хууль зөрчсөн асуудал гэж өмнө нь 2005 онд Үндсэн хуулийн цэцээр ороод тэр нь хуучин 80 мянган төгрөг гэсэн хязгаарлалт байсан юм. Тэрийг нь хүчингүй болгоод хүмүүс хязгаарлалтгүйгээр тэтгэврээ авч байсан байхгүй юу. Тэгээд саяын тэр 2023 оны Засгийн газрын тогтоолоор тэр бараг 10-аад жилийн өмнө мөрдөгдөж байсан хязгааруудыг тавиад тэгээд тэр тайралт хийсэн учраас тэр авах ёстой тэтгэврээ авч чадаагүй ахмадууд гомдолгүй яах вэ. Энэ бараг тэр доод хэмжээгээр өсөхөөс илүү олон зуун ахмадуудын гомдолтой холбоотой асуудал.

Тэгээд энэ Ахмадын холбоонд маш олон өргөдөл ирсэн. Энэ чиглэлээр Монголын ахмадын холбоо тавьж байгаа асуудлыг дэмжиж, хамтарч ажиллаж шийдвэр гаргахад биечлэн тусалж ажиллая гэсэн бодолтой байна. Баярлалаа.

О.Номинчимэг: Тэгэхээр ажлын хэсгийн ахлагчаар Рэгдэл гуай, гишүүдээр Замира гишүүн, Мөнхбаясгалан гишүүн, Саранчулуун гишүүн, Эрдэнэбат гишүүд орсон байна. Ахмадуудын тэтгэвэртэй холбоотой бас ийм багц асуудал байгаа учраас.

Ингээд Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж дууссан. Ингээд санал хураалтад бэлдье.

Ажлын хэсэгт Бадамдоржийн Пунсалмаа гишүүн бас нэмэгдэж орох хүслээ илэрхийлсэн учраас протокол нэмээд тогтоолын төсөлд тусгая. Гишүүд санал хураалтад бэлдье.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

Рэгдэл гишүүн горимын санал уу?

Д.Рэгдэл: Миний аппарат бас болж өгсөнгүй. Улайгаад болдоггүй. Тийм учраас энэ санал хураалтыг хүчингүй болгоод дахиж санал хураалгах санал оруулж байна.

О.Номинчимэг: Рэгдэл гишүүний горимын саналаар санал хурааа. Рэгдэл гишүүний одоо ажиллаж байна уу? Рэгдэл гишүүний горимын саналаар санал хураалт.

57.1 хувиар Рэгдэл гишүүний гаргасан горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн учраас “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт.

57.1 буюу нийт 14 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, Байнгын хорооны тогтоолын төслийг баталлаа.

Ингээд өнөөдрийн Байнгын хороогоор хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүддээ баярлалаа.

14.29 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР